



НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН
ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ
2023-2027



Хамтын ажиллагааны хүрээ

МОНГОЛ УЛС



НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ
БАЙГУУЛЛАГА
МОНГОЛ УЛС



НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН
ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ
2023-2027

МОНГОЛ УЛС

2022 оны 5 дугаар сар






НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН
ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН
ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ



НУБ-ЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ 2023-2027

© НУБ 2022 он

Холбоо барих:

-  Нэгдсэн Үндэстний Байгууллага
Нэгдсэн Үндэстний гудамж-14, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14201
-  unmongolia
-  unmongolia
-  <https://mongolia.un.org>
-  +976-11-327585



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР



НЭГДСЭН
ҮНДЭСТНИЙ
БАЙГУУЛЛАГА
МОНГОЛ УЛС

ХАМТРАН АЖИЛЛАХ ТУХАЙ БАТЛАМЖ

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгасан үндэсний хөгжлийн тэргүүлэх чиглэлүүд, Тогтвортой хөгжлийн зорилгууд болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хөгжлийн болон хүний эрхийн бусад зорилт, үүрэг амлалтыг биелүүлэхэд Монгол Улсын Засгийн газар болон Нэгдсэн Үндэстний Байгууллага хамтран ажиллахаа илэрхийлж байна.

Бид өнгөрсөн амжилтдаа тулгуурлаж, 2023-2027 онд хэрэгжүүлэх хамтын ажиллагааны чиглэлээ “НҮБ-ын Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээ 2023-2027” баримт бичигт тусгалаа. Бидний хамтын ажиллагаа Монгол Улсыг хүртээмжтэй, гамшигт тэсвэртэй, тогтвортой хөгжил бүхий эрүүл, аюулгүй орчинтой, хууль дээдлэх ёс болон хүний эрхийн харилцан шүтэлцээг хангасан улс болон хөгжихөд хувь нэмрээ оруулах болно.

Талууд “НҮБ-ын Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээ 2023-2027” баримт бичигт гарын үсэг зурж, баталгаажуулснаар түүнд тодорхойлсон үр дүнд хүрэх хамтын үүрэг хариуцлагаа батламжилж байна.

Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж:

Гарын үсэг

Батмөнхийн Батцэцэг
Гадаад харилцааны сайд

Огноо:

2022-05-20

Гарын үсэг

Болдын Жавхлан
Эдийн засаг, хөгжлийн
сайдын үүрэг хариуцагч

Огноо:

May 22, 2022

Нэгдсэн Үндэстний Байгууллагыг төлөөлж:

Гарын үсэг

Тапан Мишра
Монгол Улс дахь НҮБ-ын
Суурин зохицуулагч

Огноо:

20th May 2022.



**Food and Agriculture
Organization of the
United Nations**

Винод Ахужа
НҮБ-ын ХХААБ-ын
Монгол Улс дахь Суурин
төлөөлөгч



Хюберт Бойрард
ХААХОУС-гийн
Пакистан, Иран, Монгол
Улсыг хариуцсан захирал



**International
Labour
Organization**

Чанхи Ли
ОУХБ-ын БНХАУ, Монгол
Улсыг хариуцсан товчооны
захирал



Жьюзеппе Крочетти
ОУШХБ-ын БНХАУ болон
Монгол Улс дахь салбарын
тэргүүн



**International
Trade
Centre**

Ашиш Шах
ОУХТ-ийн Улс орнуудын
хөтөлбөр хариуцсан
захирал



Ацуро Окуда
ОУЦХБ-ын Ази, Номхон
далайн бүс нутаг хариуцсан
захирал



**UNITED NATIONS
HUMAN RIGHTS
OFFICE OF THE HIGH COMMISSIONER**

Рори Мунговен
НҮБ-ын ХЭДКГ-ын Ази,
Номхон далайн бүс нутаг
хариуцсан нэгжийн дарга



Таоуфик Баккали
НҮБ-ын ДОХ-ын нэгдсэн
хөтөлбөрийн Ази, Номхон
далайн бүс нутаг хариуцсан
захирлын үүрэг хариуцагч



Изабелла Дурант*
НҮБ-ын Худалдаа,
хөгжлийн бага хурлын
орлогч нарийн бичгийн
дарга



Илейн М. Конкиевич
НҮБ-ын Хөгжлийн
хөтөлбөрийн Монгол Улс
дахь Суурин төлөөлөгч



Марко Тоскано-Ривалта
НҮБ-ын ГЭББ-ын Ази,
Номхон далайн бүсийн
газрын дарга



Дечэн Церинг
НҮБ-ын БОХ-ийн Ази,
Номхон далайн бүсийн
захирал, төлөөлөгч

*НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурлын орлогч нарийн бичгийн даргын шилжүүлсэн эрх хэмжээний хүрээнд НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурлыг Монгол Улс дахь НҮБ-ын Суурин зохицуулагч төлөөлж гарын үсэг зурав.



Баттү

Баасанжавын Ганболд
НҮБ-ын АНДЭЗНК-ын
Зүүн, Зүүн-Хойд Азийн
газрын захирал



Shan

Шахбаз Хан
НҮБ-ын БШУСБ-ын
БНАСАУ, БНХАУ, Япон Улс,
Монгол Улс, БНСУ дахь
төлөөлөгч, Бээжин дэх
төлөөлөгчийн газрын
захирал



Arshon

Халид Шарифи
НҮБ-ын Хүн амын сангийн
Монгол Улс дахь тэргүүн



Shirley

Ацуши Корисава
НҮБ-ын Хабитатын Ази,
Номхон далайн бүсийн
салбарын захирал



Stephy

**Эваристе
Коуасси-Комлан**
НҮБ-ын Хүүхдийн
сангийн Монгол Улс дахь
Суурин төлөөлөгч



Stiven

Стивен Б. Каргбо
НҮБ-ын Аж үйлдвэр
хөгжлийн байгууллагын
БНХАУ, БНАСАУ болон
Монгол Улс дахь төлөөлөгч,
БНХАУ дахь бүс нутгийн
газрын тэргүүн



Jeremi

Жерми Дуглас
НҮБ-ын МБГХТА-ны
Зүүн өмнөд Ази, Номхон
далайн бүс нутаг хариуцсан
төлөөлөгч



S. Kadwani

Самина Кадвани
НҮБ-ын ТҮА-ны улс
орнууд хариуцсан газрын
захирал



D. Frimuz

Дмитрий Фришин
НҮБ-ын СДХ-ийн Ази,
Номхон далайн бүс нутгийн
газрын даргын үүрэг
хариуцагч



S. L. Ky

Сара Книббс
НҮБ-ын Эмэгтэйчүүдийн
байгууллагын Ази, Номхон
далайн бүс нутгийн газрын
даргын үүрэг хариуцагч



Sergey

Сергей Диордица
ДЭМБ-ын Монгол Улс дахь
Суурин төлөөлөгч

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

БЖДҮ	Бичил болон жижиг, дунд үйлдвэрүүд
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НҮБ-ын АНДЭЗНК	НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс
НҮБ-ын АҮХБ	НҮБ-ын Аж үйлдвэр хөгжлийн байгууллага
НҮБ-ын БОХ	НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр
НҮБ-ын БШУСБ	НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага
НҮБ-ын ГЭББ	НҮБ-ын Гамшгийн эрсдлийг бууруулах байгууллага
НҮБ-ын ДОХ-ын НХ	НҮБ-ын ДОХ-ын нэгдсэн хөтөлбөр
НҮБ-ын МБГХТА	НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба
НҮБ-ын СДХ	НҮБ-ын Сайн дурын хөтөлбөр
НҮБ-ын ТҮА	НҮБ-ын Төслийн үйлчилгээний алба
НҮБ-ын Хабитат	НҮБ-ын Хүн амын суурьшлын хөтөлбөр
НҮБ-ын ХАС	НҮБ-ын Хүн амын сан
НҮБ-ын ХС	НҮБ-ын Хүүхдийн сан
НҮБ-ын ХТХ	НҮБ-ын хөгжлийн тусламжийн хүрээ
НҮБ-ын ХХ	НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр
НҮБ-ын ХХААБ	НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага
НҮБ-ын ХХЧ	НҮБ-ын Худалдаа, хөгжлийн чуулган
НҮБ-ын ХЭДКГ	НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газар
НҮБ-ын Эмэгтэйчүүд	НҮБ-ын Жендэрийн тэгш байдал ба эмэгтэйчүүдийг чадавхжуулах байгууллага
ОУСБ	Олон улсын санхүүгийн байгууллага
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
ОУХТ	Олон улсын худалдааны төв
ОУЦХБ	Олон улсын цахилгаан холбооны байгууллага
ОУШХБ	Олон улсын шилжих хөдөлгөөний байгууллага
ОХУ	Оросын Холбооны Улс
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилгууд
ТХҮЗ	Тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөл
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХААХОУС	Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сан
ХАТ	Хамтарсан ажлын төлөвлөгөө
ХУХ	Хамтарсан удирдах хороо
ХШҮС	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, сургалт
ХШҮСБ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, сургалтын баг
ХЭҮК	Хүний эрхийн Үндэсний Комисс

АГУУЛГА

Хураангуй тойм	2
БҮЛЭГ 1: ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН 2030 ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ	6
1.1 Нөхцөл байдал	7
1.2 Тогтвортой хөгжлийн үндэсний алсын хараа	8
1.3 ТХЗ-ын хэрэгжилт	10
1.4 Сорилт, боломж	13
1.5 Хүний эрхийн талаарх олон улсын үүрэг амлалт	16
1.6 Хэнийг ч орхигдуулахгүй байх зарчим	18
БҮЛЭГ 2: ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН 2030 ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД НҮБ-ЫН ХӨГЖЛИЙН СИСТЕМЭЭС ҮЗҮҮЛЖ БҮЙ ДЭМЖЛЭГ	20
2.1 Өөрчлөлтийн ерөнхий онол	21
2.2 НҮБ-ын Хөгжлийн системийн стратегийн тэргүүлэх чиглэлүүд	27
2.3 Хамтын ажиллагааны хүрээнд дэвшүүлж буй үр дүнгийн зорилтууд, түншлэл	34
2.4 Хамтын ажиллагааны хүрээний үр дүнгийн зорилтуудын уялдаа	51
2.5 Тогтвортой байдал	52
2.6 Хил дамнасан болон бүс нутгийн хамтын ажиллагаа	53
2.7 НҮБ-ын Удирдлагын багийн харьцангуй давуу тал, зохицуулалт	55
БҮЛЭГ 3: ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ	57
3.1 Засаглал	58
3.1.1 Ерөнхий зохицуулалт	58
3.1.2 Хамтарсан удирдах хороо	58
3.2 Хамтын ажиллагааны хүрээний удирдлагын бүтэц	59
3.2.1 НҮБ-ын Удирдлагын баг	59
3.2.2 Үр дүнгийн бүлгүүд	60
3.2.3 НҮБ-ын Сэдэвчилсэн багууд болон Хөтөлбөрийг дэмжих багууд	62
3.3 Хамтын ажиллагааны хүрээний санхүүжилт	66
3.4 Хамтарсан Ажлын төлөвлөгөө	67
3.5 Бизнесийн үйл ажиллагааны стратеги	67
БҮЛЭГ 4: ТӨЛӨВ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭГ БАЯЖУУЛЖ ШИНЭЧЛЭХ БА ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	68
4.1 Хамтарсан ажлын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх	69
4.2 Эрсдэл болон боломжуудад хяналт-шинжилгээ хийх нь	71
4.3 Жилийн гүйцэтгэлийн үнэлгээ, үр дүнгийн тайлан	71
4.4 Үнэлгээ хийх төлөвлөгөө	72
Хавсралт 1: Хамтын ажиллагааны хүрээний Үр дүнгийн матриц	73
Хавсралт 2: Хамтын ажиллагааны хүрээний эрх зүйн зохицуулалт	89
Хавсралт 3: Хөтөлбөр, эрсдэлийн удирдлага	92

Хураангуй тойм

Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-аас Монгол Улсад 2023-2027 онд хэрэгжүүлэх “Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээ” баримт бичиг нь Монгол Улсын Засгийн газар болон НҮБ хамтран ойрын таван жилийн хугацаанд хэрэгжүүлэх хамтын ажиллагааны стратеги, төлөвлөлтийн нэгдсэн хүрээг тодорхойлно. Монгол Улсын Засгийн газар, УИХ, иргэний нийгэм, хувийн хэвшил, хөгжлийн түншүүд, НҮБ-ын систем зэрэг олон талын төлөөлөл энэхүү баримт бичгийн төсөл боловсруулах үйл явцад идэвхтэй оролцож, харилцан зөвлөлдсөн болно. Хамтын ажиллагааны хүрээний тэргүүлэх чиглэлийг тодорхойлоход цуврал хэлбэрээр зохион байгуулсан хэлэлцүүлгүүд чухал хувь нэмэр болов.

Энэхүү баримт бичгийг “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөр” болон хүний эрхийг хамгаалах хүрээнд олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүрэг амлалтаа хэрэгжүүлэхэд чиглэсэн үндэсний хөгжлийн хөтөлбөрүүдтэй нягт уялдуулав. Монгол Улс “Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөр”-ийг тууштай хэрэгжүүлэхийг зорьж буйн зэрэгцээ НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын Тогтвортой хөгжлийн зорилгууд (ТХЗ)-ын хэрэгжилтийг эрчимжүүлэх “Үйл ажиллагааны арван жил”-ийн уриалгыг бүрэн дэмжиж байна. Түүнчлэн Засгийн газрын түвшинд Тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөл (ТХҮЗ), УИХ-ын түвшинд Тогтвортой хөгжлийн олон талт хамтын ажиллагааны зөвлөл (ТХОТЗ)-ийг байгуулж, ТХЗ-ын хэрэгжилтэд хяналт тавих, үндэсний хөгжлийн төлөвлөлтийг тогтвортой хөгжлийн бодлоготой уялдуулах институцийн механизмыг бий болгов.

Тогтвортой хөгжлийн тулгуур болох эдийн засаг, нийгэм, байгаль орчин хэмээх гурван чиглэлд Монгол Улс томоохон ахиц дэвшил гаргасаар байна. Тухайлбал, эдийн засгийн хурдацтай өсөлтийг бий болгож, эрүүл мэнд,

боловсрол, нийгмийн хамгааллын салбарт ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд мэдэгдэхүйц ололт амжилт гаргав. Монгол Улс өнөөгийн байдлаар дундаж орлоготой орнуудын бүлэгт багтаж, хүний хөгжлийн индекс нь 0.737 (2019)-д хүрч, хүний хөгжил өндөр орнуудын ангилалд байна. Монгол Улс парламентын засаглалтай ардчилсан орон бөгөөд чөлөөт, шударга сонгуулийг тогтмол явуулдаг. Мөн эрх зүйт ёс, хүний эрхийг хамгаалах ардчилсан институци, хууль эрх зүйн орчин бүрдсэн, хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн үйл ажиллагаа харьцангуй чөлөөтэй улс юм.

“Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн үндэсний сайн дурын илтгэл, НҮБ-аас Монгол Улсын хөгжлийн төлөв байдалд хийсэн дүн шинжилгээ, стратегийн тэргүүлэх чиглэл тодорхойлох хэлэлцүүлэг уулзалтуудаас харахад тус улсад хөгжлийн сорилтууд тулгарсан хэвээр байна. Монгол Улс эрдэс баялаг, нүүрсний экспортоос ихээхэн хамааралтай байгаа нь эдийн засгийг эмзэг, түүхий эдийн үнийн хэлбэлзэлд өртөмтгий болгож байна. Эдийн засгийн өсөлт хурдацтай байсан хэдий ч хэлбэлзэл ихтэй, төрөлжиж чадаагүй төдийгүй ядуурлыг бууруулах, ажлын байр бий болгоход дорвитой хувь нэмэр болж чадахгүй байна. Бодлого боловсруулах үйл явц тэр бүр нотолгоонд суурилж чадахгүй, уялдаа холбоо сул байгаагийн зэрэгцээ засаглалын байгууллагуудад хариуцлагын тогтолцоо, ил тод байдал төдийлөн сайн бус байна. Шилжилт хөдөлгөөний зохицуулалт ч сул байна. Уур амьсгалын өөрчлөлт, агаарын бохирдлын асуудал Монгол Улсын тогтвортой хөгжилд заналхийлж буй гол хүчин зүйл болж, хүний нөөцийн хөрөнгө оруулалтын чанар, хүртээмж (эрүүл мэнд, хоол тэжээл, боловсрол, ур чадвар, нийгмийн хамгаалал) тэгш бус байна. Нийгмийн үйлчилгээний хүртээмжид ахиц дэвшил гарч байгаа хэдий ч хүн амын олон бүлэг орхигдсон буюу орхигдох эрсдэлтэй хэвээр байна.



КОВИД-19 цар тахлын тархалт эмзэг бүлгийн иргэдэд хэдийн тулгарч байсан сорилт бэрхшээлийг улам сэдрээж, эмзэг байдлыг нэмэгдүүлж байгаа нь ялангуяа эмзэг бүлгийн эмэгтэй, эрэгтэй хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, үндэстний цөөнх, гэр хорооллын оршин суугчид, албан бус хөдөлмөр эрхлэгчид, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид, бүртгэлгүй дотоодын шилжин суурьшигчид зэрэг хүн амын бусад бүлэгт хүнд сорилт болж байна.

Монгол Улс дээрх сорилтуудыг шийдвэрлэхийн тулд уялдаа холбоотой, нэгдсэн, нотолгоонд суурилсан байх зарчмыг бодлого, шийдвэр гаргах үйл ажиллагаандаа мөрдөн хэрэгжүүлэх; эдийн засаг, институци, экосистем, хүн амыг аливаа хямрал цочролд (эдийн засаг, байгаль орчин, цар тахал) бэлтгэлтэй, тэсвэртэй болгох; эдийн засгийг байгаль орчинд ээлтэйгээр төрөлжүүлэх; засаглалын байгууллагуудыг ил тод, хариуцлагатай, оролцоотой болгох; эмзэг бүлгийн хүн амын бүлгүүдэд тулгарч буй жендэрийн болон нийгмийн бусад бүх хэлбэрийн тэгш бус байдлыг арилгах замаар “хэнийг ч орхигдуулахгүй байх”-д ахиц дэвшил гаргах нэн шаардлагатай байна.

Эдгээрийг шийдвэрлэхэд шаардагдах хөрөнгө нөөцийг дайчлахын тулд төсвийн хяналттай удирдлагыг хэрэгжүүлж, зарцуулалтын өгөөж, үр ашгийг сайжруулах, ТХЗ-тай уялдсан санхүүгийн арга хэрэгслийг ашиглах замаар хувийн хэвшлийн түншлэл, бүс нутаг, олон улсын болон Өмнөд-Өмнөдийн хамтын ажиллагааг өргөжүүлэн бэхжүүлэх хэрэгтэй байна.

Өнөөг хүртэл хүрсэн ахиц дэвшил, тулгарч буй хөгжлийн сорилтууд болон өөрчлөлтийн онолд үндэслэн энэхүү хамтын ажиллагааны хүрээг хэрэгжүүлэх гол арга зам нь “хэнийг ч орхигдуулахгүй байх” зарчим болохыг хүлээн зөвшөөрч, КОВИД-19 цар тахлын уршиг, сөрөг нөлөөллөөс түргэн ангижрахыг чухалчлан, Монгол Улсын Засгийн газар болон НҮБ хамтран доор дурдсан алсын хараа, стратегийн тэргүүлэх гурван чиглэл, үр дүнгийн дөрвөн зорилтыг тодорхойлов. Энэхүү алсын харааг оролцогч талуудтай зөвлөлдөн тодорхойлж, “Алсын хараа-2050” бодлогын баримт бичигт туссан үндэсний хөгжлийн тэргүүлэх зорилтууд, ТХЗ-той нягт уялдуулсан болно (2.2 дахь хэсэгт буй хүснэгтийг үзнэ үү).



СТРАТЕГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 1



Үр дүнгийн зорилт 1

2027 он гэхэд хот, хөдөөгийн иргэн бүр, ялангуяа нэн эмзэг болон орхигдох эрсдэлтэй хүн амын бүлгүүд өөрсдийн нөөц боломжийг бүрэн дүүрэн, эрх тэгш ашиглаж, хүний эрхэд суурилсан, хүртээмжтэй, жендэрийн мэдрэмжтэй, цочролд тэсвэртэй, эрүүл мэнд, хоол тэжээл, боловсрол, нийгмийн хамгаалал, ус, ариун цэврийн байгууламжийн болон бусад үйлчилгээний үр шимийг хүртэнэ.

СТРАТЕГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 2



Үр дүнгийн зорилт 2

2027 он гэхэд Монгол Улсын эдийн засаг илүү төрөлжсөн, шинэлэг, бүтээмжтэй, хүртээмжтэй, “ногоон” болж, бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг ханган, ялангуяа эмэгтэйчүүд, залуучуудын зохистой амьжиргааг тэтгэх, XXI зууны эрэлт хэрэгцээтэй ур чадварыг хөгжүүлэх, нүүрсхүчлийн хий бага ялгаруулах хөгжлийг дэмжинэ.

Үр дүнгийн зорилт 3

Нотолгоонд суурилсан, жендэрийн мэдрэмжтэй, байгалийн нөөц, байгаль орчны тогтвортой менежмент, гамшгийн эрсдэлийг бууруулах чадавх сайжирснаар 2027 он гэхэд Монгол Улсын хүн ам, экосистем уур амьсгалын өөрчлөлтөд илүү тэсвэртэй болсон байна.

СТРАТЕГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 3



Үр дүнгийн зорилт 4

2027 он гэхэд Монгол Улсын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл явц жендэрийн мэдрэмжтэй, оролцоог хангасан, харилцан уялдаатай, нотолгоонд суурилсан, ТХЗ-той уялдсан, бүх шатны засаглалын байгууллагууд ил тод, хариуцлагатай ажиллаж, хүний эрхийг бүрэн хангаж хамгаалсан, тэгш шударга, эрх зүйт ёсыг хүн бүр, ялангуяа орхигдох эрсдэлтэй хүн амын бүлгүүд ялгаваргүй эдлэх боломж нөхцөл бүрдсэн байна.

Монгол Улс дахь НҮБ-ын систем нь эдгээр стратегийн тэргүүлэх гурван чиглэлийн хүрээнд дэвшүүлсэн үр дүнгийн дөрвөн зорилтыг хэрэгжүүлэхийн тулд техникийн туслалцаа үзүүлэх, чадавх бэхжүүлэх, шинэлэг туршилтын төслүүд хэрэгжүүлэх, бодлогын зөвлөгөө өгөх, түншлэлийг өргөжүүлэх, хөгжлийн санхүүжилтийг идэвхжүүлэх, бусад талын идэвх, оролцоог нэмэгдүүлэх зэргээр хувь нэмэр оруулах болно. Энэхүү хамтын ажиллагааны хүрээг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор НҮБ-ын Удирдлагын баг юуны түрүүнд өөрийн бизнесийн загвар, НҮБ-ын системийн байгууллагуудын чадавх зэрэгт үнэлгээ, зохицуулалт хийсэн болно. Монгол Улс дахь НҮБ-ын систем нь мэдлэг туршлагадаа тулгуурлан, нийгэм, эдийн засаг, байгаль орчны хөгжлийг дэмжих, “хэнийг ч орхигдуулахгүй байх” зарчмыг чандлан мөрдөж, жендэрийн эрх тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх, тогтвортой байдал, хариуцлагын тогтолцоо, эрсдэл даах чадварыг бий болгох зорилтыг мэдээлэл, нотолгоо, хүний эрхэд суурилан хөгжих хандлагын зарчмаар, ТХЗ-ын хэрэгжилтийг эрчимжүүлэх замаар хэрэгжүүлж хувь нэмрээ оруулна. Монгол Улсын хөгжилд бүс нутгийн хамтын ажиллагаа нэн чухал үүрэгтэй гэж үзэн бүс нутгийн мэдлэг туршлага, хөрөнгө нөөц, хөтөлбөрүүдээс үр өгөөж хүртэх, үндэсний хувь нэмэр оруулах боломжийг бүрдүүлэх

зорилгоор бүс нутгийн институцүүдтэй хамтран ажиллахад НҮБ-аас дэмжлэг үзүүлнэ.

Хамтын ажиллагааны хүрээ баримт бичгийн хэрэгжилтийг Монгол Улсын Гадаад харилцааны яам (Засгийн газрын зохицуулах байгууллага)-ны зохицуулалт дор Гадаад харилцааны сайд, НҮБ-ын Монгол Улс дахь Суурин зохицуулагч нарын даргалж шийдвэр гаргах, хяналт тавих эрх бүхий Хамтарсан удирдах хороо (ХУХ) удирдан хэрэгжүүлнэ. ХУХ нь хамтын ажиллагааны хүрээг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлт, үр дүнд үнэлэлт дүгнэлт өгч ажиллах ба шаардлагатай тохиолдолд зохих өөрчлөлт оруулах эрхтэй.

Монгол Улсын Засгийн газар, НҮБ хоорондын харилцааг энэхүү баримт бичгийн хавсралтад туссан эрх зүйн заалтуудаар зохицуулна. Хамтын ажиллагааны хүрээг Хамтарсан ажлын төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж, хөтөлбөрийн туршид мөрдөх Хяналт шинжилгээ, үнэлгээ, сургалтын төлөвлөгөөний дагуу биелэлтэд байнгын хяналт тавина. НҮБ-ын Удирдлагын багийн удирдлага дор тухайн үр дүнг хариуцсан бүлгүүд, сэдэвчилсэн болон НҮБ-ын хөтөлбөрийг дэмжих ажлын багууд хэрэгжилтийг дэмжиж ажиллана. Хамтын ажиллагааны хүрээ баримт бичгийн хэрэгжилтэд хамрах хугацааны төгсгөлийн жилийн өмнөх жилд багтаан хараат бус эцсийн үнэлгээ хийлгэнэ.



Алтайн уулсын бэл дэх малчны хот. Зургийг Ч. Батзаяа

1.1 Нөхцөл байдал

Монгол Улсын хувьд тогтвортой хөгжлийн тулгуур болох эдийн засаг, нийгэм, байгаль орчин хэмээх гурван чиглэлд КОВИД-19 цар тахлаас өмнө томоохон ахиц дэвшил гараад байв. Эдийн засгийн хурдацтай өсөлтийг бий болгож, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбарт ТХЗ-ын хэрэгжилтийг хангахад мэдэгдэхүйц ололт амжилт гарч, хүн амын дийлэнх хэсгийн амьдралын нөхцөл байдал сайжирч байсан. Өнөөгийн байдлаар Монгол Улс дэлхийн дундаж орлоготой орнуудын бүлэгт багтаж, хүний хөгжлийн индекс 0.737 (2019)-д хүрч, хүний хөгжил өндөртэй орнуудын ангилалд хамаарч байна. Монгол Улс парламентын засаглалтай ардчилсан орон бөгөөд шударга, чөлөөт сонгуулийг тогтмол явуулж ирсэн. Эрх зүйт ёсыг дээдлэх, хүний эрхийг хамгаалах ардчилсан институци, хууль эрх зүйн орчин бүрдсэн бөгөөд хэвлэл мэдээлэл, иргэний нийгэм харьцангуй чөлөөтэй хөгжиж буй орон юм. Монгол Улс хүний эрхийн механизмуудтай идэвхтэй хамтран ажиллаж, хүний эрх, хөдөлмөрлөх эрх, байгаль орчны асуудлаарх олон талт гэрээ хэлэлцээрт нэгдэн орсон. Коронавирусын халдвар авсан хүний тоо, эндэгдлийн түвшин, цар тахалтай тэмцэх хүрээнд 2020-2021 онд хэрэгжүүлсэн тусламжийн хөтөлбөрүүд, хүн амыг вакцинжуулалтад идэвхтэй хамруулсан зэрэг үзүүлэлт нь КОВИД-19 цар тахлын эсрэг Монгол Улсын авч хэрэгжүүлсэн арга хэмжээ онцгой үр дүнтэй байсныг илэрхийлж байна.

“Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн үндэсний сайн дурын илтгэл, НҮБ-аас тус улсын хөгжлийн төлөв байдалд хийсэн дүн шинжилгээ, стратегийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох хэлэлцүүлэг уулзалтуудаас харахад Монгол Улсад хөгжлийн сорилтууд тулгарсан хэвээр байна. Тус улс эрдэс баялаг, нүүрсний экспортоос ихээхэн хамааралтай байгаа нь эдийн засгийг эмзэг, түүхий эдийн үнийн хэлбэлзэлд хэт өртөмтгий болгож байна. Эдийн засгийн өсөлт хурдацтай хэдий ч хэлбэлзэл ихтэй байсан нь ядуурлыг бууруулах, ажлын байр бий болгоход дорвитой хувь нэмэр оруулж чадаагүй. Нийт хүн амын бараг дөрөвний нэг



Цаатан охин. Зургийг Ч. Батзаяа

орчим хувь нь ядуу, эмзэг нөхцөлд амьдарсан хэвээр, хүнсний аюулгүй байдал алдагдсан, эмзэг бүлгийн дийлэнх хүн амд нийгмийн суурь үйлчилгээ авах боломж хязгаарлагдмал хэвээр байгаагийн зэрэгцээ хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа мөн их байна. Эдийн засгийн төрөлжилт хязгаарлагдмал, эдийн засгийн албан бус хэлбэр нийтлэг оршсоор байна. Монгол Улсын нийт өрийн хэмжээ харьцангуй өндөр¹ төдийгүй улам өссөөр байгаагийн зэрэгцээ төсвийн бодлого оновчгүй байна. Авлига, төрийн байгууллагуудын бодлогын уялдаа холбоо, зохицуулалт хангалтгүй, хариуцлагын тогтолцоо, институцийн болон хүний нөөцийн чадавх сул байгаа нь засаглалын тулгамдсан асуудал болж байна.

¹ ОУВС-гийн Дүрмийн IV заалтын зөвлөлдөх уулзалтаар Монгол Улсын төсөв, санхүүгийн зорилтот бус олон арга хэмжээ, өсөн нэмэгдэж буй өрийн дарамт нь тус улсын макро санхүүгийн эмзэг байдлыг улам бүр нэмэгдүүлж байгааг тэмдэглэсэн. Нөгөө талаас, Монгол Улс нь сүүлийн жилүүдэд КОВИД-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээнд ихээхэн анхаарал хандуулж байгаа нь Тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэх талаар тус улсаас олон улсын өмнө хүлээсэн үүрэг амлалтаа биелүүлэх, хамтарсан санхүүжилт хийх зэрэгт нь сөргөөр нөлөөлж байна.

Мөн уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтол, хөдөө, орон нутгаас хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөнөөс үүдэлтэй өргөжин тэлж буй хяналт муутай хотжилт зэрэг нь тогтвортой хөгжилд илүү олон сорилт бэрхшээлийг бий болгож байна. Түүнчлэн агаарын бохирдол хүн амын эрүүл мэндэд ноцтойгоор нөлөөлж, халдварт бус өвчний тархалт нэмэгдэхэд хүргэж байна. Хүний нөөцөд чиглэсэн хөрөнгө оруулалтын чанар, хүртээмж (эрүүл мэнд, хоол тэжээл, боловсрол, ур чадвар, нийгмийн хамгаалал) тэгш бус байна. Нийгмийн үйлчилгээний хүртээмжид ахиц дэвшил гарч байгаа ч хүн амын тодорхой бүлгүүд орхигдож байгаа буюу орхигдох эрсдэлтэй хэвээр байна. КОВИД-19 цар тахлын тархалт эмзэг бүлгийн иргэдэд хэдийн тулгарч байсан сорилт бэрхшээлийг улам сэдрээж, эмзэг байдлыг улам хүндрүүлж байгаа нь ялангуяа эмзэг бүлгийн эмэгтэй, эрэгтэй хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй

иргэд, үндэстний цөөнх, гэр хорооллын оршин суугчид, албан бус хөдөлмөр эрхлэгчид, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид, бүртгэлгүй дотоодын шилжин суурьшигчид зэрэг хүн амын бусад бүлэгт хүнд сорилт болж байна. Тэдний дийлэнх нь хавсарсан сорилт бэрхшээлүүдтэй тулгарч байна. Мөн Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ)-тай хиллэдэг хилийн боомтууд хаагдсан нь бараа бүтээгдэхүүний импортын урсгалд ноцтой нөлөөлж, тээврийн зардал огцом нэмэгдсэнээр инфляцын түвшин 2021 оны эцэст 14 хувьд хүрсэн нь хүн амын ядуу хэсэгт хүнд цохилт болж байна. Монгол Улс нийт түлш шатахууныхаа 90 хувийг Оросын Холбооны Улс (ОХУ)-аас импортолж байгаа нь үнэ болон инфляцын өсөлтөд нөлөөлөөд зогсохгүй өрийн дарамт болон ТХЗ-ын санхүүжилтийн зардал нэмэгдэх эрсдэлийг бий болгож байна.

1.2 Тогтвортой хөгжлийн үндэсний алсын хараа

Монгол Улс “Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөр”-ийг баталсан анхдагч улсуудын нэг. НҮБ-ын Ерөнхий Ассамблей 2015 онд ТХЗ-ыг баталсны дараа буюу 2016 оны 2 дугаар сард Монгол Улсын Их Хурал урт хугацааны хөгжлийн стратегийн бодлого “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ыг баталсан. Улмаар уг баримт бичгийг сайжруулан, “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулж, Улсын Их Хурал 2020 оны 5 дугаар сард баталснаар Монгол Улс ирэх 30 жилийн хөгжлийн стратегийн шинэ чиг хандлагаа тодорхойлсон болно.

Монгол Улс хэтийн зорилгоо “2050 он гэхэд нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлт, иргэдийн амьдралын чанараар Азид тэргүүлэгч орнуудын нэг болно” (“Алсын хараа-2050” баримт бичиг) гэж тодорхойлсон. “Алсын хараа-2050” баримт бичиг нь ТХЗ-той уялдсан урт хугацааны хөгжлийн бодлогын есөн зорилгыг² дэвшүүлсэн бөгөөд Монгол Улс нь “үндэс язгуур, төрт ёс, өв соёлоо дээдэлж, үндэсний нэгдмэл үнэт зүйлээ эрхэмлэж, хүн төрөлхтний дэвшилтэт ололтыг дэмжиж, хөрст дэлхий, унаган байгалиа хамгаалж, амар тайван, хүмүүнлэг нийгмийг цогцлоож, ардчилал, шударга ёсны засаглалыг



бэхжүүлж, өөрийгөө тэтгэсэн эдийн засаг нь өрх, иргэн бүрт тэгш, хүртээмжтэй хүрсэн, эрүүл чийрэг, боловсролтой, эх оронч, хөрвөх чадвартай, оюунлаг, бүтээлч иргэнтэй улс болж хөгжинө” хэмээн заасан.

² Үүнд: 1. Үндэсний нэгдмэл үнэт зүйл; 2. Хүний хөгжил; 3. Амьдралын чанар, дундаж давхарга; 4. Эдийн засаг; 5. Сайн засаглал; 6. Ногоон хөгжил; 7. Нийгмийн амар амгалан, аюулгүй байдал; 8. Бүсчилсэн хөгжил; 9. Улаанбаатар болон дагуул хотууд зэрэг болно.



Тогтвортой хөгжлийн олон талт зөвлөлийн нээлтийн ажиллагаа. Төрийн ордон. 2022 оны 3 дугаар сарын 23
Зургийг НҮБ-ын Суурин зохицуулагчийн газар.

“Алсын хараа-2050” стратегийн зорилтууд 1/ 2020-2030 он; 2/ 2031-2040 он; 3/ 2041-2050 он гэсэн гурван үе шаттайгаар хэрэгжих ба 1 дүгээр үе шат нь НҮБ-аас зарласан ТХЗ-ын хэрэгжилтийг эрчимжүүлэх Үйл ажиллагааны арван жил болон “Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөр” хэрэгжих үетэй давхцаж байгаа ч Монгол Улс 2030 он гэхэд ТХЗ-ыг хэрэгжүүлэх үүрэг амлалтаа хэрхэн биелүүлэх стратегийн төлөвлөгөө нь хараахан тодорхойгүй байна. УИХ-аас 2020 оны 5 дугаар сард баталсан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн дагуу “Алсын хараа 2050” бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг 1) дунд хугацааны буюу 10 жилийн хөгжлийн 7 зорилтот хөтөлбөрүүд, 2) 5 жилийн үндсэн чиглэл, нэгдсэн бодлого, 3) богино хугацааны буюу Засгийн газрын үйл ажиллагааны 4 жилийн хөтөлбөр, 4) Улсын хөгжлийн жилийн нэгдсэн төлөвлөгөө бодлого, хөтөлбөрүүдээр дэмжиж хангана. Монгол Улс 2015 онд УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хорооны дэргэд ТХЗ-ын дэд хороог байгуулж, ТХЗ-ын хэрэгжилтэд хяналт тавих институцийн механизмыг бүрдүүлж, улмаар бүтцийн өөрчлөлт хийн, тус дэд хороог УИХ-ын Эдийн засгийн бодлогын байнгын хорооны харьяанд оруулсан. Монгол Улсын ТХЗ-ын хэрэгжилтэд хяналт тавих, эрчимжүүлэх, удирдлага зөвлөмжөөр хангах, шаардлагатай хөрөнгө нөөцийг дайчлах боломж бүрдүүлэх үүрэг бүхий Тогтвортой хөгжлийн олон талт хамтын ажиллагааны зөвлөлийг УИХ-ын Эдийн засгийн бодлогын байнгын хорооны дэргэдэх ТХЗ-ын дэд

хороогоор ахлуулан байгуулсан. Тус зөвлөлд төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд, НҮБ, ОУСБ, хөгжлийн түншүүд зэрэг олон талын төлөөлөл багтсан. Улс орны хэмжээнд ТХЗ-ын хэрэгжилтийн талаар шийдвэр гаргах эрх бүхий ТХҮЗ-ийн бүрэлдэхүүнийг Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар 2021 оны 1 дүгээр сард шинэчлэн баталсан. Ерөнхий сайдын тэргүүлдэг энэ Зөвлөлийн бүрэлдэхүүнд Монгол Улс дахь НҮБ-ын Суурин зохицуулагч нь олон улсын байгууллагын төлөөлөл болон орсон байна.

2019 онд НҮБ-ын Тогтвортой хөгжлийн асуудлаарх Улс төрийн өндөр түвшний чуулга уулзалтад танилцуулсан Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Үндэсний сайн дурын илтгэлд “Үндэсний болон орон нутгийн хөгжлийн бодлого, хөтөлбөр, төсвийн төлөвлөгөөнд ТХЗ-ыг нарийвчлан тусгаж байж тэдгээрийг хэрэгжүүлэх боломж бүрдэхийг цохон тэмдэглэсэн байдаг. Монгол Улс ТХЗ-ыг нутагшуулах үйл явцыг эхлүүлсэн хэдий ч тэдгээрийг үндэсний болон орон нутгийн хөгжлийн тэргүүлэх чиглэл, зорилтуудтай уялдуулах, богино, дунд хугацааны бодлогуудад тусган хэрэгжүүлэх, гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, тайлагналыг сайжруулах шаардлагатай хэвээр байна. Мөн ТХЗ-ын зөвлөлүүдийг орон нутагт (аймгийн төв, сумдад) байгуулсан нь ТХЗ-ыг хэрэгжүүлэх үйл хэргийг нэгдмэл зохион байгуулалттайгаар эрчимжүүлэх, нутагшуулах, улмаар ТХЗ-ыг биелүүлэхэд чухал хувь нэмэр оруулна.

1.3 ТХЗ-ын хэрэгжилт

Өнгөрсөн 2021 онд нийтлэгдсэн Дэлхийн Тогтвортой хөгжлийн тайлан³-ийн үзүүлэлтээр Монгол Улсын Тогтвортой хөгжлийн индекс 63.8 болж нийт 165 орноос 106-д эрэмбэлэгдсэн бөгөөд бүс нутгийн (Зүүн болон Өмнөд Ази) дунджаас доогуур байна. Монгол Улс ядуурлыг бууруулах, боловсролын чанарыг сайжруулахад чиглэсэн ТХЗ-ыг хэрэгжүүлэх талаар ахиц дэвшилтэй байгаа, жендэрийн эрх тэгш байдлыг хангах, эрүүл мэнд, зохистой хөдөлмөр, цэвэр эрчим хүч зэрэгт

чиглэсэн ТХЗ-ын хэрэгжилт дунд түвшинд, харин өлсгөлөнг арилгах, тогтвортой хот суурин газар, дэд бүтцийг хөгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах, хуурай газрын эко системийг хамгаалах, шударга ёс, институцийг хөгжүүлэхэд чиглэсэн ТХЗ-ын хэрэгжилт хоцрогдолтой байна. Нарийвчилсан задаргаатай тоо мэдээлэл дутмаг байгаа нь хүн амын зарим эмзэг хэсгийнхэнд чиглэсэн ТХЗ-ын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийхэд бэрхшээл учруулж байна.



Хүн [ТХЗ 1, 2, 3, 4, 5]

2010 онд 38.8 хувь байсан ядуурлын түвшин 2020 онд 27.8 хувь болж буурсан ч хот (26.5 хувь), хөдөө (30.5 хувь)-гийн ядуурлын түвшин эрс ялгаатай төдийгүй өрхийн ядуурлын түвшин эрхэлжбуй эдийн засгийн үйл ажиллагаа, хүүхдийн тооноос ихээхэн хамааралтай байна. 2016 онтой (29.6 хувь) харьцуулахад бага зэрэг буурсан ядуурлын түвшин цар тахлын дараа нэмэгдэх хандлагатай байгаа нь өмнө хүрсэн ахиц дэвшлээс ухарч болзошгүйг сануулж байна. Хүн амын нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамрагдалт харьцангуй өндөр, санхүүжилт сайжирч байгаа (зарим хэсэг нь ОУСБ-ын зээлийн санхүүжилттэй) нь сайшаалтай боловч нийгмийн хамгааллын үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлэх, үр нөлөөг сайжруулах, санхүүжилтийн тогтвортой байдлыг хангахад анхаарах шаардлага хэвээр байна [ТХЗ 1].

Тураалтай хүүхдийн эзлэх хувь 2000-2018 онд 24.6 хувиас 9.4 хувь болж буурсан боловч жингийн илүүдэлтэй хүүхдийн эзлэх хувь ядуу болон хот суурингийн хүн амын дунд нэмэгдэж байна. Гэр хороололд амьдарч байгаа, хөдөө орон нутгаас шилжин ирсэн өрхүүдийн хүнсний аюулгүй байдал алдагдах эрсдэл хамгийн өндөр байна [ТХЗ 2]. Монгол Улс өлсгөлөнг арилгах чиглэлд мэдэгдэхүйц ахиц дэвшилд хүрсэн хэдий ч хүн амын нэлээд хэсгийн хүнсний аюулгүй байдал асуудалтай хэвээр байгаа бөгөөд түүнийг сайжруулах талаар сүүлийн жилүүдэд тодорхой ахиц дэвшил гарахгүй байна.

Эрүүл мэндийн үзүүлэлтийн хувьд 1000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 2000 онд 42.4 байсан бол 2019 онд 16.1 болж, 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл 32.8-с 13.3 болж тус тус буурсан. 100,000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдэл 2000 онд 155 байсан бол 2017 онд 45 болон буурч, [ТХЗ-3]-ын зорилтыг хангажээ.

Нийгмийн эрүүл мэнд, ялангуяа хоол тэжээлийн байдалд тулгарч буй сорилтууд нэмэгдэж байна⁴. Түүнчлэн боловсролын чанарын үр дүн хүүхдийн нийт суралцсан хугацаатай дүйцэхгүй байна⁵. Сургуулийн өмнөх насны хүүхдийн боловсролын үйлчилгээнд ядуу өрхийн хүүхдийн 48 хувь, чинээлэг өрхийн хүүхдийн 69 хувь хамрагдсан нь ихээхэн ялгаа байгааг харуулж байна [ТХЗ 4]. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлд ахиц дэвшил гарч буй хэдий ч Улсын Их Хурлын эмэгтэй гишүүдийн эзлэх хувь (17.3 хувь) өсөхгүй байгаа төдийгүй энэ үзүүлэлт дэлхийн дунджаас доогуур хэвээр байна. Эрэгтэйчүүдтэй (8 хувь) харьцуулахад эмэгтэйчүүд гэр орны хөлсгүй ажил, халамж асаргаанд илүү их цагийг (19.1 хувь) зарцуулж байна⁶. Ялангуяа КОВИД-19 цар тахлын үед жендэрт суурилсан хүчирхийлэл, хүн худалдаалах гэмт хэрэг, охид, эмэгтэйчүүдийн эсрэг бэлгийн мөлжлөгийн тохиолдлууд нэмэгдэж, эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин буурсан зэрэг сэтгэл түгшээсэн олон асуудал тулгамдаж байна [ТХЗ 5].

³ Ж. Сачс, С. Кролл, Ж. Лафортүне, Г. Фүллэр, Ф. Воел. (2021). Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийг эрчимжүүлэх "Үйл ажиллагааны 10 жил": Тогтвортой хөгжлийн тайлан 2021. Кембриджийн их сургуулийн нийтлэл

⁴ 2016 онд Монгол Улс нь хүн амын нас баралтын эрсдэлт хүчин зүйлүүдийн нэг болох зүрх судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтын хэмжээгээр дэлхийд хоёрдугаарт эрэмбэлэгдэхээр тооцоо гарчээ. Энэ нь тус улсын хүн амын малын гаралтай хүнсний бүтээгдэхүүний уламжлалт хэрэглээтэй холбоотойн зэрэгцээ хоол тэжээлийн төрөл цөөн, хүнсний бүтээгдэхүүний хэрэглээ өсөн нэмэгдэхийн хэрээр боловсруулсан цардуул, элсэн чихэр, өөх тос, боловсруулсан хүнсний бүтээгдэхүүний хэрэглээ өндөр, хөдөө аж ахуйн салбарын хөгжил сул зэргээс шалтгаалж байна. Ерөнхийдөө хүнсний үйлдвэрлэлийн тогтвортой тогтолцоонд шилжихийн тулд технологийн шинэчлэл хийх, эдийн засгийн хөшүүргийг стратеги болгон ашиглах, нэгдмэл, оролцоог хангасан засаглалыг бэхжүүлэх, зан үйлийн өөрчлөлт хийх шаардлагатай.

⁵ Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаа (ОУБТС/MICS)-ны дүнгээс харахад 2/3-р ангийн хүүхдүүдийн дөнгөж 44.4 хувь нь унших чадварын доод түвшинг, 33.6 хувь нь тоо бодох чадварын доод түвшинг эзэмшиж байна.

⁶ Дэлхийн банк. Гэрийн, асаргааны ажилд цалингүй зарцуулсан цагийн эзлэх хувь, эрэгтэй хүн (24 цагийн %) - Монгол Улс. Мэдээллийг <https://data.worldbank.org/indicator/SG.TIM.UWRK.MA?locations=MN>



Хөгжил цэцэглэл [ТХЗ 7, 8, 9, 10]

Нүүрс, эрдэс баялгийн экспортоос ихээхэн хамааралтай Монгол Улсын ДНБ-ий жилийн дундаж өсөлт 2009 оноос хойш зарим жилд 1.3 хувь (2009)⁷ хүртэл агших, 17.3 хувь (2013) хүртэл өсөх зэргээр огцом хэлбэлзэж, эдийн засгийн өсөлт, уналтын мөчлөг байнга тулгарч байна. Залуучуудын ажилгүйдлийн түвшин 17.9 хувь буюу улсын дундаж болох 7 хувьтай харьцуулахад ихээхэн өндөр байна. Монгол Улсын эдийн засагт албан бус хөдөлмөр эрхлэлт харьцангуй өндөр байна. 2019 онд албан бус хөдөлмөр эрхэлж байгаа эрчүүд (25.6 хувь) эмэгтэйчүүдээс (19.8 хувь) олон байна⁸. Хөдөлмөр эрхлээгүй, боловсрол сургалтад хамрагдаагүй залуучуудын (15-24 насны) хувийн жин 2020 онд 19.7 хувь байна. Хөдөлмөр эрхлээгүй, боловсрол сургалтад хамрагдаагүй залуучуудын дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь (21.7 хувь) эрэгтэйчүүдээс (17,8 хувь) их байна⁹. **[ТХЗ 8]**. Эдийн засгийн төрөлжилт хязгаарлагдмал, эрс шинэчлэлтийг дэмжих тал дээр хоцронгуй байгаа ч, Монгол Улс цахим үндэстэн болох зорилт дэвшүүлж,

энэ чиглэлд идэвхтэй ажиллаж байна. 2020 онд ДНБ-ий 0.55 хувийг судалгаа, хөгжлийн хөтөлбөрүүдэд зарцуулжээ. Түүнчлэн Монгол Улс ложистикийн гүйцэтгэлийн индексээр 160 улсаас 130-д (2018) эрэмбэлэгдсэн бөгөөд өргөн уудам нутаг дэвсгэртэй, хүн ам сийрэг суурьшдаг учраас дэд бүтцийн бүтээн байгуулалтын өртөг өндөр байх сорилт тулгарсан хэвээр байна **[ТХЗ 9]**. Тэгш бус байдлыг илэрхийлэх “Жини коэффициент” 2018 онд дунд зэрэг буюу 32.7 байсан нь цар тахлын үед бий болсон тэгш бус байдал буюу орлогоор илэрхийлэгддэггүй тэгш бус байдлыг бүрэн илэрхийлж чадахгүй байна **[ТХЗ 10]**. Монгол Улсын хүн ам бүх нийтээр эрчим хүчний үйлчилгээ авах боломжтой бөгөөд гол эх үүсвэрийн дийлэнх нь цахилгаан станцууд юм. Нийт эрчим хүчний эцсийн хэрэглээнд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийн жин маш бага буюу 3.4 хувь (2018) байна. Цэвэр буюу байгаль орчинд ээлтэй эрчим хүчний хүртээмж хязгаарлагдмал буюу тэгш бус, ялангуяа хөдөө орон нутгийн ядуу өрхүүд байгальд ээлтэй түлш (боловсруулсан) хэрэглэх боломж бага байна **[ТХЗ 7]**.



Эх дэлхий [ТХЗ 6, 11, 12, 13, 15]

Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллөөс улбаалсан ган, зуд, салхи шуурга, үер зэрэг гамшигт үзэгдэл хүн амын амьжиргаа, дэд бүтэц, мал аж ахуйд ноцтой хохирол учруулж байна. Хүлэмжийн хийн ялгарлыг 27.2 хувиар бууруулах нөхцөлт зорилт бүхий Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн амлалтаа хэрэгжүүлэхийн тулд тууштай арга хэмжээ авах шаардлагатай **[ТХЗ 13]**. Усны нөөц хомсдон, мөсөн голууд, мөнх цэвдэг хайлж, мал сүргийн ялгас, уул уурхайд ашигласан химийн аюултай бодис, материал хөдөө, орон нутагт энд тэндгүй тархах болсон, түүнчлэн орон нутагт хаягдал ус цэвэршүүлэх дэд бүтэцгүй, хот, суурин газруудын хаягдал ус цэвэршүүлэх байгууламж үр ашиг муутай ажиллаж байгаа зэргээс шалтгаалан усны чанар улам доройтож байна. Усны эрэлт хэрэгцээ ойрын 20 жилд 3 дахин өсөх магадлалтайг харгалзан үзвэл усны асуудал том сорилт болохоор байна **[ТХЗ 6]**. Монгол Улсын нийт хүн амын талаас илүү хувь нь Улаанбаатар хотод оршин сууж байна. Төлөвлөлт муутай өргөжиж буй хотжилт, хөдөөгөөс хот руу чиглэлтэй тасралтгүй үргэлжлэх шилжилт хөдөлгөөн, хот орчмыг тойрон тэлэх албан бус суурьшлын

бүсүүд (*гэр хороолол*), ихэвчлэн нүүрсээр ажилладаг цахилгаан станцаас ялгарах утаанаас үүдсэн агаарын бохирдол, хог хаягдлын үр ашиггүй менежмент зэрэг олон сорилт нь хүнд ээлтэй хот суурин, суурьшлын бүсийг байгуулах тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэхэд бэрхшээл учруулж байна **[ТХЗ 11]**. Хариуцлагагүй хэрэглээ, үйлдвэрлэлийн бүтэц, үр ашиг багатай байгалийн нөөцийн ашиглалт зэрэг нь биологийн олон янз байдалд хор хөнөөл учруулж, экосистемийн эмзэг байдлыг улам нэмэгдүүлж байна **[ТХЗ 12]**. Монгол орны ихэнх газар нутаг ямар нэг хэмжээгээр эвдрэл доройтолд өртөж, бэлчээрийн мал аж ахуйн удирдлага, зохицуулалт тааруугаас шалтгаалж бэлчээрийн даац хэтрэлт, газар тариалангийн тогтвортой бус арга ажиллагаа, усны нөөцийн хамгаалал, ногоон хөгжил, хөдөө аж ахуйд суурилсан боловсруулах үйлдвэрлэл зэрэгт хангалттай хөрөнгө оруулалт хийгдэхгүй байгаа нь тус улс олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүрэг амлалтаа биелүүлж чадахгүйд хүргэх эрсдэлийг дагуулж байна. Мөн газрын зохисгүй ашиглалт нь биологийн олон янз байдал алдагдах, ой мод устах эрсдэлд хүргэхээр байна **[ТХЗ 15]**.

⁷ 2020 оныг тооцоогүй, энэ үед КОВИД-19 цар тахлын улмаас эдийн засгийн өсөлт 4.56 хувь хүрч суларсан.

⁸ ОУХБ, ХНХЯ, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт (2021) Монгол Улс дахь албан бус хөдөлмөр эрхлэлт: Судалгааны тайлан.

⁹ Дэлхийн банк. Боловсрол, ажил эрхлэлт, сургалтад хамрагдаагүй залуучуудын эзлэх хувь, нийт (залуучуудын хүн амын %) - Монгол Улс. Мэдээллийг <https://data.worldbank.org/indicator/SL.UEM.NEET.ZS?locations=MN>



Энх тайван [ТХЗ 16]

1990-ээд оноос хойш зохион байгуулсан чөлөөт сонгуулиудын үр дүнд Монгол Улс тайван замаар ардчилалд туштай шилжсэн. Тус улс хүний эрхийн үндсэн гэрээ хэлэлцээрүүдэд нэгдэн орж, олон улсын хэм хэмжээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх институц, механизмыг бий болгосон. Монгол Улс цаазаар авах ялыг халж, хүний эрхийг хамгаалагчдыг хуулиар хамгаалах нөхцөлийг бүрдүүлсэн. Ийнхүү ахиц дэвшил гарч буй ч, эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг

хүчирхийлэл, хүн худалдаалах гэмт хэрэг, хууль зөрчсөн хүүхэдтэй харьцахдаа хүүхдийн эрхийг зөрчих, авлигын түвшин өндөр, удаан хугацааны турш улстөржсөн төрийн алба, шилжин суурьшигчдын эсрэг нийгмийн хэм хэмжээ, хандлага илт бий болсон, лесбиян, гей, бисексуал, трансжендэр, интерсекс хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал зэрэг онцгой анхаарал хандуулах шаардлагатай олон асуудал тулгамдсан хэвээр байна.



Түншлэл [ТХЗ 17]

Монгол Улс нь өсөн нэмэгдэж буй өрийн дарамт, төсөв санхүүгийн хүндрэлтэй нүүр тулж байна. Өмнө өгүүлсэнчлэн тус улсын нийт өр 2021 оны эцсийн байдлаар ДНБ-ий 92 хувьтай тэнцэж байна. Тус улсыг хөрөнгө оруулагчид эрсдэл өндөртэй хэмээн үзэх болсноор гадаадын шууд хөрөнгө оруулалт мэдэгдэхүйц буурчээ. Монгол Улс нь далайд гарцгүй орны хувьд Төв Азийн бүсийн Эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөр (CAREC), БНХАУ-Монгол-ОХУ-ын Эдийн засгийн коридор, Ази-Номхон далайн бүсийн Худалдааны хэлэлцээр зэрэг бүс нутгийн дэд бүтэц, худалдааны хэд хэдэн санаачилгатай хамтран ажиллаж байна. Монгол Улс нь уламжлалт бус хандивлагчид болон оролцогч талуудтай хамтын ажиллагаагаа бэхжүүлж, Өмнөд-Өмнөдийн

болон гурван талт хамтын ажиллагааны стратеги боловсруулахад идэвхтэй оролцох байр суурьтай байна. Монгол Улсад цахим худалдааг өргөжүүлж, хүн амд үйлчилгээг шуурхай хүргэхэд чиглэсэн цахимжилтын боломж бүрэн ашиглагдаагүй байна. ТХЗ-ыг нутагшуулах, тэдгээрийг олон улсынхтай нийцүүлэн нэгдсэн бодлогод тусгах ажил бүрэн хийгдээгүй, ТХЗ-ын хэрэгжилт, хяналт-шинжилгээ, тайлагналын талаар нотолгоонд суурилсан бодлого, шийдвэр гаргахдаа нарийвчилсан задаргаатай тоо мэдээлэл ашигладаггүй, мөн нэн шаардлагатай тоо мэдээлэл хангалтгүй байгаа зэрэг нь зохицуулалт, бодлогын уялдаа холбоо, интеграцлал дутмаг байгааг илэрхийлэх томоохон сорилт болж байна.



Монгол Улсын Ерөнхий сайд У. Хүрэлсүх НҮБ-ын 75 жилийн ойд зориулж мэндчилгээ дэвшүүлж байна. 2020 он. Зургийг НҮБ-ын Суурин зохицуулагчийн газар.

1.4 Сорилт, боломж

Сорилт

Засаглал сул, санхүүжилт хангалтгүй байгаа нь ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд хамгийн том сорилт болж байна. Энэ нь нотолгоонд суурилсан, жендэрийн мэдрэмжтэй, нэгдсэн, уялдаатай бодлогын төлөвлөлт, хэрэгжилтийг хангах байгууллагын чадавх сул, хөрөнгө нөөцийн хуваарилалт хангалтгүй, үр ашиг муутай байгаагаар илэрч байна. Төрийн албан хаагчдыг албан тушаалд томилох, ажилд авахдаа чадахуйн зарчим (мерит)-ыг хангах нь асуудалтай хэвээр байна.

Төрийн захиргааны байгууллагуудад халаа сэлгээ их байгаагаас төрийн албаны залгамж чанар алдагдаж, хариуцлагын тогтолцоо сул, ил тод бус, иргэдэд чиглэсэн, мэдрэмжтэй хандлага дутагдалтай байгааг залруулж, сайжруулах хэрэгтэй. Шүүхээр шийдвэрлэгдэж байгаа авлигын хэргийн тоо нэмэгдэхийн хэрээр, цахим засаглалд шилжих, хүнд суртал, авлигагүй төрийн үйлчилгээг бүрдүүлэхээр Ерөнхий сайд тэргүүлсэн Үндэсний хороог байгуулах (2021 он), төрийн худалдан авалтын үйл ажиллагааг цахимжуулах зэрэг олон арга хэмжээг Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа хэдий ч авлига олон салбарт бат бөх оршсон хэвээр байгаа нь төрийн байгууллагад иргэдийн итгэх итгэлийг бууруулж байна.

Монгол Улсын статистикийн тогтолцоо чадавх сайтай¹⁰ хэдий ч нарийвчилсан задаргаатай тоон мэдээллийн сан дутмаг, нөлөө гаргахуйц түвшний үр дүнд анхаарал хандуулахгүй байгаа зэрэг нь нотолгоонд суурилсан бодлого шийдвэр гаргах, улмаар ТХЗ-ыг хэрэгжүүлэх үйл явцад саад болж байгааг Үндэсний сайн дурын илтгэлд (2019) тэмдэглэсэн. Хүн амын нас, хүйс, үндэс угсаа, хөгжлийн бэрхшээлийн байдал, шилжилт хөдөлгөөний хэв маяг зэрэг шинж байдлыг нарийвчлан судалсан бодитой тоо мэдээлэл дутмаг байгаа нь хөгжлийн үр шимээс хоцрох эрсдэлтэй хүн амын бүлгүүдэд чиглэсэн үр нөлөөтэй бодлого, шийдвэр гаргахад бэрхшээл учруулж байна.

Монгол Улсын Засгийн газар “Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөр” болон ТХЗ-ыг хэрэгжүүлэх үүрэг хариуцлагаа нотлон харуулж байгаа ч эдгээрийг олон улсынхтай нийцүүлэн өөрийн оронд бүрэн нутагшуулж, үндэсний болон орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөгөөнд нэгдсэн зохицуулалттайгаар уялдуулан, хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлыг үргэлжлүүлэх шаардлагатай.

Шийдвэр гаргахад бодлогын уялдаа холбоо, зохицуулалт сул байгаа нь 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд саад болж байна. Засгийн газрын үйл ажиллагаа ихэвчлэн дангаар, тусгаар шинжтэй байгаа нь төр засгийн нэгдмэл бодлого, зохицуулалт сул, бүх нийтийн оролцоог хангах арга барил тогтоогүйтэй холбоотой байна. Эдийн засгийн бүх салбарт харилцан нэгийгээ нөхөх, дэмжих бодлого, хамтын ажиллагааны механизм тогтоогүй байна. ТХЗ-ууд нь өөр хоорондоо нягт уялдаатай төдийгүй тэдгээрийг хэрэгжүүлэхэд илүү нэгдмэл арга механизм шаардлагатай байгаа энэ үед дээрх асуудал томоохон сорилт болж байна. Үндэсний хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийг найдвартай, цогц, нотолгоонд суурилсан дүн шинжилгээнд тулгуурлан зохих ёсоор тодорхойлоогүй, хөгжлийн хөтөлбөрүүдийн дийлэнх нь улс төрийн бодлогоос үүдэлтэй байгаа нь мөн асуудал дагуулж байна.



¹⁰ Дэлхийн банк. (2020). Монгол Улсын статистикийн чадавхын оноо 92.2 буюу Зүүн Ази, Номхон далайн бүс нутгийн дунджаас өндөр байна. Мэдээллийг <https://datatopics.worldbank.org/statisticalcapacity/scidashboard.aspx>



Уур амьсгалын өөрчлөлт, түүнээс үүдэлтэй цаг агаарын эрс тэс үзэгдлүүдээс улбаалсан асуудлыг цаг тухайд нь шийдвэрлэхгүй бол ТХЗ-ыг хэрэгжүүлэх явцад гарч буй үр дүнг эсрэгээр эргүүлэх эрсдэлтэй. Уур амьсгалын өөрчлөлт, байгалийн нөөцийн ачаалал нь ажлын байр бий болгох, шилжилт хөдөлгөөн, эрүүл мэнд, боловсрол, хөдөө аж ахуй, хот, хөдөөгийн тэнцвэртэй хөгжил зэрэгт сөргөөр нөлөөлнө. Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлөлтэй тэмцэх үүрэг амлалтаа хэрэгжүүлэх, гамшгийн эрсдэлийн бэлэн байдлыг хангахад шаардагдах чадавх сул хэвээр байна. Уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтол нь “Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөр”-ийг бүхэлд нь хэрэгжүүлэхэд тулгарч буй салбар дундын тулгамдсан асуудал болж байна.

Хөрөнгийн зарцуулалт ихтэй олборлох салбараас ихээхэн хамааралтай, төрөлжиж чадаагүй эдийн засаг, зогсонги байдалд орсон хөдөлмөр эрхлэлт, өргөжин тэлж буй албан бус эдийн засаг, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцээгүй ур чадвар, бүтээмж тааруу, цалин хөлсний зөрүүтэй байдал, техникийн болон мэргэжлийн боловсролын тогтолцоо сул байгаа зэрэг нь ТХЗ-ын хэрэгжилтийг эрчимжүүлэхэд саад болж, улмаар залуучууд, эмэгтэйчүүд, эмзэг бүлгийнхэнд ноцтой хохирол учруулж байна.

Монгол Улсад хувийн хөрөнгө оруулалтын орчин тийм ч таатай бус байгаагаас хөрөнгө оруулагчид тус улсыг өндөр эрсдэлтэй орчин хэмээн үзэж байгаа, нөгөөтэйгүүр улсын нийт өрийн түвшин өндөр, хууль тогтоомж, дүрэм журам нь өөрчлөгддөг, бодлого, зохицуулалтын уялдаа сул, хоорондоо нийцэхгүй, хууль тогтоомжийн талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл, санхүүжилтийн хүртээмж тэгш бус зэргээс шалтгаалж гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО) мэдэгдэхүйц буурч байна.

Монгол Улсын эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбарт оруулсан нийт хөрөнгө оруулалтын хэмжээ адил төстэй улс орнуудынхтай харьцуулахад илүү байгаа ч үр нөлөө нь сул, чанар хангалтгүй байна. Халдварт бус өвчний тархалт нь хүн амын эрүүл мэндийн томоохон эрсдэл болж байгаа төдийгүй бага насны хүүхдийн боловсролын үйлчилгээний хамрах хүрээ, тэгш хүртээмж, чанар мөн тулгамдсан асуудал болж байна. Нийгмийн үйлчилгээний тогтвортой байдлыг хангах хүрээнд төсвийн зарцуулалтын үр ашгийг илүү сайжруулах шаардлагатай.

Нийгмийн хэм хэмжээ, жендэрийн талаарх хэвшмэл, өрөөсгөл ойлголт нь эмэгтэйчүүд болон бусад эмзэг бүлгийнхний эрхийг хязгаарлаж, эдийн засгийн хүртээмжтэй, тогтвортой өсөлтөд саад тотгор учруулж байна.

Боломж

Нүүрс, эрдэс баялаг зэрэг байгалийн арвин нөөцтэй Монгол Улс ашигт малтмалаа эдийн засгийн өсөлтийг хангахад ашиглаж байна. Гэсэн хэдий ч олборлох салбар нь хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхгүй, ядуурлыг бууруулахад дорвитой хувь нэмэр оруулахгүй байна¹¹. Иймээс байгалийн баялгийг хүний нөөцийг хөгжүүлэх, хүн амын сайн сайхан байдалд чиглүүлэх шаардлага байсаар байна. Усны нөөц хомсдон, байгаль орчин улам доройтож буй өнөө үед уул уурхайн зохистой арга техникийг нэвтрүүлэх, ашигт малтмалын боловсруулалтаас олсон орлогыг илүү ухаалаг зарцуулах, эдийн засгийн мөчлөгийн

сөрөг нөлөөллийг зөөлрүүлэхэд чиглэсэн санг бүрдүүлэх, хүний нөөцийг хөгжүүлж, эдийн засгийг төрөлжүүлэх зэрэгт чиглэсэн хөрөнгө оруулалтыг дэмжих шаардлагатай бөгөөд ингэснээр ихээхэн үр өгөөжийг авчирна.

Монгол Улсын хүн амын бүтэц өөрчлөгдөхийн хэрээр нийт хүн амын дунд залуучуудын эзлэх хувийн жин томоохон байр суурь эзэлсэн хэвээр байна. Энэ нь улс орны тогтвортой өсөлтийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд залуучуудын эрүүл мэнд, боловсрол, ур чадварт хөрөнгө оруулах ихээхэн хэрэгцээ байгааг харуулж байна.

¹¹ Монгол Улсын уул уурхайн салбар ДНБ-ий 20 хувь, экспортын 90 хувь, төсвийн орлогын 20 хувийг бүрдүүлж байгаа хэдий ч нийт хөдөлмөр эрхлэлтийн дөнгөж 3.6 хувийг бүрдүүлж байна. Мэдээллийг <https://www.cambridge.org/core/journals/environment-and-development-economics/article/effects-of-ups-and-downs-of-the-mongolian-mining-sector/B4BD4C1468E8EBFBA5A445AB2EA39C96>

Ингэснээр залуучуудын эрхийг хамгаалахын зэрэгцээ тэд улс орныхоо нийгэм, эдийн засаг, улс төрийн амьдралд идэвхтэй оролцох боломж бүрдэж, ашиг тусаа эргээд улс орондоо өгнө. Энэ нь боловсрол, сургалтад хамрагдаагүй, ажил хөдөлмөр эрхлээгүй залуучуудын (15-24 насны) хувийн жинг ч бууруулна.

Эмэгтэйчүүд өндөр боловсрол эзэмшсэн, бүх салбарт ажиллаж байгаа ч шийдвэр гаргах түвшинд тэдний төлөөлөл хангалттай бус байна. Эдийн засаг, байгаль орчин, нийгмийн салбарын тогтвортой хөгжилд эмэгтэйчүүдийн мэдлэг, чадварыг бүрэн ашиглах нь улс орны хөгжлийг урагшлуулахад ихээхэн түлхэц болох юм.

Шилжин суурьшигчдын нийгмийн оролцоог нэмэгдүүлэх нь нийгэм, эдийн засгийн ач холбогдолтой. Хот, суурин газраас хөдөө, орон нутаг руу чиглэсэн шилжилт хөдөлгөөний урсгалыг дэмжих замаар хяналтгүйгээр тэлж буй хотжилтын сөрөг үр дагаврыг бууруулах боломжтой.

КОВИД-19 цар тахлын нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөө ноцтой байсан хэдий ч энэ нь ТХЗ-ын хэрэгжилтийг эрчимжүүлэх Үйл ажиллагааны


арван жилийн хүрээнд ногоон, хүртээмжтэй өсөлт, цахим өөрчлөлтийг түлхүү хөгжүүлэх боломжийг бий болгож байна.

Монгол Улс гадаад худалдааг хөгжүүлэх, эдийн засгийн коридор байгуулах зэргээр бусад улстай хамтын ажиллагааг өргөжүүлэх боломжтой. Үүнийг тогтвортой дэд бүтцэд хөрөнгө оруулах, эдийн засгийг төрөлжүүлэх, олборлох үйлдвэрлэлээс хараат байдлаас ангижрах замаар хэрэгжүүлэх боломж бий. Ингэснээр Монгол Улсын экспортын зах зээл бусад улсад нээлттэй болж, улмаар далайд гарцгүйгээс үүдсэн сорилт бэрхшээлийг даван туулахад дэмжлэг болно.

Монгол Улсын гол салбаруудад дотоодын хувийн хэвшлийн оролцоо өсөн нэмэгдэж байгаа нь ажлын байрыг олноор бий болгох, зах зээлийн эрэлтэд нийцсэн ур чадварыг хөгжүүлэх, бүтцийн өөрчлөлт, эдийн засгийг төрөлжүүлэхэд хувь нэмэр болно. Боломжийг сайтар ашиглахын тулд жижиг, дунд үйлдвэрүүдийн санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, худалдааг хөнгөвчлөх зэргээр эрс шинэчлэл хийх шаардлагатай.



НҮБ-ын Суурин зохицуулагч Тапан Мишра Завхан аймгийн Залуучуудын хөгжлийн төвд зочлов. 2022 он.
Зургийг НҮБ-ын Суурин зохицуулагчийн газар.



Цахим худалдаа нь Монгол Улс болон далайд гарцгүй хөгжиж буй бусад улс оронд гадаад худалдааны шинэ зах зээл, боломжуудыг нээх ач холбогдолтой тул шаардлагатай эрх зүйн орчныг бүрдүүлэх, цахим дэд бүтэц, цахим үйлчилгээний хүртээмжийг сайжруулахад чиглэсэн техникийн туслалцаа үзүүлэх боломж бий болж байна¹².

Монгол Улсын цахим үндэстэн болох стратегийн зорилтын хүрээнд гаргаж буй хүч чармайлт нь нийгмийн эмзэг бүлгийнхэнд нэн шаардлагатай төрийн үйлчилгээг саадгүй хүргэх, хувийн хэвшлийг татан оролцуулан үйлчилгээний салбарыг түлхүү хөгжүүлж, эдийн засгийг төрөлжүүлэх боломжийг нээж өгч байна.

1.5 Хүний эрхийн талаарх олон улсын үүрэг амлалт

Монгол Улс хүний эрхийн үндсэн 9 гэрээнээс 8-ыг нь соёрхон баталсан. Харин Бүх цагаач ажилчид болон тэдний гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай олон улсын конвенцийг одоогоор соёрхон батлаагүй байна. Монгол Улс хүний эрхийн олон улсын механизм, байгууллагуудтай идэвхтэй хамтран ажилладаг бөгөөд Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг (UPR)-ийн 190 зөвлөмжөөс 170 зөвлөмжийг (3 дугаар тайлан, 2021 оны 3 дугаар сар), Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц (CEDAW)-ийн зөвлөмжийн 90 хувийг хүлээн авч, зөвлөмжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг НҮБ-ын дэмжлэгтэйгээр боловсруулан хэрэгжүүлж байна.

Монгол Улс Жендэрийн Үндэсний хороог байгуулж, жендэрийн эрх тэгш байдлыг хангах асуудлыг Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх ажлын хүрээнд оруулсан. Монгол Улс нь Хүний эрхийн Үндэсний Комисс (ХЭҮК)-ыг бэхжүүлэхэд чиглэсэн олон арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаагийн зэрэгцээ хараахан бүрэн хэрэгжиж эхлээгүй байгаа ч эрүү шүүлтээс урьдчилан

Геополитикийн нөхцөл байдлаас үл хамааран нарийн мэдрэмжтэй дипломат ажиллагаа явуулснаар цар тахлын хямралыг даван туулж, цаашдын тогтвортой хөгжилд түлхэц болж байгаагийн нэгэн адил улс төрийн тогтвортой байдал, энх тайван, ардчиллын төлөвшил нь улс орны цаашдын хөгжилд маш чухал боломж, хувь нэмэр болох юм.

сэргийлэх талаар ХЭҮК-ын гүйцэтгэх үүргийг тодорхойлсон үндэсний механизмыг бий болгожээ. Монгол Улсын Их Хурлаар Хүний эрхийг хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг баталж, хүний эрхийн зөрчлийн асуудлаар дуу хоолойгоо илэрхийлж буй иргэдийг хамгаалах тогтолцоог бүрдүүлсэн Ази тивийн анхны улс болсон. Монгол Улс 2015 онд цаазаар авах ялыг халсан нь дэлхий дахины талархлыг хүлээсэн алхам болсон юм. Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлгийн зөвлөмжид үндэслэн тус улс Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмуудыг хэрэгжүүлэх Үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө боловсруулахаар ажиллаж байна. Монгол Улс 2018 онд Аюулгүй, дэг журамтай, зохистой хэвийн шилжилт хөдөлгөөний тухай Дэлхийн гэрээг батлахыг дэмжсэн улсын нэг юм.

Мөн Хүүхдийн эрхийн тухай конвенцод (ХЭЗХ) заасан хүүхдийн эрхийг хамгаалах, түүний дотор хурдан морины уралдаан, гэр бүлийн хүчирхийлэл, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол, бие махбодын шийтгэл зэрэг асуудалтай холбоотой хууль тогтоомжийг баталж, институцийн механизмыг бий болгосон.

¹² Далайд гарцгүй орнуудын бүлгийг төлөөлөн Монгол Улсаас ДХБ/ВТО-д хүргүүлсэн Сайд нарын тунхаглал. Мэдээллийг <https://docs.wto.org/dol2fe/Pages/SS/directdoc.aspx?filename=q:/WT/GC/237.pdf&Open=True>



“Монголдоо сайхан амьдаръя” залуучуудын тайван жагсаал. 2022 он. Зургийг Б.Ирээдүй/Noise Art Media

Гэвч хүний эрхийн зарим тулгамдсан асуудал гарсан хэвээр байна. Тухайлбал, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, ялгаварлан гадуурхах хандлага, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан зэрэг эмзэг бүлгийн хүмүүсийг алагчлах, хүчирхийллийн нөхцөл байдал, түүний дотор хүүхдийн эсрэг хүчирхийлэл, байгаль орчны доройтол зэрэгтэй холбоотой хүний эрхийн зөрчлүүд гарсаар байна. Ялангуяа хот, суурин газрууд агаар, хөрс, усны ноцтой бохирдолд өртөж, өвлийн улиралд Улаанбаатар хотын агаарын бохирдлын хэмжээ дэлхийд дээгүүрт тооцогдохоор болсон нь хүний цэвэр, аюулгүй

ундны ус хэрэглэх эрх, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх болон амьжиргааны зохистой түвшинд амьдрах эрх зөрчигдөх эрсдэлд хүргэж байна¹³. Хүмүүс үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, тайван жагсаал, цуглаан хийх, эвлэлдэн нэгдэхэд төр, засаг хөндлөнгөөс оролцохгүй, хязгаарлахгүй байх талаар эрх зүйн баталгаа бүрдсэн хэдий ч иргэний нийгмийн зарим үйл ажиллагаа, тайван жагсаал цуглааны цагдаагийн байгууллагын зүгээс тасалдуулах явдал гарч байна. Түүнчлэн КОВИД-19 цар тахлын үеэр иргэний орон зай, түүний дотор иргэдийн цахим орон зайд халдах асуудал гарч байсныг тэмдэглэж байна.

¹³ Монгол Улс дахь Нэгдсэн Үндэстний Байгууллага. (2021). Монгол Улсын Төлөв байдлын шинжилгээ. х.47

1.6 Хэнийг ч орхигдуулахгүй байх зарчим

Хэнийг ч орхигдуулахгүй байх нь олон улсын хэм хэмжээ, хүний эрхийн суурь зарчимд тулгуурласан “Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөр”-ийн тэргүүлэх зарчим юм. Энэ нь ядуурлын бүх хэлбэрийг устгах, ялгаварлан гадуурхах, алагчлах явдлыг таслан зогсоох, хөгжлийн үр шимээс хүмүүсийг орхигдуулан хувь хүн, хүн төрөлхтний боломж чадавхыг сулруулж буй тэгш бус байдал, эмзэг байдлыг бууруулах зорилгоор НҮБ-ын гишүүн улс орнууд 2015 онд санал нэгтгэж баталсан амлалт болно.

Хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмын хэрэгжилтийг хангах зорилгоор Монгол Улсын Төлөв байдлын шинжилгээнд орхигдож байгаа буюу орхигдох эрсдэлтэй хүн амын бүлгүүдийг

судлан тодорхойлсон. Хэд хэдэн хавсарсан хүчин зүйлсээс шалтгаалан нэн эмзэг байдалд амьдарч байгаа хүмүүс хөгжлийн үр шимээс орхигдох эрсдэл хамгийн өндөр байна. Орхигдох эрсдэлтэй хүн амын бүлгүүдийг тодорхойлох зорилгоор зарим бүлэг, иргэдтэй фокус бүлгийн хэлэлцүүлэг зохион байгуулсны зэрэгцээ КОВИД-19 цар тахлын эсрэг нийгэм, эдийн засгийн хариу арга хэмжээний төлөвлөгөө, олон улсын хүний эрхийн тайлан, мэдээллүүд, Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-ын тайлан зэрэг олон эх сурвалжийг үүнд ашигласан болно.

Орхигдож байгаа болон орхигдох эрсдэлтэй дараах хүн амын бүлгүүд байна. Үүнд:



1. Хүүхэд, өсвөр үеийнхэн



2. Хөдөөгийн ядуу иргэд, малчид



3. Үндэстний цөөнх

4. Ажилгүй, ур чадваргүй залуус



5. Охид, эмэгтэйчүүд (болон эмзэг бүлгийн эрчүүд)



6. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс



7. Ахмад настан

8. Хот, суурин газрын ядуу иргэд, дотоодын шилжин суурьшигчид



9. Бэлгийн цөөнх

10. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид



Хувирамтгай бөгөөд хөрөнгө нөөц, гадаадын хөрөнгө оруулалт ихээр шингээж буй олборлох үйлдвэрлэлд тулгуурласан эдийн засгийн өсөлтийн загвар нь хүмүүс хөгжлийн үр шимээс орхигдох суурь шалтгаан болдог бөгөөд энэ нь эдийн засгийн төрөлжилтийг хязгаарлаж, ажилгүйдлийг нэмэгдүүлэхэд хүргэж байна. Хөдөө, орон нутагт ажлын байр дутмаг, орлого нэмэгдүүлэх боломж хомс, мөн байгаль, цаг уурын эрсдэл, доройтлын эрсдэл давхар нүүрлэж байгаагийн зэрэгцээ байгалийн нөөцийн хүртээмж хязгаарлагдмал, хүний нөөцөд чиглэсэн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хамрах хүрээ, өгөөж, үр дүн тааруу, эмзэг бүлгийнхний эрхийг зохистой түвшинд хамгаалах засаглалын байгууллагуудын чадавх сул зэрэг олон хүчин зүйл үүнд нөлөөлж байна.

Хүн амын бүлгүүдийг орхигдуулахад нөлөөлж буй бусад олон хүчин зүйл байна. Тухайлбал, нийгэмд давамгайлж буй хэвшмэл хэм хэмжээ, жендэрийн

талаарх сөрөг ойлголт, эмэгтэйчүүдийг алагчлах хандлага; орхигдох эрсдэлтэй хүн амын бүлгүүдэд үр өгөөжтэй бодлого боловсруулан хэрэгжүүлэх үүрэг хүлээгчдийн чадавх сул, нарийвчилсан задаргаатай тоо мэдээлэл дутмаг; гэмт хэргийн хохирогчид мэдээлэл өгөх хүсэл сонирхол дутмаг; эрх эдлэгчдийн оролцоо хязгаарлагдмал, тэдний үзэл бодлыг бодлого, хөтөлбөрт хангалтгүй тусгах; ялангуяа хөдөө орон нутаг болон алслагдсан нутгуудад үйлчилгээ хүргэгчдийн чадавх хангалтгүй; гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх дэмжлэг, туслалцаанд чиглэсэн төсөв хөрөнгө хязгаарлагдмал; бодлого боловсруулагчид болон эмзэг бүлгийг төлөөлдөг иргэний нийгмийн байгууллагуудын хоорондын итгэлцэл сул, хамтын ажиллагаа дутмаг зэрэг болно.

2.1 Өөрчлөлтийн ерөнхий онол

ТХЗ-ын хэрэгжилтийг эрчимжүүлэх Үйл ажиллагааны арван жилийн энэ цаг үед Монгол Улс дэлхийн бусад улс орны нэгэн адил цар тахалтай тэмцэхийн зэрэгцээ ТХЗ-ын хэрэгжилтийг үргэлжлүүлэн хангах боломж хязгаарлагдаж, гол бодлого, үйл ажиллагаагаа КОВИД-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээнд төвлөрүүлсэн нь ТХЗ-ын хэрэгжилтэд гарсан зарим ололт амжилтыг зогсонги байдалд оруулж, улмаар олон тооны сорилттой тулгарахад хүргэж байна. Өсөн нэмэгдэж буй тэгш бус байдал, эдийн засгийн уналт, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлөл улам хурцдаж байгаа зэрэг нь ердийн бизнесийн хандлагаар цааш хөгжих боломжгүй төдийгүй үр дүн багатайг харуулж байна. Дэлхий дахинд урьд хожид тохиолдож байгаагүй, урьдчилан таамаглах аргагүй, хүнд цочрол учруулсан цар тахлын хямралыг 2030 он хүртэлх тогтвортой хөгжлийн замналаар даван туулахын зэрэгцээ уг хямралыг даван туулах, эргэн сэргэхэд чиглэсэн тууштай, өвөрмөц бодлого шаардлагатай байна.

Өөрчлөлтийн ерөнхий онолд Монгол Улс “Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх үйл явцаа эрчимжүүлэх, улмаар

“2030 он гэхэд Монгол Улсын иргэн бүр амьдралынхаа туршид хүртээмжтэй, эрсдэл даах чадвартай, тогтвортой хөгжлөөр баталгаажсан, хамтаар хөгжин цэцэглэх, эрүүл, аюулгүй орчны үр шимийг хүртэх; эрх зүйт ёс, хүний эрхэд суурилсан эв нэгдэлтэй нийгэмд хөгжин дэвжих нөхцөл бүрдсэн байна” гэж Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын нэгдмэл алсын харааны үндсэн зорилгод хүрэх өөрчлөлтийн замналыг тодорхойлсон болно.


Энэхүү алсын харааны хэрэгжилтийг хангах боломж нь сайн сайхан байдлыг тэтгэх хүний нөөцийн хөгжилд хангалттай хөрөнгө оруулсан, үндэсний хөгжлийн стратегид уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг байгалийн нөөцийн тогтвортой менежмент, гамшгийн эрсдэлийг бууруулах зэрэг асуудалтай уялдуулан тусгаж, ногоон, тогтвортой, хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийг бий болгосон, хүн төвтэй засаглал, эрх зүйт ёс, эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн эрх тэгш байдлыг хангаж, хүний эрхийг бүрэн дүүрэн хангасан тэр нөхцөлд бүрдэх юм. (2.2 дахь хэсэгт буй хүснэгтийг үзнэ үү).



Өмнөговь аймгийн Даланзадгад хот дахь Политехникийн коллежийн оюутнууд. 2022 он.
Зургийг Б.Хаш-Эрдэнэ /НҮБ-ын Хүн амын сан

Эдгээр нь хамтын ажиллагааны хүрээний стратегийн тэргүүлэх чиглэлүүд (2.2 дахь хэсгийг үзнэ үү) болохын зэрэгцээ ТХЗ-ын нэгдмэл шинж чанарыг агуулж байгаа тул өөр хоорондоо харилцан нягт уялдаатай байх учиртай. Стратегийн тэргүүлэх чиглэлүүдийн хүрээнд дэвшүүлсэн үр дүнгийн дөрвөн зорилт нь бодлого, хөтөлбөр, институцийн механизмын арга замаар дараах өөрчлөлтийг бий болгохыг зорино. Тухайлбал,


Илүү үр нөлөөтэй, хүртээмжтэй, эрх тэгш, жендэрийн болон хямрал, цочролын мэдрэмжтэй **нийгмийн үйлчилгээ** (эрүүл мэнд, хоол тэжээл, боловсрол, бага насны хүүхдийн боловсрол, ус, ариун цэврийн байгууламжийн үйлчилгээ, нийгмийн хамгаалал) бий болно.




Илүү төрөлжсөн, эрс шинэлэг, нүүрсхүчлийн хий бага ялгаруулах, зохистой ажлын байрыг олноор бий болгох **эдийн засгийн өсөлт** бий болж, эмэгтэйчүүд, залуучууд, эмзэг бүлгийн хүмүүс хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн үр чадвартай болох, хөдөлмөр эрхлэх боломжийг өргөжүүлнэ.




Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлөл, биологийн олон янз байдлын доройтол, агаарын бохирдол зэрэг асуудлыг шийдвэрлэх, “ногоон”, хаягдалгүй эдийн засгийг хөхиүлэн дэмжих, хүн амын бүлгүүд, ялангуяа малчдын гамшгийн эрсдэлийг (зудын аюул гэх мэт) даван туулах чадварыг бэхжүүлэх зэрэгт **байгалийн нөөцийг** илүү тогтвортой ашигладаг болно.




Хүн бүр үр нөлөө бүхий үйлчилгээ авч, хүний эрх хангагдсан, хүн бүр нэр төр, эрх мэдлээ бүрэн таатай эдэлж байгаагаа мэдрэхүйц ил тод, авлигагүй, хариуцлагатай **засаглалын тогтолцоо** үндэсний болон орон нутгийн түвшинд бий болно.




Эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг хүчирхийллээс үр дүнтэй урьдчилан сэргийлж, таслан зогсоох, хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дорвитой хариу арга хэмжээ авах, эмэгтэйчүүдийн хөлсгүй асран хамгаалах ажил, үүргийн ачааллыг бууруулах, эдийн засаг, нийгэм, улс төрийн амьдралд эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих механизм, үйл явц боловсронгуй болсон байна.



Эрх баригчдад хариуцлага тооцдог, үр нөлөөтэй ажиглагч байх, хараат бус, шударга **хэвлэл мэдээлэл, иргэний нийгэм** бий болно.




Бүс нутаг, хөдөө орон нутаг, хот суурин газар, нийгмийн болон эдийн засгийн давхарга, жендэр зэрэгт суурилсан **тэгш бус байдлыг** бууруулна.



Нотолгоонд тулгуурласан бодлого шийдвэр гаргах, илүү сайн зохицуулалттай, нарийвчилсан задаргаатай тоо мэдээллийг бий болгох, ашиглах замаар **бодлогын уялдаа холбоог** сайн хангадаг болно.



Хил дамнасан бараа бүтээгдэхүүний тээвэрлэлт, хүн амын шилжилт хөдөлгөөнтэй холбоотой хил дамнасан хөгжлийн сорилтуудыг шийдвэрлэхийн тулд **бүс нутгийн хамтын ажиллагааг** бэхжүүлнэ.



Шилжилт хөдөлгөөн, БНХАУ, ОХУ-аас эдийн засгийн хувьд хараат болох геополитикийн нөхцөл, байгалийн баялгийн менежментээс үүсэх нийгмийн зөрчил, авлига зэрэг сорилт бэрхшээлийг тооцож тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн урьдчилан сэргийлэх арга замыг баримтална.



“Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэхэд шаардлагатай бүхий л хүчин зүйлс нь дээрх өөрчлөлтийг бий болгох гол арга замыг дэмжинэ. Тухайлбал,

1

Цахим
хуваагдал

Цахим хуваагдлыг

арилгаж, ялангуяа
нэн эмзэг хэсгүүдэд
чиглэсэн цахим
хувьслыг бий болгох,

2

Хөгжлийн
санхүүжилт

3

Түншлэл

Нэмэлт санхүүжилт татах,
техникийн туслалцаа,
чадавх бэхжүүлэхэд
чиглэсэн олон талт
түншлэлийг бий болгох,

Эрс шинэлэг
эх үүсвэрийг
ашиглаж, **хөгжлийн
санхүүжилтийг**
хангалттай
хэмжээнд
бүрдүүлэх,

4

Хүн амын
бүтцийн
шилжилт

Залуучуудын хүсэл
тэмүүллийг зоригжуулан
дэмжихийн тулд
**хүн амын бүтцийн
шилжилтийг**
зохистойгоор удирдах,
хот, хөдөөгийн хөгжлийг
тэнцвэржүүлэх,

5

Хил дамнасан
хамтын
ажиллагаа

Хүрсэн ахиц дэвшлийг
баталгаажуулан
эрчимжүүлэх
**хил дамнасан
хамтын ажиллагааг**
хөгжүүлэх,

6

Нийгмийн
хэм хэмжээ

Хор уршиг
учруулахуйц
**нийгмийн хэм
хэмжээ** эмэгтэйчүүд,
эмзэг бүлгүүдэд
нөлөөлөх өрөөсгөл
ойлголт, жендэрийн
хэвшмэл ойлголт
зэрэгтэй үр дүнтэй
тэмцэх,

7

Тоо
мэдээллийн
сан

**Нарийвчилсан
задаргаатай
тоо мэдээллийн
санг** бий болгож,
бодлого, шийдвэр
гаргахад ашиглахыг
дэмжих зэрэг
болно.

Өөрчлөлтийн онол

АЛСЫН 2030 он гэхэд Монгол Улсын иргэн бүр амьдралынхаа туршид хүртээмжтэй, эрсдэл даах чадвартай, тогтвортой **ХАРАА:** хөгжлөөр баталгаажсан, хамтаар хөгжин цэцэглэх, эрүүл, аюулгүй орчны үр шимийг хүртэх, эрх зүйт ёс, хүний эрхэд суурилсан эв нэгдэлтэй нийгэмд хөгжин дэвжих нөхцөл бүрдсэн байна.

СТРАТЕГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 1:
Хүний хөгжил, сайн сайхан байдал

ҮР ДҮНГИЙН ЗОРИЛТ 1:

2027 он гэхэд хот, хөдөөгийн иргэн бүр, ялангуяа нэн эмзэг болон орхигдох эрсдэлтэй хүн амын бүлгүүд өөрсдийн нөөц боломжийг бүрэн дүүрэн, эрх тэгш ашиглаж, хүний эрхэд суурилсан, хүртээмжтэй, жендэрийн мэдрэмжтэй, цочролд тэсвэртэй, эрүүл мэнд, хоол тэжээл, боловсрол, нийгмийн хамгаалал, ус, ариун цэврийн байгууламжийн болон бусад үйлчилгээний үр шимийг хүртэнэ.

Үр дүн 1.1: Жендэрийн мэдрэмжтэй, цочролд тэсвэртэй, хямд төсөр, чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээ (бие махбодын, сэтгэцийн, бэлгийн болон нөхөн үржихүйн), хоол тэжээлийн болон ус ариун цэврийн байгууламжийн үйлчилгээг хүн бүрт хүргэх эрүүл мэндийн нэгдсэн тогтолцоог дэмжих чадавх бэхжсэн байна.

Үр дүн 1.2: Боловсролын тогтолцоо бүхэлдээ, боловсролын байгууллагууд нь нийт хүүхэд, залуучууд, тэр дундаа эмзэг бүлгийн хүүхэд, залуучуудыг бага насны хүүхдийн боловсрол, амьдрах ухаан, бэлгийн цогц боловсрол зэрэг боловсролын бүхий л үйлчилгээнд ялангуяа онцгой байдлын үед хүртээмжтэй, тэгш хамруулан сургах, сургуулиас хөдөлмөрийн зах зээлд, төвөггүй шилжих боломжийг бүрдүүлэх хэмжээнд хүрч чадавхжсан байна.

Үр дүн 1.3: Нийгмийн болон хүүхэд хамгааллын бодлого, тогтолцоо (нийгмийн даатгал, нийгмийн халамж, хөдөлмөрийн зах зээлийн хөтөлбөрүүд) нь хүн бүрийг нийгмийн хамгааллын үйлчилгээнд эрх тэгш хамруулж, цочролд тэсвэртэй, тогтвортой хөгжиж хүн амын эмзэг хэсгийг найдвартай хамгаалах чадавхтай болно.

Үр дүн 1.4: Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, жендэрийн мэдрэмжтэй, хүн бүрт хүртээмжтэй, хямд төсөр, чанартай ундны ус, ариун цэврийн байгууламж, эрүүл ахуйн үйлчилгээг хүн бүрт хүргэх хүчин чадалтай болно.

Үр дүн 1.5: Хүн амын эмзэг хэсэгт онцгой анхаарал хандуулахын зэрэгцээ хүн бүр шим тэжээллэг, эрүүл хоол хүнсний зохистой түвшинд хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх, хамгаалах, дэмжих чадавх бэхжсэн байна.

Үр дүн 1.6: Илүү эв нэгдэлтэй нийгэмд жендэрийн эрх тэгш байдал, хүний эрх, нэн ялангуяа шилжин суурьшигчдын эрхийг хүндэтгэн хамгаалах хүртээмжтэй, оролцоог хангасан, олон салбарыг хамарсан, жендэрт суурилсан хүчирхийллийн эсрэг дорвитой хариу арга хэмжээ авах механизмыг бий болгох институцийн болоод чадавхыг бэхжүүлнэ.

Салбар дундын өөрчлөлт: Дижитал хуваагдлыг арилгаж, дижитал хувьсалыг ашиглах; Эрс шинэлэг эх үүсвэрийг ашиглаж хөгжлийн санхүүжилтийг хангалттай хэмжээнд бүрдүүлэх; Хүн амын бүтцийн шилжилтийг зохистойгоор удирдаж залуусын хүсэл тэмүүллийг дэмжих; Ахиц дэвшилд саад учруулах хил дамнасан асуудлаас урьдчилан сэргийлэх; Хор уршиг учруулахуйц нийгмийн хэм хэмжээ, эмзэг бүлгийнхний эсрэг өрөөсгөл ойлголт, жендэрийн талаарх хэвшмэл ойлголт зэрэгтэй үр дүнтэй тэмцэх; нарийвчилсан задаргаатай тоо мэдээллийн санг бий болгож, бодлого шийдвэр гаргахад ашиглахыг дэмжих;

Тавигдах нөхцөл: Засгийн газар эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбарт хангалттай хэмжээний төсөв хөрөнгийг төвлөрүүлэх байр суурийг тууштай баримтлах; КОВИД-19 цар тахлын дэгдэлтийг хяналтадаа оруулж, халдварын тархалт зогссон байх; Хил дамнасан бараа, үйлчилгээний хөдөлгөөн саадгүй болсон байх; Дэд бүтэц, дижитал хувьсалд хөрөнгө оруулалт хийж, хүн амд үйлчилгээг үр дүнтэй хүргэх; Төрийн үйлчилгээг хязгаарлах санхүүгийн хямрал гаргахгүй байх; Төрийн захиргааны удирдлагыг сайжруулах, авлгатай үр дүнтэй тэмцэх улс төрийн хүсэл зоригтой байх.

СТРАТЕГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 2:
Ногоон, хүртээмжтэй, тогтвортой өсөлт

ҮР ДҮНГИЙН ЗОРИЛТ 2:

2027 он гэхэд Монгол Улсын эдийн засаг илүү төрөлжсөн, шинэлэг, бүтээмжтэй, хүртээмжтэй, "ногоон" болж, бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг ханган, ялангуяа эмэгтэйчүүд, залуучуудын зохистой амьжиргааг тэтгэх, XXI зууны эрэлт хэрэгцээтэй ур чадварыг хөгжүүлэх, нүүрсхүчлийн хий бага ялгаруулах хөгжлийг дэмжинэ.

Үр дүн 2.1: Эмэгтэйчүүд, залуучуудын ур чадвар эзэмших, дахин мэргэшэх боломжийг өргөжүүлж бизнес эрхлэх сургалтыг зохион байгуулан тэдний зохистой хөдөлмөр эрхлэх, ажилд ороход шаардагдах бүтээлч чадварыг дээшлүүлэх, түүнчлэн дотоод, гадаадын шилжих хөдөлгөөнийг илүү үр дүнтэй удирдах зэргээр эмэгтэйчүүд, залуучууд, орхигдох эрсдэлтэй хүн амын бүлгүүдийн ажиллах хүчний оролцоог нэмэгдүүлэх институцийн чадавхыг бэхжүүлнэ.

Үр дүн 2.2: Эдийн засгийг төрөлжүүлж, нөөцийг үр ашигтай зарцуулах арга хандлагад шилжих, нүүрсхүчлийн хий бага ялгаруулах хөгжил, дижитал хувьсалыг дэмжих, улмаар өрсөлдөх чадвартай, технологийн хувьд эрс шинэлэг, бүтээмжтэй эдийн засгийг хөгжүүлэх, жижиг аж ахуйн нэгжүүд илүү ногоон үйл ажиллагаа эрхлэх, олон улсын нэмүү өртгийн сүлжээнд холбогдох, албан ёсны эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэх боломжийг нэмэгдүүлэх, нөөцийг үр ашигтай, тогтвортой ашиглах зэрэг нөхцөлийг хангасан бодлого, стратеги, институцууд бий болсон байна.

Үр дүн 2.3: Ил тод, урьдчилан тооцоолох боломжтой хөрөнгө оруулалтын орчныг бүрдүүлэх, үр ашигтай, нүүрсхүчлийн хий бага ялгаруулах хөгжилд чиглэсэн хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих эрс шинэлэг санхүүжилтийн тогтолцоог бий болгох Засгийн газрын чадавх бэхжиж, бизнесийн хариуцлагатай хэрэглээ, үйлдвэрлэлийг дэмжих, хүний эрхийг дээдлэх, нийгэм, байгаль орчин, өмч хөрөнгөд ээлтэй бодлогууд хэрэгжинэ.

ҮР ДҮНГИЙН ЗОРИЛТ 3:

Нотолгоонд суурилсан, жендэрийн мэдрэмжтэй, байгалийн нөөц, байгаль орчны тогтвортой менежмент, гамшгийн эрсдэлийг бууруулах чадавх сайжирснаар 2027 он гэхэд Монголын Улсын хүн ам, экосистем уур амьсгалын өөрчлөлтөд илүү тэсвэртэй болсон байна.

Үр дүн 3.1: Дасан зохицох чадавхыг сайжруулж, нийгэм, эдийн засгийн эмзэг байдлыг бууруулах, гамшгийн улмаас нүүлгэн шилжүүлэх эрсдэлийг сааруулахын тулд уур амьсгалын өөрчлөлтөд мэдрэмжтэй хариу арга хэмжээ авах төлөвлөлт, хөгжлийн эрх зүйн зохицуулалтын тогтолцоо бэхжсэн байна.

Үр дүн 3.2: Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөө тооцсон, газар, ой, биологийн олон янз байдал, ус зэрэг байгалийн нөөцийн тогтвортой менежмент, мал аж ахуйн бүтээгдэхүүний өртгийн сүлжээг сайжруулах, онцгой байдлын үед авах арга хэмжээг үр дүнтэй төлөвлөж зохицуулах зэргээр байгалийн нөөцөөс ихээхэн хамааралтай малчдын нөхөрлөлүүдийн эрсдэлийг даах чадварыг бэхжүүлнэ.

Үр дүн 3.3: Байгалийн нөөцийн тогтвортой менежмент, биологийн олон янз байдлын алдагдлыг бууруулж экосистемийн үйлчилгээг сайжруулах талаар мэргэжлийн мэдлэг чадвартай институцууд, аж ахуйн нэгжүүд, хүн амын бүлгүүд төлөвшсөн, генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашигласнаас гарах ашиг, үр шимийг тэгш, шударгаар хуваалцах, ялангуяа малчдад хүртээмжтэй байх нөхцөл бүрдсэн, чадавх бэхжсэн байна.

СТРАТЕГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 3:
Хүн төвтэй засаглал, эрх зүйт ёс, хүний эрх

ҮР ДҮНГИЙН ЗОРИЛТ 4:

2027 он гэхэд Монгол Улсын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл явц жендэрийн мэдрэмжтэй, оролцоог хангасан, харилцан уялдаатай, нотолгоонд суурилсан, ТХЗ-той уялдсан, бүх шатны засаглалын байгууллагууд ил тод, хариуцлагатай ажиллаж, хүний эрхийг бүрэн хангаж хамгаалсан, тэгш шударга, эрх зүйт ёсыг хүн бүр, ялангуяа орхигдох эрсдэлтэй хүн амын бүлгүүд ялгарвгүй эдлэх боломж нөхцөл бүрдсэн байна.

Үр дүн 4.1: Жендэрийн эрх тэгш байдал, хөдөлмөрийн эрх зэрэг хүн амын эмзэг хэсгийн эрхийг хамгаалах, дэмжих, хяналт тавих эрх үүрэг бүхий шүүх засаглалын байгууллагууд, Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс, иргэний нийгмийн байгууллагуудын чадавх сайжирна.

Үр дүн 4.2: Бодлогын үнэлгээг тогтмол хийх, нөлөөлөл, сурталчилгаа, сургалт мэдээллийн үйл ажиллагаа өргөжүүлэх зэргээр эмэгтэйчүүд, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эсрэг хүчирхийлэл, дарамт шахалт, хүн худалдаалах гэмт хэрэг зэргээс үр дүнтэй урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, жендэрийн эрх тэгш байдлыг хангах механизм, үйл явцыг сайжруулна.

Үр дүн 4.3: Төв, орон нутгийн оролцоог талуудын үйлчилгээг ил тод, хүн төвтэй, үр нөлөө гарахуйцаар үр дүнтэй хүргэх чадавх дижитал хувьсалд шилжсэнээр сайжирч, нотолгоонд суурилж бодлого боловсруулах, хяналт шинжилгээ хийх, тайлагнах үйл явцыг харилцан уялдуулж, бодлого шийдвэр гаргахад иргэд оролцох боломжийг бүрдүүлснээр тэд эрх баригчдаас үр дүнгийн хариуцлага нэхэх чадвар эзэмшсэн байна.

Үр дүн 4.4: Иргэний нийгэм, залуучуудын зөвлөлүүд, эмэгтэйчүүд, залуучуудын сүлжээгээр дамжуулан улсын болоод орон нутгийн хурлын сонгуулиуд, орон нутгийн бодлого шийдвэр гаргадаг байгууллагуудын эмэгтэйчүүд, залуучуудын төлөөлөл, оролцоог нэмэгдүүлнэ.

Дээр дурдсан өөрчлөлтийн онол/үзэл санаа нь хүний эрхэд суурилсан хөгжлийн хандлагад тулгуурласан бөгөөд дараах удирдах зарчмуудыг мөрдлөг болгов. Үүнд: (1) хэнийг ч орхигдуулахгүй байх, (2) хүний эрхэд суурилсан хандлага, (3) жендэрийн эрх тэгш байдал, эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх, (4) эрсдэл даах чадвартай байх, (5) тогтвортой байдал, (6) хариуцлагатай байх зэрэг болно. Хамтын ажиллагааны хүрээ нь бүс нутаг, хүн амын бүлгүүд, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондын эрх тэгш бус байдлыг бууруулахын тулд орхигдох эрсдэлд өртөж болзошгүй хүн амын бүлгүүдийг үйл ажиллагаандаа түлхүү хамруулахыг эрмэлзэнэ. Мөн КОВИД-19 цар тахлын үеэр бий болсон шинэ хэлбэрийн эмзэг байдлыг тусгайлан авч үзэх болно.

Дээрх арга замууд нь өөр хоорондоо уялдаа холбоотой төдийгүй харилцан биенээ нөхнө. Төрийн үйлчилгээг цаг алдалгүй, үр дүнтэй хүргэх байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх нь шийдлийн бүхий л арга замд тэргүүлэх ач холбогдолтой байх болно. Ирээдүйд бий болох ажлын байрны дийлэнххувийг ногоон, тогтвортой, цахим эдийн засаг бий болгох тул эмэгтэйчүүд, залуучууд зэрэг бүх ажиллах хүчинд ур чадвар шинээр олгох, давтан сургах, мэргэшүүлэх замаар дэмжлэг үзүүлэх шаардлага тавигдана.

Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлөл, эдийн засгийн болон эрүүл мэндийн хямралыг даван туулах чадвартай тогтолцоо нь нийгмийн үйлчилгээнд оруулах хөрөнгө оруулалтын үр нөлөөг тодорхойлно. Эрх тэгш байдал нь дотоод үнэ цэнийн хувьд төдийгүй эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих хэрэгсэл болгож хэрэгжүүлэх учиртай чухал зорилт юм.

Өнөөг хүртэл үргэлжилсээр буй, үр дагавар нь хараахан тодорхой бус КОВИД-19 цар тахлын үед энэхүү хамтын ажиллагааны хүрээ баримт бичгийг боловсруулав. Цар тахал нь нийгэм, эдийн засгийн хүнд сорилтуудыг бий болгосон ч, нөгөө талаас хөгжлийн зүй тогтлыг эргэн харж, тогтвортой хөгжих зарчмуудыг хямралын дараах сэргэлт, эрсдэлийн удирдлагын зарчмуудтай хослуулан, “илүү сайнаар сэргээн цогцлоох” боломжийг бидэнд олгож байна. Ийм ч учраас хамтын ажиллагааны хүрээ нь “Алсын хараа-2050” баримт бичигт тусгалаа олсон “Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөр”, ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үндэсний хөгжлийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлнэ.

Хамтын ажиллагааны хүрээ амжилттай хэрэгжих эсэх нь гадаад, дотоодын олон **нөхцөл байдлаас** хамаарна гэж үзэж байна. Тухайлбал,

1

Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбарт хангалттай хэмжээний төсөв хөрөнгө төвлөрүүлж, иргэдэд эдгээр үйлчилгээг үзүүлэх орон зайг хязгаарлах төсвийн хүндрэл гаргахгүй байх чиглэлд **Засгийн газар тууштай байр суурь баримтлах;**

2

КОВИД-19 цар тахлын тархалтыг хяналтдаа оруулан, хил гаалийн хөдөлгөөнийг чөлөөтэй нээж, хөрш орнуудын эдийн засгийн хямралаас үүдэн гарах аливаа сөрөг нөлөөлөл арилсан байх;

3

Богино хугацааны **эдийн засгийн ашиг сонирхол** нь уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлөл, нүүрсхүчлийн хийн ялгарлыг бууруулах томоохон хөтөлбөрүүдийг үл анзаарах эрсдэлийг бий болгох тул Засгийн газар холбогдох бодлого, хууль тогтоомж, стратеги, үйл ажиллагааг боловсруулах замаар уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг шийдвэрлэх чиглэлд тодорхой арга хэмжээ авах;

4

Нийгэм, эдийн засаг, байгаль орчны тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн тулд **олон нийтийн оролцоог** хангалттай түвшинд хүргэх;

5


Засгийн газар хүний эрхийн талаарх олон улсын гэрээ, конвенцийн заалтыг дагаж мөрдөх, түүний дотор жендэрт суурилсан хүчирхийллийн аливаа хэлбэрээс ангид, халдашгүй байх, хөдөлмөрийн хууль тогтоомжийг сахин биелүүлэх, хүний эрхийн үндэсний механизм, иргэний нийгмийн байгууллага зэрэг жендэрийн эрх тэгш байдлыг хамгаалах байгууллагыг эрх мэдэлжүүлэх;

6

Нарийвчилсан задаргаатай тоо мэдээллийн сан бий болгож, бодлого, шийдвэр гаргахад ашиглах тогтолцоо, механизмыг бэхжүүлэх хүсэл эрмэлзэлтэй байх;

7

Төрийн захиргааны удирдлагыг сайжруулах, авлигатай үр дүнтэй тэмцэх улс төрийн хүсэл зоригтой байх.



Хамтын ажиллагааны хүрээг амжилттай хэрэгжүүлэх нь олон талт түншлэлээс ихээхэн хамаарна. НҮБ нь Монгол Улсын үндэсний хөгжлийн тэргүүлэх зорилтууд, ТХЗ-ыг хэрэгжүүлэхийн төлөө Засгийн газар, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудтай нягт хамтран ажиллана. НҮБ-ын ТХХАХ-нд гарын үсэг зурсны дараа Санхүүжилт босгох түншлэлийн нарийвчилсан стратеги (СБТС)-ийг боловсруулна. СБТС-ийг боловсруулах явцад Монгол Улс дахь гол оролцогч талууд болон хөгжлийн түншүүдийн цогц замын зураглалыг гаргаж, НҮБ-ын ТХХАХ-г хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө санхүүжилтийг татан төвлөрүүлэх зорилгоор НҮБ-ын Удирдлагын баг, Засгийн газар, хандивлагчид болон бусад гол түншүүдийн дунд хэлэлцүүлэг тогтмол зохион байгуулж, зөвшилцлийг хангана. Түүнчлэн НҮБ-ын системийн байгууллагуудын түншлэлийн арга хандлагыг ч мөн ашиглах болно. Мөн хандивлагчид, олон улсын төрийн бус байгууллагууд, иргэний нийгэм зэрэг бусад түнш байгууллагуудын хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, туршлагыг ашиглах зорилгоор ТХЗ-ын хэрэгжилтийг эрчимжүүлэхэд холбогдох талуудыг татан оролцуулж, хүчийг нь нэгтгэх платформыг бий болгоно. Эцэст нь энэхүү стратегинь зөвхөн НҮБ-ын ТХХАХ-г хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө нөөц, түншлэлийг дайчлах үндсэн хэрэглүүр болоод зогсохгүй Монгол Улсад ТХЗ-уудыг хэрэгжүүлэхэд шаардагдах нэмэлт бөгөөд шинэлэг санхүүжилтийн арга хэрэгслүүдийг Үндэсний санхүүжилтийн нэгдсэн тогтолцоонд нийцүүлэн идэвхжүүлэх үр дүнтэй арга хэрэгсэл байх болно.

Энэхүү баримт бичгийн зорилт бүрийн хүрээ болон үр дүнгийн хэсэгт түншлэлийн тодорхой хэлбэрүүдийг тайлбарлав (Хавсралт 1).

Монгол Улс дахь НҮБ-ын систем нь НҮБ-ын **харьцангуй давуу талыг** удирдлага болгон, эрх мэдлийн хэм хэмжээ, байр суурь, чадавх (мэргэжлийн болон санхүүгийн) зэргийг тулгуурлан, гол тэргүүлэх чиглэлүүдэд хувь нэмэр оруулах бүрэн боломжтой. Дэлгэрэнгүй тайлбарыг 2.7 дахь хэсгээс үзнэ үү.

Энэхүү хамтын ажиллагааны хүрээ баримт бичгийг боловсруулах явцад өнгөрсөн жилүүдэд НҮБ-ын хөгжлийн тусламжийн хүрээ (НҮБ-ын ХТХ)-г хэрэгжүүлэх явцад гарсан сургамжийг сайтар судалж үзсэн болно.

НҮБ-ын ХТХ-ний хэрэгжилтэд хийсэн үнэлгээ (2022 оны 2 дугаар сар)-ний тайланд НҮБ-ын ХТХ нь Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030-тай уялдан нийцэж байгаа болон тус хөтөлбөрийн хүрээнд НҮБ-ын Удирдлагын багаас цар тахалтай тэмцэх арга хэмжээний хамтарсан хөтөлбөрүүдийг шуурхай бөгөөд үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн зэрэг сайн загвар болсныг тэмдэглэсэн билээ. Гэхдээ тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад дараах гол сургамжийг авсан. Тухайлбал, НҮБ-ын Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээг боловсруулах үйл явцад Засгийн газрын идэвх санаачилгатай оролцоог хангах, хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмыг баримталж эмзэг бүлгийнхэнд гол анхаарлаа чиглүүлэх, хүрсэн үр дүн, амжилтын цар хүрээг илүү тэлж өргөжүүлэх стратегийг дэмжих, үр дүнгийн бүлгүүд, сэдэвчилсэн багуудын гүйцэтгэх үүрэг, үр нөлөөг бэхжүүлэх зэрэг нь тун чухал болохыг нотолсон.

Дээрх зөвлөмжийн дагуу НҮБ нь Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээг боловсруулах эхний шатнаас Монгол Улсын Засгийн газартай нягт хамтран ажиллаж Тогтвортой хөгжлийн Үндэсний хороо зэрэг үндэсний механизмуудтай үйл ажиллагаагаа уялдуулж ирсэн. Түүнчлэн ТХЗ-ыг хэрэгжүүлэх үндэсний хөгжлийн нэгдмэл зорилго, үр дүнгийн зорилтуудын илэрхийлэл болсон НҮБ-ын ТХХАХ-ний загвар, ач холбогдолыг тодорхойлж сайжруулсан. Улмаар дотоод зохицуулалтыг сайжруулахын зэрэгцээ НҮБ-ын системийн байгууллагын хөтөлбөрүүд нь НҮБ-ын ТХХАХ-ний тэргүүлэх чиглэл, үр дүнгийн зорилтуудтай нийцсэн байх төдийгүй гарах үр нөлөөнд нь дорвитой хувь нэмэр оруулахыг дэмжих болно. Цаашлаад тодорхой хэмжигдэхүйц шалгуур үзүүлэлтийг ашиглан НҮБ-ын ТХХАХ-г хэрэгжүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаанд жендэрийн эрх тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийг чадавхжуулан эрх мэдэлжүүлэх удирдах зарчмуудыг тусгана. НҮБ-ын Удирдлагын баг болон Монгол Улсын Засгийн газар хамтран ТХЗ-ын санхүүжилтийн тогтолцоог бэхжүүлэх, түүний нөлөөллийн цар хүрээг сайжруулахад чиглүүлж үндэсний санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлнэ.

2.2 НҮБ-ын Хөгжлийн системийн стратегийн тэргүүлэх чиглэлүүд

Хамтын ажиллагааны хүрээг боловсруулах явцад үндэсний түншлэгч талууд (Монгол Улсын Засгийн газар, салбарын яамд, агентлагууд, иргэний нийгэм, хувийн хэвшлийн төлөөлөл, судалгааны төвүүд, эрдэм шинжилгээний байгууллагууд, залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн төлөөлөл), НҮБ-ын системийн суурин болон суурин бус байгууллагууд, олон улсын хөгжлийн түншүүд, олон улсын санхүүгийн байгууллагууд зэрэг олон талын төлөөллийг оролцуулан өргөн хүрээний хэлэлцүүлгүүдийг зохион байгуулав. Хамтын ажиллагааны хүрээг “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, НҮБ-аас гаргасан Монгол Улсын Төлөв байдлын шинжилгээ, НҮБ-ын ХТХ (2017-2021/2022)-ний хэрэгжилтэд хийсэн үнэлгээ, КОВИД-19 цар тахалтай тэмцэх нийгэм, эдийн засгийн хариу арга хэмжээний төлөвлөгөө (КОВИД-19 цар тахалтай тэмцэх зорилгоор Монгол Улс дахь НҮБ-ын төлөөлөл боловсруулсан), “Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн талаарх үндэсний сайн дурын илтгэл, нийгмийн бүх салбарын төлөөллийг оролцуулсан “НҮБ-

75” хэлэлцүүлгүүд зэрэг олон тооны баримт бичиг, судалгаа, тайлан, хэлэлцүүлгийн үр дүнд тулгуурлан боловсруулав.

Монгол Улс 2030 он гэхэд хүрсэн байх хөгжлийн түвшний талаарх стратегийн алсын харааг тодорхойлох арга хэмжээг Монгол Улс дахь НҮБ-ын байгууллагууд, Засгийн газартай хамтран 2021 оны 11 дүгээр сард зохион байгуулав. Энэ үеэр “Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилтыг суурь болгон авч үзсэн бөгөөд арга хэмжээ нь энэхүү баримт бичгийн агуулгыг урт хугацаанд “Алсын хараа-2050” баримт бичигтэй нийцүүлэн тодорхойлоход чухал ач холбогдолтой болов. Үүний зэрэгцээ стратегийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлох ажлуудыг хийж, Монгол Улсын өмнө тулгарч буй хөгжлийн сорилтууд, түүний дотор төлөв байдлын шинжилгээний үр дүнгийн талаар нэгдсэн ойлголтод хүрч, хөгжлийн цаашдын төлөвийг тодорхойлох боломж бүрдсэн. Энэ хүрээнд дээр дурдсан өөрчлөлтийн онолыг боловсруулж, алсын харааны стратеги зорилтыг хэрэгжүүлэх шийдлийн арга замыг тодорхойлов.



Хаваржаандаа буухаар нүүж буй малчдын нүүдэл. Баян-Өлгий аймаг. Зургийг ОУХШБ / Н.Нуржас.

Түүнчлэн “Хэрэв”, “Тэгвэл” гэсэн томъёоллыг хэрэглэн төлөвлөсөн хөтөлбөрүүд стратегийн тэргүүлэх зорилтуудын биелэлтэд хэрхэн нөлөөлөх, хөгжлийн алсын хараа руу хөтлөх боломжийг тодорхойлов. Эдгээр арга хэмжээний үеэр талууд НҮБ-ын оруулж буй хувь нэмэр,

харьцангуй давуу талыг бусад оролцогчдын зүгээс талархан хүлээн авч байв.

Эдгээр ажлын үр дүнд өөрчлөлтийн онолын дагуу дараах тэргүүлэх чиглэлүүдийг хамтран тодорхойлсон болно. Үүнд:



СТРАТЕГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 1: ХҮНИЙ ХӨГЖИЛ, САЙН САЙХАН БАЙДАЛ

Монгол Улс дахь НҮБ-ын Удирдлагын баг нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, боловсрол, нийгмийн хамгаалал зэрэг нийгмийн үйлчилгээний тогтолцоог бэхжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулна. Чингэхдээ хүний эрүүл мэнд нь мал амьтан, хүрээлэн буй орчны “эрүүл мэндээс” салшгүй хамааралтайг хүлээн зөвшөөрч “нэг эрүүл мэнд” зарчимд суурилсан бие махбодын (халдварт болон халдварт бус өвчин), сэтгэцийн болон бэлгийн эрүүл мэнд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг цогцоор хангах эрүүл мэндийн тогтолцоог хөгжүүлэхийн төлөө ажиллана. НҮБ-ын систем нь хүнсний аюулгүй байдал, хоол тэжээлийн олон янз байдал, хүмүүсийн зохистой хоол хүнс хэрэглэх эрхийг хамгаалах, хоол тэжээл, эрүүл мэндийг сайжруулах зэрэгт чиглэсэн, хүнсний бүтээгдэхүүний асуудалд суурилсан хөтөлбөрүүдийг дэмжинэ. Боловсролын салбарт үзүүлэх дэмжлэг нь бага насны хүүхдийн хөгжлөөс эхлэн хүмүүс насан туршдаа олон улсын болон бүс нутгийн боловсролын чанарын

стандартад нийцсэн цогц боловсрол эзэмших, улмаар XXI зууны эрэлтэд нийцсэн ур чадвар, амьдрах ухаанд суралцаж, ажил хөдөлмөрт саадгүй шилжих, эдийн засгийн “шинэ” эринд бэлтгэгдсэн байх зэрэг боломж, нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэнэ. НҮБ нь нийгмийн хамгааллын зарцуулалтыг үр ашигтай, тэгш, илүү өргөн хүрээг хамруулан сайжруулахад дэмжлэг үзүүлнэ. Түүнчлэн малчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан, эмэгтэйчүүд, хүүхдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, хямралын эсрэг мэдрэмжтэй, хүртээмжтэй нийгмийн хамгааллын үйлчилгээг бий болгоход анхаарна. Энэхүү стратегийн тэргүүлэх чиглэлийн зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд ялангуяа орхигдож байгаа буюу орхигдох эрсдэлтэй хүн амын бүлгүүдийг анхаарч, үндэсний болон орон нутгийн засаг захиргааны байгууллагуудтай хамтран ажиллана. Энэхүү стратегийн тэргүүлэх чиглэл нь “Алсын хараа-2050” бодлогын баримт бичгийн 2 дахь зорилтыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулна.

ЭНЭХҮҮ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН ХҮРЭЭНД ДАРААХ ҮР ДҮНГИЙН ЗОРИЛТ ДЭВШҮҮЛЖ БАЙНА:

Үр дүнгийн зорилт 1: ○

2027 он гэхэд хот, хөдөөгийн иргэн бүр, ялангуяа нэн эмзэг болон орхигдох эрсдэлтэй хүн амын бүлгүүд өөрсдийн нөөц боломжийг бүрэн дүүрэн, эрх тэгш ашиглаж, хүний эрхэд суурилсан, хүртээмжтэй, жендэрийн мэдрэмжтэй, цочролд тэсвэртэй эрүүл мэнд, хоол тэжээл, боловсрол, нийгмийн хамгаалал, ус, ариун цэврийн байгууламжийн болон бусад үйлчилгээний үр шимийг хүртэнэ.



СТРАТЕГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 2: НОГООН, ХҮРТЭЭМЖТЭЙ, ТОГТВОРТОЙ ӨСӨЛТ

Монгол Улс дахь НҮБ-ын Удирдлагын баг тус улсыг шинэлэг, өрсөлдөх чадвартай, ажлын байрыг олноор бий болгосон, ногоон, бүтээмжтэй, төрөлжсөн эдийн засагт шилжихэд нь бодит дэмжлэг үзүүлнэ. Байгалийн баялагт суурилсан эдийн засаг тогтвор муутай болохыг КОВИД-19 цар тахал анхааруулж, тогтвортой хөдөө аж ахуй, мал аж ахуйд түшиглэсэн эдийн засаг, үйлчилгээ, боловсруулах үйлдвэрлэл зэргээс илүү өргөн хүрээтэй өсөлтийг бий болгох боломж байгааг харуулав. НҮБ-ын Удирдлагын баг нь хувийн хэвшилд чиглэсэн хариуцлагатай, байгаль орчинд ээлтэй хөрөнгө оруулалтын бодлого боловсруулж хэрэгжүүлэх, ялангуяа бичил болон жижиг, дунд үйлдвэрүүд (БЖДҮ)-эд зах зээл, санхүү, технологид нэвтрэх боломжийг нээх, хүртээмжийг нэмэгдүүлэх, тэдгээрийг өртгийн сүлжээнд холбогдоход нь дэмжлэг

үзүүлнэ. Цахим хувьсал, залуучуудын оролцоог нэмэгдүүлэх зэрэг нь цахим худалдааг хөгжүүлэх, өрсөлдөх чадварыг сайжруулах, албан эдийн засгийг тэлэх стратегийн нэг байх болно. Нүүрсхүчлийн хий бага ялгаруулах үйл ажиллагаанд эдийн засаг шилжихийн хэрээр энэ үед эмзэг бүлгийн хүн амыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлөлтэй тэмцэх механизм бий болгох, байгалийн нөөцийг илүү тогтвортой удирдах, олон нийт, институцийг аюул гамшгийн үед хариу арга хэмжээ авахад бэлтгэх замаар эрсдэл даах чадварыг бий болгоход зохицуулалт хийх шаардлага бий болно. Уур амьсгалын өөрчлөлт, гамшгаас улбаатай дарамт ачааллыг эмэгтэйчүүд, эмзэг бүлгийнхэн илүү үүрч байгаа тул зорилтот бүлгүүдэд онцгой анхаарал хандуулна.

ЭНЭХҮҮ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН ХҮРЭЭНД ҮР ДҮНГИЙН ДАРААХ ХОЁР ЗОРИЛТЫГ ДЭВШҮҮЛЖ БАЙНА:

Үр дүнгийн зорилт 2:

2027 он гэхэд Монгол Улсын эдийн засаг илүү төрөлжсөн, шинэлэг, бүтээмжтэй, хүртээмжтэй, “ногоон” болж, бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг ханган, ялангуяа эмэгтэйчүүд, залуучуудын зохистой амьжиргааг тэтгэх, XXI зууны эрэлт хэрэгцээтэй үр чадварыг хөгжүүлэх, нүүрсхүчлийн хий бага ялгаруулах хөгжлийг дэмжинэ.

Үр дүнгийн зорилт 3:

Нотолгоонд суурилсан, жендэрийн мэдрэмжтэй, байгалийн нөөц, байгаль орчны тогтвортой менежмент, гамшгийн эрсдэлийг бууруулах чадавх сайжирснаар 2027 он гэхэд Монгол Улсын нийт хүн ам, экосистем уур амьсгалын өөрчлөлтөд илүү тэсвэртэй болсон байна.



СТРАТЕГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 3: ХҮН ТӨВТЭЙ ЗАСАГЛАЛ, ЭРХ ЗҮЙТ ЁС, ХҮНИЙ ЭРХ

Монгол Улс дахь НҮБ-ын Удирдлагын баг нь хүний эрх, ялангуяа эмзэг бүлгийн иргэдийн эрхийг хамгаалж, дэмжихийн зэрэгцээ хүчирхэг, хараат бус, зарчимч, шударга ёсны төлөө болон омбудсмений байгууллагууд, эрх зүйт тогтолцоог бий болгох засаглалын шинэчлэлийг үргэлжлүүлэхэд нь Засгийн газарт болон бусад оролцогч талд дэмжлэг үзүүлнэ. Яамд хоорондын ажлын уялдаа зохицуулалтыг сайжруулах, ТХЗ-той уялдуулж нэгдсэн төлөвлөгөө, төсвийн төлөвлөгөө боловсруулах, нотолгоонд суурилж бодлого, шийдвэргаргах зэрэг үйл явц нь нарийвчилсан задаргаа бүхий тоо мэдээллээр хангагдсан байх шаардлагатай. Төрийн албан хаагчид

чадахуйн зарчим (мерит)-д суурилсан, аль нэг талд үйлчилдэггүй, хүн төвтэй үйлчилгээ үзүүлэхэд хариуцлагатай ханддаг байх учиртай. Ялгаварлан гадуурхалтын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, үзэн ядсан үг хэллэг, хор уршиг учруулахуйц нийгмийн хэм хэмжээ, хэвшмэл сөрөг ойлголтыг арилгахад чиглэсэн иргэний орон зайг өргөжүүлэх шаардлагатай. НҮБ-ын Удирдлагын баг нь өөрийн системийн байгууллагуудын гүйцэтгэх үүрэг, эрх мэдлийн хүрээнд иргэний яриа хэлэлцүүлэг өрнүүлэх, “хэнийг ч орхигдуулахгүй байх” зарчмыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх болно.


ЭНЭХҮҮ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН ХҮРЭЭНД ДАРААХ ҮР ДҮНГИЙН ЗОРИЛТЫГ ДЭВШҮҮЛЖ БАЙНА:



Үр дүнгийн зорилт 4:

2027 он гэхэд Монгол Улсын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл явц жендэрийн мэдрэмжтэй, оролцоог хангасан, харилцан уялдаатай, нотолгоонд суурилсан, ТХЗ-той уялдсан, бүх шатны засаглалын байгууллагууд ил тод, хариуцлагатай ажиллаж, хүний эрхийг бүрэн хангаж хамгаалсан, тэгш шударга, эрх зүйт ёсыг хүн бүр, ялангуяа орхигдох эрсдэлтэй хүн амын бүлгүүд ялгаваргүй эдлэх боломж нөхцөл бүрдсэн байна.

Дараах **хүснэгтэд** “Алсын хараа-2050” бодлогын баримт бичигт туссан зорилтууд (1 дүгээр үе шат: 2021-2030 он), түүний хүрээнд тодорхойлсон тэргүүлэх чиглэлүүдийг Хамтын ажиллагааны хүрээний тэргүүлэх

чиглэлүүд, ТХЗ-уудтай уялдуулсныг харуулав. ТХЗ-ын зорилтуудтай хэрхэн нийцэж буйг Хавсралт-1 дэх Үр дүнгийн матриц хүснэгтээс харах боломжтой.



Хамтын ажиллагааны хүрээний Стратегийн тэргүүлэх чиглэлүүд	Үр дүнгийн зорилтууд болон холбогдох чиглэл "Ps"	"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого	Тогтвортой хөгжлийн зорилгууд		
Хүний хөгжил, сайн сайхан байдал	ҮР ДҮНГИЙН ЗОРИЛТ 1: ХҮН (PEOPLE)	<p>Зорилго 2: Хүний хөгжил</p> <ul style="list-style-type: none"> • насан туршийн чанартай боловсрол • эрүүл мэндийн чанартай тусламж үйлчилгээ • идэвхтэй, эрүүл амьдралын хэв маяг, насжилт • хоол тэжээл, хоол хүнсний олон янз байдал, хүнсний аюулгүй байдал • агаар, ус, хөрсний бохирдлоос сэргийлж, цэвэр, ногоон орчин бүрдүүлэх • ур чадварыг дээшлүүлж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх <p>Зорилго 3: Амьдралын чанар, дундаж давхарга</p> <ul style="list-style-type: none"> • нийгмийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлж, эмзэг бүлгийнхнийг бүрэн хамруулах, • хараат бус нийгмийн даатгалын тогтолцоог бүрдүүлэх • хямд төсөр орон сууцаар хангах • БЖДҮ-дэд ээлтэй орчин бүрдүүлэх • аж ахуй эрхлэлтийг дэмжих • малчид, тариаланчдыг дэмжих • тэгш бус байдлыг бууруулах 	<p> TX3 1 Ядуурлыг устгах</p> <p> TX3 2 Өлсгөлөнг зогсоох</p> <p> TX3 3 Эрүүл мэндийг дэмжих</p> <p> TX3 4 Чанартай боловсролыг дэмжих</p> <p> TX3 5 Жендэрийн эрх тэгш байдлыг хангах</p> <p> TX3 6 Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах</p> <p> TX3 7 Сэргээгдэх эрчим хүчээр хангах</p> <p> TX3 9 Инновац болон дэд бүтцийг хөгжүүлэх</p> <p> TX3 11 Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих</p> <p> TX3 17 Хөгжлийн төлөөх туншлэлийг бэхжүүлэх</p>		
		Ногоон, хүртээмжтэй, тогтвортой өсөлт	ҮР ДҮНГИЙН ЗОРИЛТ 2: ХӨГЖИЛ (PROSPERITY)	<p>Зорилго 4: Эдийн засаг</p> <ul style="list-style-type: none"> • макро эдийн засгийн тогтвортой байдал • хариуцлагатай уул уурхай, ХАА-н боловсруулалт, аялал жуучлал, бүтээлч үйлдвэрлэл • хүнс, хөдөө аж ахуйн илүү бүтээмжтэй салбар • агро-экологийн өртгийн сүлжээ • хүртээмжтэй санхүүжилт • бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцлал • өрсөлдөх чадавхыг сайжруулах • төрөлжсөн, эрс шинэлэг, ногоон өсөлтийг дэмжих баялгийн сан <p>Зорилго 8: Бүс нутаг, орон нутгийн хөгжил</p> <ul style="list-style-type: none"> • эдийн засгийн эрчимтэй өсөлтийг дэмжих хамтын ажиллагааг өргөжүүлэх • эко-жуулчлалыг хөгжүүлэх • ногоон эдийн засгийн зарчимд нийцсэн тогтвортой хөдөө аж ахуй. 	<p> TX3 1 Ядуурлыг устгах</p> <p> TX3 2 Өлсгөлөнг зогсоох</p> <p> TX3 5 Жендэрийн эрх тэгш байдлыг хангах</p> <p> TX3 8 Зохистой хөдөлмөр, эдийн засгийн өсөлтийг дэмжих</p> <p> TX3 9 Инновац болон дэд бүтцийг хөгжүүлэх</p> <p> TX3 10 Тэгш бус байдлыг бууруулах</p> <p> TX3 17 Хөгжлийн төлөөх туншлэлийг бэхжүүлэх</p>

Хамтын ажиллагааны хүрээний Стратегийн тэргүүлэх чиглэлүүд	Үр дүнгийн зорилтууд болон холбогдох чиглэл "Ps"	"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого	Тогтвортой хөгжлийн зорилгууд		
Ногоон, хүртээмжтэй, тогтвортой өсөлт	ҮР ДҮНГИЙН ЗОРИЛТ 3: ЭХ ДЭЛХИЙ (PLANET)	<p>Зорилго 4: Эдийн засаг</p> <ul style="list-style-type: none"> макро эдийн засгийн тогтвортой байдал хариуцлагатай уул уурхай, агро-боловсруулалт, жуулчлал, бүтээлч үйлдвэрлэл хүртээмжтэй санхүүжилт бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцчлал өрсөлдөх чадавхыг сайжруулах төрөлжсөн, эрс шинэлэг, ногоон өсөлтийг дэмжих баялгийн сан. <p>Зорилго 6: Ногоон хөгжил</p> <ul style="list-style-type: none"> байгалийн нөөцийг үнэлэх, хамгаалах, нөхөн сэргээх, усны хомсдолоос урьдчилан сэргийлэх, хүн амыг ундны усаар хангах уур амьсгалын өөрчлөлтөд өртөх эрсдэлтэй нь тогтоогдсон гол нуурын сав газрын менежмент нүүрсхүчлийн хий бага ялгаруулдаг, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжил уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг даван туулах чадавхыг бий болгох ногоон санхүүжилтийн тогтолцоог хувийн хэвшилтэй хамтран хөгжүүлэх <p>Зорилго 8: Бүс нутаг, орон нутгийн хөгжил</p> <ul style="list-style-type: none"> эдийн засгийн эрчимтэй өсөлтийг дэмжих хамтын ажиллагааг өргөжүүлэх эко-жуулчлалыг хөгжүүлэх ногоон эдийн засгийн зарчимд нийцсэн тогтвортой хөдөө аж ахуй <p>Зорилго 9: Улаанбаатар хот, дагуул хотууд</p> <ul style="list-style-type: none"> Тогтвортой, эрсдэл даах чадвартай, хүн төвтэй хотууд 	           	ТХЗ 1	Ядуурлыг устгах
		ТХЗ 2		Өлсгөлөнг зогсоох	
		ТХЗ 5		Жендэрийн эрх тэгш байдлыг хангах	
		ТХЗ 7		Сэргээгдэх эрчим хүчээр хангах	
		ТХЗ 8		Зохистой хөдөлмөр, эдийн засгийн өсөлтийг дэмжих	
		ТХЗ 9		Инновац болон дэд бүтцийг хөгжүүлэх	
		ТХЗ 10		Тэгш бус байдлыг бууруулах	
		ТХЗ 11		Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих	
		ТХЗ 12		Хариуцлагатай хэрэглээ, үйлдвэрлэлийг дэмжих	
		ТХЗ 13		Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөг багасгах	
		ТХЗ 15		Хуурай газрын экосистемийг хамгаалах	
		ТХЗ 17		Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх	

Хамтын ажиллагааны хүрээний Стратегийн тэргүүлэх чиглэлүүд	Үр дүнгийн зорилтууд болон холбогдох чиглэл "Ps"	"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого	Тогтвортой хөгжлийн зорилгууд		
Хүн төвтэй засаглал, эрх зүйт ёс, хүний эрх	ҮР ДҮНГИЙН ЗОРИЛТ 4: ЭНХ ТАЙВАН (PEACE)	<p>Зорилго 1: Үндэсний нэгдмэл үнэт зүйлс</p> <ul style="list-style-type: none"> • үндэсний бахархал, эв нэгдэл • нүүдлийн соёл иргэншилт монгол • монгол хэл, бичиг • эрдэм судлал-нийгмийн соён гэгээрэл • дэлхийн монгол <p>Зорилго 5: Засаглал</p> <ul style="list-style-type: none"> • хараат бус шүүх • бодлогын үр дүнтэй хэрэгжилт • хувийн хэвшил, иргэний нийгмийн оролцоо • хувийн хэвшлийг хөгжүүлэх эрх зүйн орчин • үр ашигтай цахим засаглал • чадахуйн зарчимд (merit) суурилсан, мэргэшсэн, хариуцлагатай, ёс зүйтэй, тогтвортой төрийн алба • хүний эрхийг хамгаалах үндэсний хүчирхэг тогтолцоо • авлигаас ангид засаглал <p>Зорилго 7: Аюулгүй, амар амгалан нийгэм</p> <ul style="list-style-type: none"> • улс дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх • орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхыг сайжруулах • олон улсын стандартад нийцсэн эрх зүйн шинэчлэл • хууль тогтоомж хэрэгжүүлэх чадавхыг сайжруулах • кибер аюулгүй байдлыг сайжруулах 	 TX3 1	Ядуурлыг устгах	
			 TX3 2	Өлсгөлөнг зогсоох	
			 TX3 5	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах	
			 TX3 9	Инновац болон дэд бүтцийг хөгжүүлэх	
			 TX3 10	Тэгш бус байдлыг бууруулах	
			 TX3 11	Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих	
			 TX3 12	Хариуцлагатай хэрэглээ, үйлдвэрлэлийг дэмжих	
			 TX3 13	Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөг багасгах	
			 TX3 16	Энх тайван, шударга ёсыг цогцлоох	
			 TX3 17	Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх	

Монгол Улс дахь НҮБ-ын системийн байгууллагууд "Алсын хараа-2050" урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үндэсний бодлого, стратегийн тодорхой зорилтууд, ТХЗ-ын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлж ажиллана. НҮБ-ын ТХХАХ баримт бичиг нь хөгжил, жендэрийн эрх тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийг эрх

мэдэлжүүлэх, "хэнийг ч орхигдуулахгүй байх" зэрэг хүний эрхэд суурилсан удирдах зарчмуудыг мөрдлөг болгон "Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх үйлсэд дэмжлэг үзүүлж буй нь чухамдаа хүний эрхийг хангахад оруулж буй бодит хувь нэмэр хэмээн НҮБ үзэж байна.

2.3 Хамтын ажиллагааны хүрээнд дэвшүүлж буй үр дүнгийн зорилтууд, түншлэл

Хамтын ажиллагааны хүрээнд тодорхойлсон стратегийн тэргүүлэх гурван чиглэлийн хүрээнд үр дүнгийн дөрвөн зорилтыг хэрэгжүүлснээр тогтвортой хөгжилд хүрэх үйл явцыг эрчимжүүлэх институцийн, зан үйлийн болон хууль эрх зүйн хүрээнд дорвитой өөрчлөлт гаргахаар төсөөлж байна. Эдгээр зорилтыг хэрэгжүүлж, өөрчлөлтийг бий болгоход Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Удирдлагын баг, оролцогч талууд хамтран бодитой хувь нэмэр оруулж чадах хэдий ч шууд хяналтдаа оруулах боломжгүй юм. Үр дүнгийн матриц хүснэгтэд үзүүлсэн шалгуур үзүүлэлтүүдийг ашиглан дэвшүүлж буй зорилтуудын хэрэгжилтийн үр дүнг хэмжиж, хяналт тавих боломжтой байна.

Дэвшүүлж буй зорилт бүрийн хүрээнд тодорхой үр дүнгүүд гарах болно. Тухайлбал, хувь хүмүүс, байгууллагуудын чадавх, мэдлэгт өөрчлөлт гарах, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмж нэмэгдэх зэргээр үр дүн гарч, НҮБ-ын систем түншүүдээрээ дамжуулан үүнд шууд хяналт тавьж, хариуцлагатай хандана.

Эдгээр үр дүнг Хамтын ажиллагааны хүрээг хэрэгжүүлэх Хамтарсан Ажлын төлөвлөгөө (ХАТ) боловсруулах явцад НҮБ-ын системийн холбогдох байгууллагуудаас Монгол Улсад хэрэгжүүлэх хөтөлбөр, стратегийн баримт бичигт тусгах дэд үр дүнгүүдтэй уялдуулан илүү тодорхой, боловсронгуй болгоно.



СТРАТЕГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 1: ХҮНИЙ ХӨГЖИЛ, САЙН САЙХАН БАЙДАЛ

Үр дүнгийн зорилт 1:

2027 он гэхэд хот, хөдөөгийн иргэн бүр, ялангуяа нэн эмзэг болон орхигдох эрсдэлтэй хүн амын бүлгүүд өөрсдийн нөөц боломжийг бүрэн дүүрэн, эрх тэгш ашиглаж, хүний эрхэд суурилсан, хүртээмжтэй, жендэрийн мэдрэмжтэй, цочролд тэсвэртэй, эрүүл мэнд, хоол тэжээл, боловсрол, нийгмийн хамгаалал, ус, ариун цэврийн байгууламжийн болон бусад үйлчилгээний үр шимийг хүртэнэ.

ӨӨРЧЛӨЛТИЙН ОНОЛ

Энэхүү зорилтыг хэрэгжүүлснээр гарах өөрчлөлтийн гол үзэл санаа нь Монгол Улсад хүний хөгжил, сайн сайхан байдлыг сайжруулахын тулд нийгмийн үйлчилгээний хүчирхэг тогтолцоо бий болгох шаардлагатайг илэрхийлнэ. Үүнд, хүн бүрийн, ялангуяа эмзэг бүлгийн хүмүүсийн насан туршийн бие махбодын, сэтгэцийн болон бэлгийн эрүүл мэнд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн хэрэгцээг хангасан бүх нийтийн, эрсдэлийг сөрөх чадвартай, эрх тэгш эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тогтолцоо; аюулгүй, шим тэжээлтэй хүнсний тэгш хүртээмжийг нэмэгдүүлэх, тогтвортой хэрэглээ, байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэлийг дэмжих; боловсролын үйлчилгээний үр нөлөөг сайжруулах, ялангуяа сургуулийн өмнөх насны хүүхдийг боловсролын үйлчилгээнд бүрэн

хамруулах, хот, хөдөөгийн, нийгмийн бүлгүүдийн ялгааг арилгах; залуучуудад сургуулийн орчноос ажил хөдөлмөрийн талбарт саадгүй шилжихэд нь дэм болохуйц мэргэжлийн болон амьдрах ухааны ур чадварыг эзэмшүүлэх; эмзэг бүлгийн иргэдийг бүрэн хамруулж, хамгаалсан жендэрийн мэдрэмжтэй, хямралд тэсвэртэй, үр нөлөө бүхий нийгмийн хамгааллын тогтолцоог бэхжүүлэх зэрэг өөрчлөлт багтана. Түүнчлэн улс орны хөгжил, ТХЗ-ын хэрэгжилтийг эрчимжүүлэхэд хувь нэмэр оруулж буй шилжин суурьшигчдын эрх ашгийг хамгаалах, дотоод болон олон улсын хэмжээнд гэнэтийн болон албадан нүүлгэн шилжүүлэлтэд өртөж байгаа хүмүүсийн эмзэг байдлыг бууруулах зэрэгт чиглэсэн шилжилт хөдөлгөөний цогц бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх үйл ажиллагаа үүнд хамаарна.


Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэд, дотоодын шилжин суурьшигчид, малчид, хүчирхийлэл мөлжлөгт өртсөн хүүхдүүд, жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүмүүс, хөдөөгийн хүн ам, үндэстний цөөнх, эрсдэлтэй эмзэг нөхцөлд амьдарч байгаа эмэгтэй, эрэгтэй хүмүүс, бэлгийн цөөнх зэрэг орхигдох эрсдэлтэй бүлэгт чиглэсэн нийгмийн суурь үйлчилгээний хүртээмжийг сайжруулахад онцгойлон анхаарал хандуулна. Эдгээр хүн амын бүлгийн төлөөллийг бодлого, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх, хяналт тавих үйл явцад

оролцуулснаар нийгмийн үйлчилгээг илүү шуурхай, хүн төвтэй болгоход тустай байх болно. Нийгмийн эв нэгдэл, эмэгтэйчүүд, үндэстний болон бэлгийн цөөнх, эмзэг бүлгийн хүүхэд, өсвөр үеийнхэн, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан, шилжин суурьшигчид зэрэг хүн амын бүлэгт чиглэсэн алагчлах болон хор уршиг учруулахуйц хандлага, зан үйл, хэвшмэл ойлголт, нийгмийн хэм хэмжээ, хандлагыг хэрхэн үр дүнтэй шийдвэрлэхээс ард түмний аж байдал ихээхэн хамаарна.

ҮР ДҮНГИЙН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД НҮБ-ЫН ОРУУЛАХ ХУВЬ НЭМЭР

Монгол Улс дахь НҮБ-ын системийн байгууллагууд нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тогтолцоог бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ эрүүл мэндийн салбарыг ТХЗ-ын бусад зорилгуудыг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэхүйц үйлчилгээ, эдийн засгийн шинэ тогтолцоо бүхий салбар болгон хөгжүүлэх чиглэлийг баримтлан ажиллана. НҮБ-аас хэрэгжүүлэх хөтөлбөрүүд нь халдварт бус өвчинтэй тэмцэх, тухайлбал хорт хавдар, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, уур амьсгалын өөрчлөлт, агаарын бохирдлоос шалтгаалсан хүний эрүүл мэндийн асуудал зэрэг эрүүл мэндийн нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай сорилтуудад анхаарал хандуулж, илүү нэгдмэл, хямд төсөр, хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх замаар бүх нийтийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд бүрэн хамруулах зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн олон талт хамтын ажиллагаа, зохицуулалтыг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ. Зөв зохистой хоол тэжээл нь хүүхдийн эрүүл мэнд, суралцах чадвар, бүтээмжид эерэг нөлөө үзүүлэх учир хүүхдийн хоол тэжээлийн дутагдал, өсөлтийн хоцрогдол, бичил тэжээлийн дутагдал, таргалалт зэрэг түгшүүр төрүүлж буй асуудлыг шийдвэрлэхэд анхаарч, төсвийн санхүүжилт болон олон салбарын оролцоог нэмэгдүүлэхэд НҮБ нөлөөлж ажиллана. КОВИД-19 цар тахлын дараах эх, хүүхдийн болон өсвөр үе, залуучуудын эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ зэрэгт тулгарч буй нийгмийн эрүүл мэндийн олон асуудлыг институцийн чадавхыг бэхжүүлэх замаар шийдвэрлэхэд анхаарна. Хүмүүсийн халааснаас гарч буй эрүүл мэндийн үйлчилгээний

зардлыг бууруулах зорилгоор эрүүл мэндийн санхүүжилтийн зохистой тогтолцоог бүрдүүлэх чиглэлд Засгийн газарт дэмжлэг үзүүлнэ. Эрүүл мэндийн тогтолцооны эрсдэл даах чадавхыг бэхжүүлэх хүрээнд “Алсын хараа-2050” бодлогын баримт бичигт туссан цахим эрүүл мэндийн үйлчилгээг хөгжүүлэх зорилтын дагуу эрүүл мэндийн тусламж үйлчилгээг илүү цахимжуулах, нотолгоонд суурилсан бодлого, шийдвэр гаргахад чиглүүлж, эрүүл мэндийн удирдлагын мэдээллийн системийг бий болгох, бэхжүүлэх чиглэлийг дэмжиж ажиллана. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүн бүрт хүргэх зорилтыг хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ эмзэг бүлгийн болон эмзэг бүс нутгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хэрэгцээг хангахад түлхүү анхаарал хандуулна. Боловсролын салбарын бодлого, стратеги төлөвлөгөөнд ТХЗ-4-ийн зорилтуудыг тусгах, улмаар тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих, ТХЗ-4-ийн шалгуур үзүүлэлтийг үндэсний түвшинд тооцож ахиц дэвшлийг үнэлэхэд хувь нэмэр оруулна. Илүү цогц байдлаар, урт хугацаанд үр дүн гаргах зорилгоор холбогдох сурталчилгаа, мэдлэг ойлголтыг сайжруулах, чадавх бэхжүүлэх, салбар дундын хөтөлбөрүүдийг (эрүүл мэнд, хоол тэжээл, засаглал, ус, ариун цэвэр, байгаль орчин зэрэг) дэмжих, ялангуяа эмзэг бүлгийн хүмүүс, бүс нутгуудад анхаарал хандуулах зэргээр бага насны хүүхдийг хөгжүүлэх тогтолцоог бэхжүүлэхэд хувь нэмэр оруулна. Хүн амын бүх бүлэгт эрх тэгш, хүртээмжтэй, чанартай боловсрол эзэмшихэд нь тэгш боломж олгох үүднээс нотолгоонд суурилсан, боловсролын салбарыг бүхэлд нь хамарсан төлөвлөлт, бодлогын дүн шинжилгээ, төсвийн хуваарилалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ



хийх, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, өсвөр үеийнхний боловсролд хамрагдалт, ирцийн зөрүүг арилгах зэрэгт чиглэсэн хөтөлбөрүүдийг НҮБ дэмжин хэрэгжүүлнэ. Боловсролын үйлчилгээний төлөвлөлт, хяналт-шинжилгээний хөтөлбөрүүдэд эцэг эхчүүд гол оролцогч талуудын нэг хэсэг болж оролцоно.

НҮБ нь гамшгийн эрсдэлийг бууруулах, хариу арга хэмжээ авах асуудлыг сургуулийн сургалтын хөтөлбөрт тусгахад анхаарч ажиллана. Түүнчлэн уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх боловсрол, тогтвортой хөгжлийн боловсролыг бүх түвшинд түгээх институцийн чадавхыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулна. Сургалтын арга зүй, сургалтын хөтөлбөр, арга хэрэглэгдэхүүнд өөрчлөлт шинэчлэл хийх замаар сургалтын үр нөлөөг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ. Монгол Улсад цахим хуваагдал үүсч байгааг хүлээн зөвшөөрөхийн хэрээр боловсролын бодлогын хүрээнд мэдээлэл, харилцааны технологийн бат бэх суурьтай цахим боловсролын тогтолцоог илүү хүртээмжтэйгээр хөгжүүлэх, улмаар эрсдэлийг даван туулах чадварыг бэхжүүлэх боловсролын мастер төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Үүний зэрэгцээ хүүхдийн цогц хөгжил, хүүхдэд бэлгийн цогц боловсрол олгоход танхимын сургалт чухал үүрэгтэй бөгөөд үүнийг цахим боловсролын тогтолцоо орлох боломжгүйг анхааруулж байна. Боловсролын салбарын цахим хувьсалд зориулсан мэдээлэл, харилцааны технологид шаардагдах багш нарын мэдлэг, ур чадвар, стандартыг бэхжүүлэхэд НҮБ хувь нэмрээ оруулна. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, сургуулийн орчноос хөдөлмөрийн талбарт төвөггүй шилжих, ур чадварыг дээшлүүлэх, техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалт, насан туршийн боловсролыг төлөвшүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн зохих ур чадвар, ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх зэрэгт чиглэсэн хөтөлбөрүүдийг дэмжинэ. Үндэсний мэргэшсэн мэргэжилтэн бэлтгэх хүрээнд дээд боловсролын салбарыг бэхжүүлэх, олгож буй дээд боловсрол, мэргэжлийг хүлээн зөвшөөрөх, магадлан итгэмжлэх, оюутан суралцагчдыг шилжин суралцах боломж нөхцөлийг сайжруулахад хувь нэмэр оруулна.

Нийгмийн болон хүүхэд хамгааллын цогц тогтолцоо нь ядуурлын түвшинг бууруулах, хүний нөөцийг хөгжүүлэхэд чухал хөрөнгө оруулалт

болх тул босоо, хөндлөн зэрэг төрөл бүрийн хамгааллын схемийг хэрэгжүүлэх, эдгээр схемд ялангуяа албан бус хөдөлмөр эрхлэгчид, малчид болон бусад эмзэг бүлгийн хүмүүсийг (тухайлбал ахмад настан) хамруулах, улмаар нийгмийн хамгааллын тогтолцооны бүх нийтийн шинжийг хадгалж, хүрээг нь тэлэх зэргээр нийгмийн хамгааллын тогтолцоог эрсдэл даах чадвартай, хямралд тэсвэртэй болгон хөгжүүлэхэд НҮБ дэмжлэг үзүүлнэ. Хүүхэд хамгааллын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчил гарсан тохиолдолд хариу арга хэмжээ авах, хүүхэд хамгааллын зөрчлийн зан үйл, нийгэм, соёл, эдийн засгийн тодорхойлогч хүчин зүйлсийг үр дүнтэй шийдвэрлэхэд чиглэсэн хүртээмжтэй тогтолцоог үргэлжлүүлэн дэмжинэ. Хүүхэд аливаа зөрчилд өртөж байгаа тохиолдолд дахин давтагдахаас сэргийлэх, тусламж дэмжлэг үзүүлэх, шударга ёсыг хангах хүрээнд хариу арга хэмжээ авч, хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх чадавхыг бэхжүүлэх зорилгоор НҮБ түншүүдтэйгээ хамтран ажиллана. Үүний зэрэгцээ нийгмийн хамгааллын зардлын үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн цахим хувьсал, үндэсний санхүүжилтийн нэгдсэн тогтолцоо, хямралын мэдрэмжтэй нийгмийн хамгааллын арга хэмжээний төсвийн орон зайг нэмэгдүүлэх, хүнсний болоод шатахууны үнийн өсөлтийн (Орос-Украины нөхцөл байдлаас шалтгаалсан) хямралтай тэмцэх зэрэг хөтөлбөрөөр дамжуулан үргэлжлүүлэн дэмжлэг үзүүлнэ.

Бодлого боловсруулах, амьдралд нөлөөлөхүйц хөгжлийн болон хүмүүнлэгийн хөтөлбөр, үйлчилгээг хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ хийх үйл ажиллагаанд эмзэг бүлгийн хүн ам, ялангуяа залуучуудын оролцох чадавхыг бэхжүүлэхэд НҮБ дэмжлэг үзүүлнэ.

Эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг хүчирхийллийн тохиолдлууд буурахгүй хэвээр байгааг анхааралдаа авч, Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенцийн хорооны болон Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлгийн зөвлөмжийн дагуу жендэрийн эрх тэгш байдлыг хангах хүрээнд хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлд НҮБ үргэлжлүүлэн ажиллана. Мөн эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний талаарх НҮБ-ын Тусгай илтгэгчийн зөвлөмжийг хэрэгжүүлэхэд Засгийн газарт дэмжлэг үзүүлнэ.

Улаанбаатар хот болон дийлэнх аймгийн төвүүдийн хяналт, төлөвлөлтгүй хотжилт, өргөжин тэлж буй гэр хорооллын гол шалтгаан нь дотоодын шилжилт хөдөлгөөн болж буйг хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ үндэсний болон орон нутгийн засаг захиргаа, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, дотоодын шилжилт хөдөлгөөний хандлага, урсгалыг шинжлэн судалж, шилжин суурьшигчдын эдийн засаг, нийгмийн ач холбогдолд үнэлгээ хийх замаар тэдгээрийн эмзэг байдлыг бууруулах, шилжин суурьшигчдыг илгээж буй болон хүлээн авч буй талуудад тэдний оруулж буй хувь нэмэр, хөгжлийн үр нөлөөг нэмэгдүүлэхэд анхаарч, дэмжиж ажиллана. НҮБ нь ялангуяа хотын

ядуу иргэдийн орон сууц, амьдрах нөхцөлийг сайжруулахад анхаарал хандуулж, хот, суурин газрын төлөвлөлтийг хотжилтын үр нөлөөг сайжруулах гол арга хэрэгсэл болгож бэхжүүлэхэд хувь нэмэр оруулна. Цар тахлын тархалт, түүний эсрэг авч хэрэгжүүлсэн хариу арга хэмжээний улмаас хамгийн их хохирсон хүн амын бүлгүүдийн нэг бол гадаадад байгаа монголчууд юм. Монгол Улсын хөгжилд оруулж буй тэдний хувь нэмэр мөнгөн гуйвуулга илгээхээр хязгаарлагдахгүй бөгөөд цаашид тэдний хөрөнгө оруулалтыг татах, нийгмийн асуудалд тусламж дэмжлэг авах зэрэг арга замаар тэдэнтэй шинэ арга барилаар хамтран ажиллахыг дэмжих шаардлагатай байна.

ТҮНШЛЭЛ



Энэхүү зорилтыг хэрэгжүүлэхэд салбарын яамд, агентлагууд, төрийн байгууллагууд, хөгжлийн түншүүд, хувийн хэвшил (гадаад, дотоодын) болон иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо, хамтын ажиллагаа нэн чухал болно. Түүнчлэн бүс нутгийн институцүүд, Өмнөд-Өмнөдийн болон гурван талт хамтын ажиллагаа нь дээрх зорилтыг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ. Иймээс НҮБ нь дараах оролцогч талууд, түншүүдтэй стратегийн түншлэл бий болгож, хамтран ажиллахын зэрэгцээ бусад талтай хамтран ажиллахад нээлттэй байх болно. Тухайлбал, Монгол Улсын төв, орон нутгийн захиргааны байгууллага, аймаг, сум, дүүрэг, хорооны захиргаа, Хүний эрхийн Үндэсний Комисс зэрэг хараат бүс байгууллага, хүний эрхийг хамгаалагчид, Жендэрийн үндэсний хороо, орон нутгийн болон дотоод, гадаадын төрийн бүс

байгууллага (хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн төлөө үйл ажиллагаа явуулдаг байгууллага гэх мэт), Олон улсын санхүүгийн байгууллага (ОУСБ) зэрэг хөгжлийн түнш, үйлдвэрчний эвлэл, хувийн хэвшлийн байгууллага, орхигдох эрсдэлтэй хүн амын бүлгүүдийг төлөөлөх олон нийтэд түшиглэсэн байгууллага, сургалтын байгууллага, бодлогын судалгааны төв, эрдэм шинжилгээний байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллага зэрэг олон талтай хамтран ажиллана. Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа (ТАБНЭЗХА) болон Ази, Номхон далайн орнуудын¹⁴ нийгмийн хамгааллын бүс нутгийн хамтын ажиллагааг бэхжүүлэх Үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бүс нутгийн хүрээний түншлэлийг дэмжинэ. Гол түнш байгууллагуудын жагсаалтыг Хавсралт-1 (Үр дүнгийн матриц)-д үзүүлэв.

¹⁴ НҮБ-ын АНДЭЭЗНК. (2021 оны 1-р сарын 13). Ази, Номхон далайн бүс нутгийн нийгмийн хамгааллын хамтын ажиллагааг бэхжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө. Мэдээллийг <https://www.unescap.org/kp/2021/action-plan-strengthen-regional-cooperation-social-protection-asia-and-pacific>

ТАВИГДАХ НӨХЦӨЛ

- ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд тулгарах хамгийн гол сорилт бол засаглал сул, санхүүжилт дутмаг явдал хэмээн тооцож, нийгмийн салбарын төсвийн хуваарилалт тогтвортой, хангалттай байх төсвийн орон зайг бүрдүүлэх, улмаар улс орны макро эдийн засгийн төлөв байдал таатай хэвээр байлгах.
- Нийгмийн салбарын хөтөлбөрүүдийн тогтвортой байдлыг сайжруулах, хамрах хүрээг тэлж, эрх тэгш байдлыг хангах үүднээс үр нөлөө, загварчлалыг сайжруулах улс төрийн хүсэл эрмэлзэлтэй, үүрэг амлалт авсан байх
- КОВИД-19 цар тахлын нөхцөл байдлыг хяналтдаа оруулсан, эрүүл мэндийн тогтолцоо нь цаашид гарч болзошгүй аливаа эрсдэлийг даах чадвартай хэвээр байх
- Үйлчилгээний хүртээмжийг сайжруулахад чиглэсэн цахим дэд бүтцийг хөгжүүлэхэд тулгарах томоохон саад бэрхшээл гарахгүй байх зэрэг нөхцөл бүрдсэн байх

НҮБ-ЫН УДИРДЛАГЫН БАГИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Энэхүү зорилтын хэрэгжилтийг НҮБ-ын системийн байгууллагууд, сан, хөтөлбөрүүд дэмжиж ажиллана. Үүнд: НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (ХХААБ), Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ), Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага (ОУШХБ), Олон улсын цахилгаан холбооны байгууллага (ОУЦХБ), НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газар (ХЭДКГ), НҮБ-ын ДОХ-ын нэгдсэн хөтөлбөр (ДОХ-ын НХ), НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах байгууллага (ГЭББ), НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс (АНДЭЗНК), НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (БШУСБ), НҮБ-ын Хүн амын сан (ХАС), НҮБ-ын Хүн амын суурьшлын хөтөлбөр (Хабитат), НҮБ-ын Хүүхдийн сан (ХС), НҮБ-ын Аж үйлдвэр хөгжлийн байгууллага (АҮХБ), НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба (МБГХТА), НҮБ-ын Төслийн үйлчилгээний

алба (ТҮА), НҮБ-ын Сайн дурын хөтөлбөр (СДХ), Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ).

Эдгээр байгууллага нь дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах мэдлэг туршлага, хөрөнгө нөөцийг дайчлан ажиллаж, хамтарсан хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх боломжийг мөн ашиглах болно. Эдгээр байгууллага нь (a) үйлчилгээ хүргэгчдийн чадавхыг бэхжүүлэх, (b) шинэлэг, цахим, нэгдсэн шийдлүүдийг олох, (c) эмэгтэйчүүд, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эсрэг хор уршиг учруулахуйц, ялгаварлан гадуурхах үйлдэл, хүчирхийллийг таслан зогсооход чиглэсэн нөлөөлөл сурталчилгаа хийх, (d) мэдлэг мэдээллийн сүлжээг ашиглах, (e) хүний болон хөдөлмөрлөх эрхийн талаарх ойлголт, мэдлэгийг сайжруулах, (f) “хэнийг ч орхигдуулахгүй байх” зарчмыг хөтөлбөрүүдийн удирдах зарчим болгох зэрэг чиглэлээр холбогдох талуудтай нягт хамтран ажиллана.





СТРАТЕГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 2: НОГООН, ХҮРТЭЭМЖТЭЙ, ТОГТВОРТОЙ ӨСӨЛТ

Үр дүнгийн зорилт 2:

2027 он гэхэд Монгол Улсын эдийн засаг илүү төрөлжсөн, шинэлэг, бүтээмжтэй, хүртээмжтэй, "ногоон" болж, бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг ханган, ялангуяа эмэгтэйчүүд, залуучуудын зохистой амьжиргааг тэтгэх, XXI зууны эрэлт хэрэгцээтэй ур чадварыг хөгжүүлэх, нүүрсхүчлийн хий бага ялгаруулах хөгжлийг дэмжинэ.

ӨӨРЧЛӨЛТИЙН ОНОЛ



Энэхүү зорилтыг хэрэгжүүлснээр гарах өөрчлөлтийн гол үзэл санаа нь Монгол Улс ногоон, хүртээмжтэй, тогтвортой өсөлтийн загварт шилжихийн тулд эдийн засгийг төрөлжүүлэх (салбар, газарзүйн хувьд) бодлого хэрэгжүүлж, эрдэс баялагт суурилсан эдийн засгийн хараат байдлаас ангижрах шаардлагатайг харуулж байна. Энэ нь илүү өрсөлдөх чадвар, бүтээмжтэй, агро-экологийн зарчмыг удирдлага болгосон хөдөө аж ахуйд суурилсан үйлдвэржилт, хувийн хэвшил, түүний дотор бичил болон жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийг хөгжүүлэх, улмаар технологи, санхүү, зах зээлд нэвтэрч, дотоодын болон олон улсын өртгийн сүлжээнд цахим худалдаагаар холбогдох зэрэг нөхцөлийг бүрдүүлэх; байгаль орчин, нийгэм, засаглалын стандартад нийцсэн хариуцлагатай хөрөнгө оруулалтыг дэмжих жендэрийн мэдрэмжтэй бодлого, хууль тогтоомж; XXI зууны эрэлтэд нийцсэн, бизнес эрхлэх ур чадварыг залуучууд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох, ур чадварыг дээшлүүлэх боломжийг бий болгох замаар хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг хангах институцийн чадавх; хүртээмжтэй цахим шилжилтийг дэмжих

хүрээнд үйлчилгээ хүрэхгүй байгаа бүс нутаг, салбаруудын цахим хуваагдлыг арилгахад чиглэсэн бодлого, хөрөнгө оруулалт; агро-эко аялал жуулчлал зэрэг эрс шинэлэг, байгальд суурилсан ногоон амьжиргааны боломжууд; тогтвортой бөгөөд уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй эрсдэлийг даах чадвартай мал аж ахуй эрхлэгчдэд нэмүү өртөг шингэсэн малын гаралтай бүтээгдэхүүн нийлүүлэх боломжийг бүрдүүлэх; эмэгтэйчүүд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн ур чадвар олгох сургалтууд болон бусад боломжууд; эмэгтэйчүүдийн цалин хөлсгүй халамж, асаргааны ажлын ачааллыг бууруулах, эмэгтэй эзэн, удирдлагатай БЖДҮ-г дэмжих, нийлүүлэлтийн сүлжээ тасалдахаас урьдчилан сэргийлэх, бараа бүтээгдэхүүний солилцоо, хүмүүсийн хөдөлгөөнийг саадгүй байлгахын тулд хил, гаалийн хамтын ажиллагааг сайжруулах; орлого, зарлагын хөдөлгөөнийг шуурхай хянах боломж бүрдүүлсэн, ил тод, хариуцлагатай төсвийн бодлого зэрэг олон арга хэмжээ авах шаардлагатайг нотлон харуулж байна.

ҮР ДҮНГИЙН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД НҮБ-ЫН ОРУУЛАХ ХУВЬ НЭМЭР

Монгол Улс тогтвортой хөгжлийн хэрэгжилтийг эрчимжүүлэх Үйл ажиллагааны арван жилийн хүрээнд хоцронгуй байгаа ТХЗ-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг илүү эрчимжүүлэх шаардлагатай байна. Үүний тулд НҮБ үндэсний санхүүжилтийн нэгдсэн тогтолцоог хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ ТХЗ-ын санхүүжилтийн бүтцийг бэхжүүлэхэд туслалцаа үзүүлнэ. НҮБ нь байгаль орчин, нийгэм, засаглалын стандартыг мөрдлөг болгосон, ТХЗ-д нийцсэн, жендэрийн мэдрэмжтэй хариуцлагатай хөрөнгө оруулалт хийхэд нь төр, хувийн хэвшлийг дэмжиж ажиллана. НҮБ нь Засгийн газар, Хөгжлийн банк, олон улсын болон дотоодын санхүүгийн гол байгууллагуудтай хамтран ажиллах замаар тогтвортой санхүүжилтийн бодлого, зохицуулалтын тогтолцоог бий болгоход хувь нэмрээ оруулж, мөнгөн гуйвуулга, гадаадын улс орнуудад шилжин суурьшсан монголчуудын хөрөнгө оруулалтыг татах зэргээр санхүүжилтийн хэрэгцээг нөхөх санхүүгийн эрс шинэлэг хэрэгслийг ашиглах боломжийг судална. Эдгээр арга хэмжээ нь ТХЗ-ыг хэрэгжүүлэх, дэд бүтцийн хөгжил, жендэрийн мэдрэмжтэй, ТХЗ-уудтай уялдсан төсвийн төлөвлөлт, хөрөнгө нөөцийн урсгалыг ил тод болгох зэрэгт ихээхэн хувь нэмэр оруулна гэж үзэж байна. Хүний эрхийн удирдах зарчмуудыг бизнесийн байгууллагуудад мөрдүүлэх, хүний эрхийн аливаа зөрчил гаргахгүй байх, гарсан тохиолдолд шуурхай арилгах арга хэмжээ авах зэргээр үүрэг хүлээгчдийн чадавхыг бий болгоход чиглэсэн хөтөлбөрүүдээр дамжуулан эдгээр арга хэмжээг дэмжинэ. Ялангуяа уул уурхай, дэд бүтцийн төслүүдийн хүрээнд орон нутгийн хүн амын бүлгүүд байгаль орчин, хүний эрхийн нөлөөллийн талаар бүрэн, зөв мэдээлэл авах механизмыг бэхжүүлж, тэдний мэдээлэл авах, мэдэх эрх, нөхөн төлбөр авах эрхийг хамгаалахад НҮБ дэмжлэг үзүүлэх болно.

Байгаль орчинд сөрөг нөлөөтэй уул уурхайн салбараас эдийн засгийн хамаарлыг бууруулахад НҮБ хувь нэмрээ оруулж, үндэсний тэргүүлэх чиглэл болох эдийн засгийг төрөлжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Цар тахлаас шалтгаалж тус улсын эдийн засгийн тогтворгүй байдал илүү даамжирсан нь эдийн засгийн төрөлжилт нэн чухал болохыг нотлон харуулж байна. Цар тахлын хямрал нь цаашид илүү хүртээмжтэй, ногоон,

дигитал хөгжлийг бий болгох боломжтойг мөн харуулсан. Монгол Улсын эдийн засагт хөдөө аж ахуй-үйлдвэрлэл, үйлчилгээний салбараас оруулах хувь нэмрийг нэмэгдүүлж, эдгээр салбарын бүтээмжийг сайжруулан, эмэгтэй, эрэгтэй хүмүүст зориулсан ажлын байрыг олон арга хэлбэрээр нэмэгдүүлэхэд нь Засгийн газарт дэмжлэг үзүүлнэ. Цар тахлын дараа хот, суурин газраас хөдөө, орон нутаг руу чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг дэмжих зохицуулалтыг бүс нутаг болон орон нутгийн хөгжилд хүний нөөцийг шинээр бүрдүүлэх чухал арга хэрэгсэл авч хэрэгжүүлж болохыг судалж үзэх шаардлагатай. Монгол Улсын эдийн засагт томоохон байр суурь эзэлж байгаа албан бус эдийн засгийг албан болгоход тулгарч буй сорилтуудыг шийдвэрлэх, албан бус хөдөлмөр эрхлэгчдийн санхүү зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх, шинэчлэлийг нэвтрүүлэх, тэдгээрийг өртгийн сүлжээнд (ноолуур, мах боловсруулах, нэхмэл эдлэл, арьс шир, сүү, үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн, гэх мэт) холбох, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулах зэргээр албан бус үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд, эмзэг бүлгийн хүмүүст чухал нөлөө үзүүлэх хууль, эрх зүйн актуудыг өөрчлөн шинэчлэх чиглэлд гарч буй үндэсний хэмжээний хүч чармайлтыг дэмжин ажиллана.

Монгол Улсын цахим худалдааг хөгжүүлэх бэлэн байдлын үнэлгээг хийж, эрсдэл даах чадварыг бэхжүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн зөвлөмж өгөх замаар цахим хувьсалд шилжихэд НҮБ хувь нэмэр оруулах болно. Аж үйлдвэрийн 4 дүгээр хувьсгал хийхэд шаардагдах мэдлэгт суурилсан шинэ эдийн засгийг бүтээх ур чадварын эрэлт хэрэгцээ бий болно. НҮБ-аас ялангуяа эмэгтэйчүүд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд шаардагдах ур чадварын хэрэгцээ, дутагдлыг тодорхойлох чиглэлд ажиллаж, зах зээлийн болон ХХI зууны эрэлтэд нийцсэн, “зөөлөн” бөгөөд хөрвөх чадвартай ур чадварыг бий болгох байгууллагуудын чадавхыг бэхжүүлэхийн төлөө хувийн хэвшилтэй хамтран ажиллана. Ингэснээр хүн амын үлэмж хэсгийг бүрдүүлж буй залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, хүн амын бүтэц болон газар зүйн байршлын чиг хандлагаас үүдэлтэй боломжуудын үр шимийг хүртэх болно.

ТҮНШЛЭЛ



Ногоон, хүртээмжтэй, тогтвортой өсөлтийг дэмжихэд хувь нэмэр оруулахын тулд түншүүдтэй хамтран ажиллах шаардлагатай. Төв, орон нутгийн засаг захиргаа, салбарын яамд хамтын ажиллагааны гол түншүүд байх болно. Эдийн засгийн өсөлт, хөдөлмөр эрхлэлтийн гол хөдөлгөгч хүч болох хувийн хэвшил (гадаад, дотоодын) чухал үүрэг гүйцэтгэнэ. НҮБ-аас дараах талуудтай нягт хамтран ажиллана. Үүнд: төв, орон нутгийн засаг захиргааны байгууллагууд, хувийн хэвшлийн үйлдвэрлэлийн болон мэргэжлийн нийгэмлэг, холбоод, үйлдвэрчний болон ажил олгогчдын холбоод, хувийн хэвшлийн банкууд, ОУСБ зэрэг хөгжлийн түншүүд, гадаад, дотоодын төрийн

бус байгууллагууд, боловсролын болон ур чадварын сургалтын байгууллагууд, судалгааны байгууллагууд, бодлогын судалгааны төвүүд, хэвлэл мэдээллийн байгууллагууд зэрэг талтай хамтран ажиллана. Түүнчлэн ТАБНЭЗХА; БНХАУ-Монгол Улс-ОХУ-ын Эдийн засгийн коридор; Зүүн хойд Азийн Супер сүлжээ зэрэг бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллага, НҮБ-ын АНДЭЗНК-ын хүрээнд худалдаа, дэд бүтцийн холбогдох гэрээ хэлэлцээр, сүлжээ, хөтөлбөрүүд, бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагуудтай хамтран ажиллана. Гол түнш байгууллагуудын жагсаалтыг Үр дүнгийн матриц (Хавсралт-1)-д үзүүлэв.

ТАВИГДАХ НӨХЦӨЛ

- Монгол Улсын ТХЗ-ын санхүүжилтийг босгох боломжийг хязгаарлаж болзошгүй учир Орос-Украины нөхцөл байдлаас болж нийт санхүүгийн урсгал, түүнчлэн төрийн болон хувийн хэвшлийн санхүүгийн удирдлага өөрчлөгдөхгүй байх,
- Нүүрсхүчлийн хий бага ялгаруулах зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд урт хугацааны эрс шинэчлэл хийх үүрэг амлалт авсан байх,
- Макро эдийн засгийн таатай орчин бүрдсэн, ерийн түвшин тогтворжсон, нийгмийн салбарын зарцуулалтад зориулсан төсвийн орон зай бүрдсэн байх,
- Дэд бүтцийн хөгжил, өртгийн шинэ сүлжээг бий болгох, инноваци, дижитал хувьсал зэрэгт хангалттай хөрөнгө оруулалт хийх,
- Хөрөнгө оруулалтын таатай, урьдчилан тооцоолж болохуйц орчин бүрдсэн, гадаад, дотоодын хувийн хөрөнгө оруулагчдын сонирхлыг татсан хэвээр байх,
- Олборлох үйлдвэрлэлийг илүү ил тод, байгаль орчинд ээлтэй, орон нутгийн хөгжилд хүртээмжтэй, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга зэрэг олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлэх хүсэл зорилго нь тодорхой байх зэрэг нөхцөл бүрдсэн байх.

НҮБ-ЫН УДИРДЛАГЫН БАГИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Энэхүү зорилтыг хэрэгжүүлэхэд дараах НҮБ-ын системийн байгууллагууд, сан, хөтөлбөрүүд дэмжиж ажиллана. Үүнд: НҮБ-ын ХХААБ, Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сан (ХААХОУС), ОУХБ, ОУШХБ, Олон улсын худалдааны төв (ОУХТ), ОУЦХБ, НҮБ-ын ХЭДКГ, НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (НҮБ-ын ХХБХ), НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (ХХ), НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр (БОХ), НҮБ-ын АНДЭЗНК, НҮБ-ын БШУСБ, НҮБ-ын ХАС, НҮБ-ын Хабитат, НҮБ-ын ХС, НҮБ-ын АҮХБ, НҮБ-ын ТҮА, НҮБ-ын СДХ. Эдгээр байгууллага нь дэвшүүлсэн зорилтыг хамтран хэрэгжүүлэхэд шаардагдах мэдлэг туршлага, хөрөнгө нөөцийг дайчлан ажиллаж, хамтарсан хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх боломжийг мөн

ашиглах болно. Эдгээр байгууллага нь (a) ТХЗ-уудтай уялдуулсан бодлого төлөвлөлт, төсвийн төлөвлөлт, хяналт-шинжилгээний тогтолцоог бүрдүүлэхийн тулд Үндэсний нэгдсэн санхүүжилтийн тогтолцоог салбарын яамдад нэвтрүүлэх чадавхыг бэхжүүлэх, (b) цахим худалдаа, эрс шинэчлэл, нэгдсэн шийдлүүдийг хамарсан цахим хувьсал хийх чиглэлд техникийн туслалцаа үзүүлэх, (c) нүүрсхүчлийн хий бага ялгаруулах хөгжлийн үйл явцад түргэн, шударгаар шилжих сурталчилгаа, (d) бүс нутгийн болон олон улсын мэдлэг мэдээллийн сүлжээг ашиглах, (e) “хэнийг ч орхигдуулахгүй” байх зарчмыг хөтөлбөрүүдийн баримтлах зарчим болгох зэрэг чиглэлээр холбогдох талуудтай нягт хамтран ажиллана.



Үр дүнгийн зорилт 3:

Нотолгоонд суурилсан, жендэрийн мэдрэмжтэй, байгалийн нөөц, байгаль орчны тогтвортой менежмент, гамшгийн эрсдэлийг бууруулах чадавх сайжирснаар 2027 он гэхэд Монгол Улсын хүн ам, экосистем уур амьсгалын өөрчлөлтөд илүү тэсвэртэй болсон байна.

ӨӨРЧЛӨЛТИЙН ОНОЛ



Энэхүү зорилтыг хэрэгжүүлснээр гарах өөрчлөлтийн гол үзэл санаа нь дараах шаардлага тулгарч байгааг нотлон харуулж байна. Тухайлбал, Монгол Улс уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор эдийн засгийн бүх салбарт эрсдэлийг даван туулж, дасан зохицох чадавхыг бий болгоход чиглэсэн жендэрийн мэдрэмжтэй төрийн бодлого, хууль тогтоомж, стратеги, институцийн механизмыг бүрдүүлэх; байгаль орчинд ээлтэй, сэргээгдэх эрчим хүч, технологийг нэвтрүүлэх, нүүрсхүчлийн хий бага ялгаруулах (ногоон) хөгжлийн үйл явцад шуурхай шилжих; байгалийн нөөцийн төвлөрсөн бус засаглалыг дэмжиж, газар, ой, усны нөөцийн тогтвортой менежментийн бодлого, арга туршлагыг нэвтрүүлж, малчдад чиглэсэн үр өгөөжтэй үйл ажиллагаа хэрэгжүүлэх замаар орон нутгийн удирдлагын чадавхыг бэхжүүлэх; газар нутгийн дарамт ачааллыг хөнгөвчилж, байгаль орчинд ээлтэй мал аж ахуйг хөгжүүлэхийн тулд малын тоо толгойг зохистой хэмжээнд хүртэл бууруулж удирдахад нь малчдад дэмжлэг үзүүлэх; нийгэм, байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд тулгуурлан уул уурхай, дэд бүтцийн салбарт хөрөнгө оруулалт хийж байгаа эсэх талаарх мэдээллийг орон нутгийн ард иргэдтэй ил тод хуваалцаж байх; гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгийн болон онцгой байдлын үед хариу арга хэмжээ авах орон нутгийн иргэдийн чадавхыг бий болгох; төсөл хөтөлбөрүүдийн байгаль орчинд үзүүлэх

нөлөөллийн талаарх мэдээллийн хүртээмжийг сайжруулах, байгалийн нөөцийн менежмент, гамшгийн эрсдэлийг бууруулах зэрэгт чиглэсэн уламжлалт арга мэдлэгээ ашиглах, шийдвэр гаргах үйл явцад эмэгтэйчүүдийг татан оролцуулах зэргээр байгаль орчны доройтол, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийн харьцангуй хүнд ачааг үүрч байгаа эмэгтэйчүүдийг чадавхжуулж эрх мэдлийг нь нэмэгдүүлэх; тогтвортой хөгжил, байгальд ээлтэй шийдлүүдтэй уялдуулж, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлөлтэй тэмцэх эрс шинэлэг нэмэлт санхүүжилт дайчлах нөхцөлийг бүрдүүлэх; байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхүйц хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл, хэрэглээнээс татгалзах талаарх олон нийтийн ойлголт, мэдлэгийг сайжруулж, зан үйлийн өөрчлөлтийг бий болгох; орон сууц, суурьшлын бүсүүд, агаарын чанар, хог хаягдлын менежмент, гамшгийн эрсдэлийг даах чадвар зэрэг хүн амын амьжиргаа, амьдрах орчны олон асуудлыг мэдрэмжтэйгээр шийдсэн илүү тогтвортой, хүртээмжтэй хот, суурин газруудыг хөгжүүлэх; байгаль орчны засаглал, мэдээлэл, хууль эрх зүйн орчны ялгаа дутагдлыг арилгах, байгалийн гамшиг, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй нүүлгэн шилжүүлэлтийн бэлэн байдлыг хангах, нүүлгэн шилжүүлтэд өртөж буй хүн амыг хамгаалах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

ҮР ДҮНГИЙН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД НҮБ-ЫН ОРУУЛАХ ХУВЬ НЭМЭР

НҮБ нь байгаль орчны засаглалын асуудалд илүү цогц, жендэрийн мэдрэмжтэй, нэгдсэн арга барилаар хандаж, Монгол Улсын Засгийн газар, оролцогч бусад талыг дэмжин, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг даван туулах, дасан зохицох замаар бууруулах, байгалийн нөөцийн тогтвортой удирдлага (газар, ус, биологийн олон янз байдал), арга туршлагыг хэрэгжүүлэх, гамшгийн эрсдэлийг мэдрэмжтэйгээр удирдах, хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлэх зэрэг чиглэлд хамтран ажиллана. Хөдөө аж ахуй, дэд бүтэц, эрчим хүч, тээвэр, ус ариун цэврийн байгууламж зэрэг салбарын бодлого, стратегид уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой асуудлыг тусгах замаар түүний сөрөг нөлөөллийг шийдвэрлэх чадавхыг нэмэгдүүлэх, үндэсний тодорхойлсон хувь нэмрийн хүрээнд дэвшүүлсэн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах талаарх үүрэг амлалтыг биелүүлэх, олон нийтийн эрсдэлд дасан зохицох чадавхыг бий болгох зэрэг чиглэлд талуудтай хамтран ажиллана. Гамшгийн үеийн нүүлгэн шилжүүлэлтийн эрсдэлийн бэлэн байдлыг хангах асуудлыг оролцуулан орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын уур амьсгалын өөрчлөлтөд мэдрэмжтэй хөгжлийн төлөвлөлт, санхүүжилт, хэрэгжилт, хяналт-шинжилгээ хийх чадавхыг нэмэгдүүлэх зэрэг чиглэлд Засгийн газарт дэмжлэг үзүүлнэ.

Монгол Улсын өргөн уудам бэлчээр, нутгийн дийлэнх нь янз бүрийн хэлбэрээр доройтож байгааг харгалзан, бэлчээрийн болон мал аж ахуйн тогтвортой удирдлагыг дэмжих, мал сүргийн тоо толгойг зохистой түвшинд хүргэж бууруулах замаар хөдөө аж ахуйн салбарын ялгаруулж буй метан хийн ялгарлыг хязгаарлахтай холбоотой орон нутгийн иргэд, орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын хүч чармайлт, байгальд ээлтэй, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний зах зээлд нэвтрэх боломжийг сайжруулах зэрэг чиглэлд хөтөлбөрийн дэмжлэг үзүүлж ажиллана.

Уул уурхайд түшиглэсэн эдийн засгийн үйл ажиллагаанд мөнгөн ус болон бусад аюултай химийн бодис ашигладаг нь газар, хөрс, ус, агаарын чанарыг доройтуулах, бохирдуулах гол шалтгаан болж, энэ нь орон нутгийн хүн амын эрүүл мэндэд ноцтой хүндрэл учруулж

байна. Иймд химийн хог хаягдлын тогтвортой менежментийг дэмжих чиглэлд хувийн хэвшил, орон нутгийн иргэд, Засгийн газартай хамтран ажиллана. Мөн эмнэлгийн хог хаягдлын аюулгүй менежмент, хот суурин газруудад хуванцар хог хаягдлыг дахин боловсруулах чиглэлд дэмжлэг үзүүлнэ.

Монгол Улс хөгжихийн хэрээр цаашид уур амьсгалд ээлтэй технологи нэвтрүүлэх, цэвэр эрчим хүч, байгалийн нөөцийг үр ашигтай боловсруулах, байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл, хэрэглээг дэмжих зэргээр нүүрсхүчлийг бага ялгаруулах хөгжлийн үйл явцад тууштай шилжих шаардлага тавигдана. Хаягдалгүй эдийн засгийг дэмжих хүрээнд хог хаягдлын үр ашигтай менежмент, дахин боловсруулалтын тогтолцоог бий болгох шаардлагатай болно. Монгол Улс нар, салхины эрчим хүчний арвин нөөцтэйг тооцон, эрчим хүчний эцсийн хэрэглээнд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийн жинг нэмэгдүүлж, түүхий нүүрсний хэрэглээнээс аажмаар татгалзах, улмаар сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, бүс нутаг болон дэд бүс нутгийн улс орнуудад экспортлох боломжийг нэмэгдүүлэхэд НҮБ-аас дэмжлэг үзүүлж ажиллана. Энэ нь ялангуяа хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүдийн эрүүл мэндэд хортой нөлөө үзүүлж буй агаарын бохирдлыг бууруулахад чухал хувь нэмэр болно.

Монгол Улс уур амьсгалын өөрчлөлт, байгалийн нөөцийн зохисгүй менежментээс үүдэлтэй гамшигт үзэгдлүүдэд эмзэг, өртөмтгий байна. Экосистем доройтож байгаагаас шалтгаалж, хөдөө, орон нутгаас хот, суурин газар руу хүн ам олноор шилжин суурьшиж, улмаар хөдөө, орон нутгийн эдийн засаг улам сульдахад нөлөөлж байна. Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээний дагуу олон нийтийн бүлгүүдийн гамшгийн эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлэхэд НҮБ дэмжлэг үзүүлнэ. Энэ хүрээнд үндэсний түвшинд хэрэгжүүлэх салбар дундын мэдээлэл солилцох, эрт сэрэмжлүүлэх цогц системийг бий болгох, эмзэг байдлын үнэлгээ хийх арга хэрэгсэл, болзошгүй аюул ослын зураглал гаргах, хүний амь нас, амьжиргааг хамгаалах, хөдөө орон нутагт орлого нэмэгдүүлэх, ажлын байр бий болгоход чиглэсэн

хөрөнгө оруулалт хийх, охид, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, эмзэг нөхцөлд байгаа өндөр настан зэрэг иргэдийг хамруулсан хямралын эсрэг нийгмийн хамгааллын үйлчилгээг бий болгох замаар төрөл бүрийн үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлж дэмжинэ.

Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй сорилтууд нь нийгэм, эдийн засгийг бүхэлд нь хамарч байгаа нь Монгол Улсын хөгжлийн үйл явцад томоохон бэрхшээл болж байна. Эдгээр сорилтыг шийдвэрлэхэд их хэмжээний санхүүжилт шаардлагатай бөгөөд түүнийг

төсөв бүрдүүлдэг ердийн эх үүсвэрээс олох боломжгүй. Санхүүжилтийн хэрэгцээг хангахын тулд хувийн хэвшлийнхэн, ялангуяа гадаадын хөрөнгө оруулагчдаар дамжуулан уур амьсгалын санхүүжилтийн эрс шинэлэг арга хэрэгслүүдийг ашиглах нь чухал юм. Дээр өгүүлсэн ТХЗ-ын санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэхэд чиглэсэн НҮБ-аас үзүүлж буй дэмжлэгтэй уялдуулан, техникийн туслалцаа, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой санхүүжилтийг дайчлах институцийн чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

ТҮНШЛЭЛ



НҮБ энэхүү зорилтыг хэрэгжүүлэхийн тулд шууд хамаарал бүхий холбогдох салбарын яамдтай хамтран ажиллана. Мөн дараах оролцогч талуудтай нягт хамтарна. Тухайлбал, төв, орон нутгийн засаг захиргааны болон судалгаа, шинжилгээний байгууллагууд, бодлогын судалгааны төвүүд, дотоод, гадаадын төрийн бус байгууллагууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн болон залуучуудын байгууллага, орон нутгийн (эрсдэлд өртсөн) бүлгүүд, сайн дурынхан, ОУСБ зэрэг хөгжлийн түншүүд, хувийн хэвшлийнхэн

үйлдвэрчний холбоод, хэвлэл мэдээллийн байгууллагууд зэрэг болно. Байгаль орчны зарим сорилт нь хил дамнасан болохыг НҮБ анхааралдаа авч, ТАБНЭЗХА болон НҮБ-ын АНДЭЗНК-ийн хүрээнд худалдаа, дэд бүтцийн холбогдох гэрээ хэлэлцээр, сүлжээ, хөтөлбөрүүд зэрэг бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагатай хамтран ажиллана. Гол түншлэгч талуудын жагсаалтыг Үр дүнгийн матриц (Хавсралт-1)-д үзүүлэв.

ТАВИГДАХ НӨХЦӨЛ

- Нүүрсхүчлийн хий бага ялгаруулах хөгжлийн замналыг сонгох улс төрийн хүсэл зориг гаргаж, үүрэг амлалт авсан байх, богино хугацааны эдийн засгийн ашиг сонирхлоор урт хугацааны хөгжлийн алсын харааг сааруулахгүй байх,
- Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй асуудлыг шийдвэрлэхийн тулд зах зээлд суурилсан арга хэрэгслээр дамжуулан санхүүжилт татах чадвартай байх,
- Байгаль орчин, гамшгийн эрсдэлийн асуудлаар мэдээлэл солилцох, тодорхой арга хэмжээ хэрэгжүүлэх чиглэлд бүс нутгийн болон хил дамнасан хамтын ажиллагааг түлхүү хөгжүүлэх зэрэг нөхцөл бүрдсэн байх.

НҮБ-ЫН УДИРДЛАГЫН БАГИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Энэхүү зорилтыг хэрэгжүүлэхэд дараах НҮБ-ын системийн байгууллагууд, сан, хөтөлбөрүүд дэмжиж ажиллана. Үүнд: ХХААБ, ХААХОУС, ОУХБ, ОУШХБ, ОУЦХБ, НҮБ-ын ХЭДКГ, НҮБ-ын ХХ, НҮБ-ын ГЭББ, НҮБ-ын БОХ, НҮБ-ын АНДЭЗНК, НҮБ-ын БШУСБ, НҮБ-ын Хабитат, НҮБ-ын ХС, НҮБ-ын АҮХБ, НҮБ-ын МБГХТА, НҮБ-ын ТҮА, НҮБ-ын СДХ, ДЭМБ. Эдгээр байгууллага дэвшүүлсэн зорилтыг хамтран хэрэгжүүлэхийн тулд шаардагдах мэдлэг туршлага, хөрөнгө нөөцийг дайчлан ажиллах бөгөөд хамтарсан хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх

боломжийг мөн ашиглана. Эдгээр байгууллага нь (a) үндэсний институцүүд, орон нутгийн бүлгүүдийн чадавхыг бэхжүүлэх, (b) шинэлэг, цахим, нэгдсэн шийдлүүд олох, (c) ногоон эдийн засгийг дэмжих, үнэлэхэд техникийн туслалцаа үзүүлэх, (d) мэдлэг мэдээллийн сүлжээг ашиглах, (e) хариуцлагатай үйлдвэрлэл, хэрэглээг дэмжих, (f) “хэнийг ч орхигдуулахгүй байх” зарчмыг хөтөлбөрүүдийн баримтлах зарчим болгох зэрэг чиглэлээр холбогдох талуудтай нягт хамтран ажиллана.





СТРАТЕГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 3: ХҮН ТӨВТЭЙ ЗАСАГЛАЛ, ЭРХ ЗҮЙТ ЁС, ХҮНИЙ ЭРХ

Үр дүнгийн зорилт 4:

2027 он гэхэд Монгол Улсын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл явц жендэрийн мэдрэмжтэй, оролцоог хангасан, харилцан уялдаатай, нотолгоонд суурилсан, ТХЗ-той уялдсан, бүх шатны засаглалын байгууллагууд ил тод, хариуцлагатай ажиллаж, хүний эрхийг бүрэн хангаж хамгаалсан, тэгш шударга, эрх зүйт ёсыг хүн бүр, ялангуяа орхигдох эрсдэлтэй хүн амын бүлгүүд ялгаваргүй эдлэх боломж нөхцөл бүрдсэн байна.

ӨӨРЧЛӨЛТИЙН ОНОЛ



Энэхүү зорилтыг хэрэгжүүлснээр гарах өөрчлөлтийн үндсэн үзэл санаа нь эрх зүйт ёс, хүний эрхийг дээдэлсэн, жендэрийн эрх тэгш байдлыг хангасан хүн төвтэй засаглалыг төлөвшүүлэхэд оршино. Үүний тулд дараах үндсэн шаардлагууд тавигдана. Тухайлбал, бодлогын болон төсвийн төлөвлөлт, үр дүнгийн хяналт шинжилгээ, тайлагналыг нотолгоонд үндэслэн, ТХЗ-уудтай нийцүүлсэн байх, чингэхдээ нарийвчилсан задаргаатай тоо мэдээллийн санг бий болгон, ашиглаж хэвших; институцийн тогтолцоо нь хүлээх үүрэг, эрхлэх үйл ажиллагааны хувьд уялдаатай, чадавхжсан, хариуцлагатай байх; шүүх эрх мэдлийн тогтолцоо, хууль сахиулах байгууллагууд, хүний эрхийн үндэсний механизмуудыг илүү бие даасан хараат бус, үр дүнтэй, жендэрийн мэдрэмжтэй, хүүхдэд ээлтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй, алагчлалд өртөх эрсдэлтэй хүн амын бүлгүүдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн байхаар илүү чадварлаг, боловсронгуй болгох; хууль сахиулах, урьдчилан сэргийлэх харга хэмжээ авах замаар авлига, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх; төрийн алба нь намын харьяалалгүй, илүү мэргэшсэн, чадахуйн (мерит) зарчимд суурилсан, хариуцлагатай байх;

Засгийн газарт хариуцлага тооцох хяналтын үүргийг үр нөлөөтэй гүйцэтгэж чадах чөлөөт, хараат бус хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байх; цахим шилжилтийг бодит ажил хэрэг болгох боломж нөхцөлийг бүрдүүлэх; иргэний оролцоо, сайн дурын үйл ажиллагааг дэмжих замаар үйлчилгээ, бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл явцад иргэний нийгэм, олон нийт, ялангуяа алагчлалд өртөх эрсдэлтэй хүн амын бүлгүүдийг утга учиртай оролцуулах, хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавихыг дэмжих; эрэгтэй, эмэгтэй хүмүүс, хүүхдийг хүн худалдаалах гэмт хэрэгт өртөхөөс сэргийлж, энэ төрлийн гэмт хэргийг таслан зогсоох; ялгаварлан гадуурхах зан үйл, хор уршиг учруулахуйц нийгмийн болон жендэрийн хэм хэмжээ, үзэн ядсан үг хэллэг, хуурамч мэдээлэл, худал мэдээлэлтэй хатуу тэмцэх; нийгэм, эдийн засаг, улс төрийн амьдралд эмэгтэйчүүдийн оролцоог хангах таатай орчин бүрдүүлэх; орон нутгийн хөгжлийн төлөвлөлт, төсвийн төлөвлөлтийн төвлөрлийг сааруулах, төрийн үйлчилгээг цогц хэлбэрээр эмзэг бүлгийн хүн амд хүртээмжтэйгээр саадгүй хүргэх зэрэг болно.

ҮР ДҮНГИЙН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД НҮБ-ЫН ОРУУЛАХ ХУВЬ НЭМЭР

НҮБ хүлээсэн эрх, үүргийнхээ хүрээнд нэгдсэн, уялдаа холбоо бүхий, нотолгоонд суурилсан, ТХЗ-уудтай нийцсэн хөгжлийн бодлого төлөвлөлт, төсвийн төлөвлөлт, үр дүнгийн хяналт-шинжилгээ, тайлагнал, хууль тогтоомж, бодлого хэрэгжүүлэх журам боловсруулах зэрэг чиглэлд үр дүнтэй институцийн механизм бий болгож, чадавх бэхжүүлэхэд нь Засгийн газарт дэмжлэг үзүүлнэ. НҮБ нь Тогтвортой хөгжлийн бодлого боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх, үр дүнгийн хяналт-шинжилгээ хийх зэрэг чиглэлд Засгийн газрын зохицуулалтын чадавхыг сайжруулахын төлөө ажиллана. Түүнчлэн эрс шинэлэг арга хэрэгслийг ашиглан ТХЗ-ын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, тайлагнахад шаардагдах мэдээллийн хэрэгцээг нөхөх тоо мэдээллийн экосистемийг бэхжүүлэх, улмаар ТХЗ-ыг үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөгөөтэй уялдуулан ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүд, зорилтуудыг үндэсний хөгжлийн тэргүүлэх чиглэл болгон бүрэн нутагшуулахад НҮБ-ын зүгээс дэмжлэг үзүүлнэ.

Засгийн газар, Хүний эрхийн Үндэсний Комисс, Жендэрийн үндэсний хороо, Хөдөлмөр, нийгмийн зөвшилцлийн гурван талт Үндэсний хороо зэрэгт хүний эрх, түүний дотор жендэрийн болон хөдөлмөрлөх эрх, Хүний эрхийн төлөв байдлын илтгэлийн зөвлөмжүүд, олон улсын хүний эрхийн гэрээгээр хүлээсэн үүргийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. НҮБ нь жендэрийн эрх тэгш байдал, гэр бүлийн хүчирхийлэл, жендэрт суурилсан хүчирхийлэл, хүүхдийн эрх, хөдөлмөрийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийг олон улсын хэм хэмжээнд нийцүүлэхэд нь Засгийн газарт дэмжлэг үзүүлж ажиллана. Түүнчлэн Монгол Улс 2009 онд соёрхон баталсан Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн заалтуудтай үндэсний хууль тогтоомжийг нийцүүлэх ажилд хувь нэмэр оруулна. Хүүхэд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эсрэг хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх, нийгмийн сөрөг хэм хэмжээ, гутаан доромжлох хандлагыг арилгахын төлөө үр дүнтэй тэмцэх, жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн Засгийн газрын үйл ажиллагааг дэмжин ажиллана. Эмзэг бүлгүүдийн

зарим хэсэгт эрх зүйн туслалцаа авах боломж хязгаарлагдмал байгааг харгалзан, Засгийн газар, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллаж, хүний үндсэн эрх болох “хамгаалагдах эрх”-ийг хамгаалах, ядуу, эмзэг бүлгийн хүн амд үнэ төлбөргүй эрх зүйн туслалцаа үзүүлэх тогтолцоог бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. НҮБ-ын Удирдлагын баг нь системийн байгууллагуудынхаа хамтаар хүний эрхийг хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавихад дэмжлэг үзүүлнэ.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг олж тогтоох арга хэмжээг эн тэргүүнд авч хэрэгжүүлэх нь дэмжлэг туслалцаа авах, нөхөн сэргээх үйлчилгээнд хамрагдах боломжийг тэдэнд олгох үндсэн алхам гэдгийг анхааралдаа авч, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг олж тогтоох, шилжүүлэх, тэдэнд тусламж үзүүлэхдээ хүний эрхэд суурилах, жендэрийн мэдрэмжтэй хандах талаар хууль сахиулах байгууллага, үйлчилгээ үзүүлэгчид болон бусад холбогдох эрх бүхий талын чадавхыг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ. Мөн хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүмүүсийг ажилд авахдаа шударга, ёс зүйтэй хандах зарчмыг удирдлага болгох чиглэлд аж ахуйн нэгж, байгууллагуудад хяналт тавихад нь Засгийн газарт дэмжлэг үзүүлнэ.

Эдийн засагт эрс шинэлэг технологи нэвтрүүлэх (Үр дүнгийн зорилт 2-т дурдсан), төрийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, дижитал бичиг үсгийн боловсролыг дээшлүүлэхийн зэрэгцээ хот, хөдөө, эрэгтэй, эмэгтэй хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй болон бэрхшээлгүй иргэдийн хооронд бий болсон дижитал хуваагдлыг арилгах, улмаар хөгжлийн үр шимээс хэнийг ч орхигдуулахгүй байхад чиглэсэн дижитал хувьслыг дэмжинэ. Энэ ажлыг Монгол Улсын цахим үндэстэн болох стратегитай уялдуулна. Нотолгоонд суурилж бодлого, шийдвэр гаргах, төлөвлөгөө боловсруулахад шаардагдах нарийвчилсан задаргаатай тоо мэдээллийн олдоц, чанар, ашиглалтыг сайжруулахад чиглэсэн үндэсний чадавхыг бэхжүүлэхэд НҮБ дэмжлэг үзүүлнэ.

Монгол Улсад иргэний нийгэм харьцангуй эрх чөлөөтэй орон зай эзэлж байгааг дэмжиж, бодлого шийдвэр гаргах үйл явцад ялангуяа эмэгтэйчүүд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн утга төгөлдөр оролцоог дэмжсэн иргэний орон зайг бий болгох, улмаар иргэний оролцоо, сайн дурын үйл ажиллагаа явуулах боломжийг өргөжүүлэхэд НҮБ дэмжлэг үзүүлэх болно. Хүн амын хөгжлийн асуудлаар

мэдээлэл цуглуулах, ашиглах чиглэлд үндэсний чадавхыг бэхжүүлэх, ялангуяа бодлого, шийдвэр гаргахад залуучууд болон тэдний төлөөллийн байгууллагуудын үр дүнтэй оролцоог дэмжих замаар хүн амын насны бүтцэд гарч буй өөрчлөлтийн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллана.

ТҮНШЛЭЛ



НҮБ хүний эрх, жендэрийн эрх тэгш байдлыг дээдэлсэн, эрх зүйт ёс, сайн засаглалыг дэмжсэн хүн төвтэй засаглалд хүрэх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд олон талын түншүүдтэй нягт хамтран ажиллана. Тухайлбал, УИХ-ын гишүүд, Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн яам болон чиг үүргийн яамд, агентлагууд, орон нутгийн засаг захиргаа, хууль сахиулах байгууллага, шүүх эрх мэдлийн байгууллагууд, эрх зүйн туслалцаа үзүүлэгч талууд, орон нутгийн байгууллагууд, иргэдийн төлөөлөгчийн хурлууд, Үндэсний статистикийн хороо, Хүний эрхийн Үндэсний Комисс, Жендэрийн үндэсний хороо, Улсын дээд шүүх, Сонгуулийн ерөнхий хороо, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах үндэсний зөвлөл, Төрийн албаны зөвлөл, дотоод, гадаадын төрийн бус байгууллагууд, Хөдөлмөрийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд, эмэгтэйчүүд, залуучуудын байгууллагууд, шашны болон сайн дурын байгууллага, бүлгүүд, ОУСБ зэрэг

хөгжлийн түншүүд, үйлдвэрчний эвлэлүүд, хөдөлмөрийн байгууллагууд, орхигдох эрсдэлтэй бүлгүүдийг төлөөлсөн, олон нийтэд түшиглэсэн байгууллагууд, сургалтын байгууллагууд, бодлогын судалгааны төвүүд, эрдэм шинжилгээний байгууллагууд, хэвлэл мэдээллийн байгууллагууд зэрэг олон талтай хамтран ажиллана. Хамтын ажиллагааны хүрээнд Варшавын тунхаглал, АЕУ (Ази-Европын уулзалт), ЕАБХАБ (Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага), ХЭҮБ-АНДЧ (Хүний эрхийн үндэсний байгууллагуудын Ази, Номхон далайн чуулган), Ази, Номхон далайн улс орнуудын Иргэний бүртгэл, мэдээллийн Үйл ажиллагааны хүрээ зэрэг бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагуудтай нягт хамтран ажиллах болно. Гол түншлэгч талуудын жагсаалтыг Үр дүнгийн матриц (Хавсралт-1)-д үзүүлэв.

ТАВИГДАХ НӨХЦӨЛ

- Олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүргийн дагуу Монгол Улс нь хүний эрхийг хамгаалах, жендэрийн эрх тэгш байдлыг хангах, дэмжих улс төрийн хүсэл эрмэлзэлтэй, үүрэг амлалт авсан байх,
- Бодлогын уялдаа холбоог илүү сайн хангаж, эрх зүйн тогтолцоо, хууль сахиулах механизм, төрийн албаны үйлчилгээг хамарсан засаглалын шинэчлэлийг Засгийн

газар үргэлжлүүлэн хийх,

- Засгийн газрын үйл ажиллагаанд иргэний нийгэм оролцож, хариуцлага тооцох орон зай бий болсон байх,
- Нарийвчилсан задаргаатай тоо мэдээллийн сан бий болж, нотолгоонд суурилсан бодлого шийдвэр гаргахад ашиглах боломж бүрдсэн байх.

НҮБ-ЫН УДИРДЛАГЫН БАГИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Энэхүү зорилтыг хэрэгжүүлэхэд дараах НҮБ-ын системийн байгууллагууд, сан, хөтөлбөрүүд дэмжиж ажиллана. Үүнд: ХХААБ, ОУХБ, ОУШХБ, ОУЦХБ, НҮБ-ын ХЭДКГ, НҮБ-ын ДОХ-ын НХ, НҮБ-ын ХХ, НҮБ-ын АНДЭЗНК, НҮБ-ын БШУСБ, НҮБ-ын ХАС, НҮБ-ын Хабитат, НҮБ-ын ХС, НҮБ-ын МБГХТА, НҮБ-ын ТҮА, НҮБ-ын СДХ, НҮБ-ын Эмэгтэйчүүд, ДЭМБ. Эдгээр байгууллага нь хамтын хүчээр шаардлагатай мэдлэг туршлага, хөрөнгө нөөцийг дайчлан, үүрэг хүлээгч, эрх эдлэгчидтэй хамтран дараах үр дүнг гаргах болно. Үүнд: (a) засаглалын

гол институцүүдийн чадавхыг бэхжүүлэх, (b) нийгмийн эв нэгдлийг дээдлэн таниулах, хор уршиг учруулахуйц, ялгаварлан гадуурхах зан үйл, нийгмийн хандлага, хэм хэмжээг таслан зогсоох, (c) дижитал хувьсал, нэгдсэн цогц үйлчилгээг хүргэхэд чиглэсэн мэргэжлийн дэмжлэг үзүүлэх, (d) бүс нутгийн болон олон улсын мэдлэг мэдээллийн сүлжээг ашиглах, (e) хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмыг хөтөлбөрүүдийн баримтлах зарчим болгох зэрэг чиглэлд холбогдох талуудтай нягт хамтран ажиллана.



2.4 Хамтын ажиллагааны хүрээний үр дүнгийн зорилтуудын уялдаа

Дээр дурдсан стратегийн тэргүүлэх гурван чиглэлийн хүрээнд дэвшүүлсэн үр дүнгийн дөрвөн зорилт бүр хоорондоо харилцан уялдсан бөгөөд ТХЗ-ууд болон үндэсний хөгжлийн тэргүүлэх зорилтуудын хэрэгжилтийг зохицуулалттайгаар эрчимжүүлэхэд нэгдмэл хувь нэмэр оруулна. Хүний хөгжлийг дэмжих зорилт нь эрүүл мэнд, хоол тэжээл, боловсрол, нийгмийн хамгааллын салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, үр дүнд нь хүмүүс өөрсдийн чадавхыг бүрэн ашиглаж, улс орны тэгш, хүртээмжтэй, тогтвортой, ногоон өсөлтийг бий болгоход хувь нэмэр оруулах боломж бүрдэх чухал ач холбогдолтой.

Уурамьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтол нь тогтвортой хөгжлийг хязгаарлаж байна. Цаг агаарын эрс тэс үзэгдлүүд, гамшгийн эрсдэлүүд, бохирдлоос шалтгаалсан эрүүл мэндийн сорилтууд нэмэгдэх болсон зэрэг нь хүмүүсийн сайн сайхан байдал, эдийн засгийн тогтвортой өсөлтөд ноцтой нөлөөлж байна. Байгаль орчны доройтол, эдийн засгийн өсөлтийн харилцан хамаарал нь Монгол Улс олборлох үйлдвэрлэлээс ногоон, нүүрсхүчлийн хий бага ялгаруулах өсөлт рүү шилжих шаардлагатайг харуулж байна. Цаашид тохиолдож болзошгүй байгалийн гамшиг, цар тахал нь хөрөнгө нөөцийг хөгжлийн бүтээн байгуулалтаас дайжуулж, онцгой байдлын үед авах арга хэмжээнд зарцуулахаас өөр аргагүйд хүргэн, нийгмийн үйлчилгээ (эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаалал)-нд хуваарилах Засгийн газрын төсвийн орон зайг хумиж, ТХЗ-уудын хэрэгжилт, Хамтын ажиллагааны хүрээ баримт бичгийн бүх үр дүнд сөргөөр нөлөөлж болзошгүй юм. Иймд гамшгийн эрсдэлийг даах чадвартай, бэлэн байдлыг хангасан байх нь энэхүү Хамтын ажиллагааны хүрээг амжилттай хэрэгжүүлэх нэн чухал нөхцөл болно.

Хүн төвтэй засаглал, эрх зүйт ёс, жендэрийн эрх тэгш байдал, хүний эрхийн асуудал зэрэг нь бүх чиглэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэрэгсэл байх болно. Хүний эрхийн хэм хэмжээ, стандартууд, жендэрийн эрх тэгш байдлыг хангаснаар илүү хүртээмжтэй хөгжлийг дэмжинэ. Хамтын ажиллагааны хүрээ нь засаглалын институцийг бэхжүүлэх, иргэдийн оролцоо, ялангуяа эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих, иргэдийн өмнө эрх баригчдын хүлээх хариуцлагыг нэмэгдүүлэхэд нөлөөлөх замаар эрүүл мэнд, боловсролын үйлчилгээг сайжруулах, ажлын байр бий болгох, нийгмийн хамгааллыг өргөжүүлэх, байгаль орчныг дээдлэх, “хэнийг ч орхигдуулахгүй” байхад хувь нэмэр оруулах болно. Цахим шилжилт, мэдээлэл солилцоо, институцийн болон олон нийтэд түшиглэсэн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх замаар илүү ил тод, эрсдэлийг даах чадварыг бий болгосноор Хамтын ажиллагааны хүрээнд дэвшүүлж буй зорилтуудын дагуу ТХЗ-ын хэрэгжилтийг эрчимжүүлэхэд хувь нэмэр болно.

Хамтын ажиллагааны бүхий л зорилтын хүрээнд орхигдох эрсдэлтэй хүн амын бүлгүүдэд анхаарал төвлөрүүлснээр хөгжлийн үр дүнг улам ахиулна.

Охид, эмэгтэйчүүдэд чиглэсэн чанартай, хүртээмжтэй боловсролд хөрөнгө оруулалт хийх нь эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалж, дэмжихийн зэрэгцээ эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг сайжруулах, тэдний хөдөлмөр эрхлэлтийн хэтийн төлөвийг илүү найдвартай болгож, хөгжихөд нь тусална. Энэ нь бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, нөхөн үржихүйн эрхийг хамгаалах зорилтуудыг хэрэгжүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ. Тэгш хамруулан сургах боловсролын үйлчилгээнд хөрөнгө оруулснаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн хэтийн төлөвийг сайжруулахад дэмжлэг болно.



ТХЗ-ын санхүүжилтийн тогтвортой бүтэц, нэгдсэн бодлого, тэдгээрийн уялдаа холбоог бүхий л зорилтын хүрээнд бэхжүүлснээр ТХЗ-уудыг хэрэгжүүлэх, хэнийг ч орхигдуулахгүй байх талд ахиц дэвшил гарна.

Хамтын ажиллагаа, уялдаа холбоог хангах механизмын хувьд НҮБ-ын Тогтвортой

хөгжлийн хамтын ажиллагааны хүрээний (НҮБ-ын ТХХАХ) Үр дүнгийн бүлгүүд, Сэдэвчилсэн багууд, Хөтөлбөрийг дэмжих ажлын хэсгүүдийг байгуулж ажиллах бөгөөд тэдгээр нь хариуцсан асуудлынхаа хүрээнд НҮБ-ын Удирдлагын багт тогтмол тайлагнах үүрэг хүлээнэ.

2.5 Тогтвортой байдал

Энэхүү Хамтын ажиллагааны хүрээний стратегийн тэргүүлэх чиглэлүүд, зорилтуудыг тодорхойлж, боловсруулахдаа Монгол Улсын Засгийн газар, бусад оролцогч талтай хамтран хэлэлцэж, үндэсний хөгжлийн алсын хараа, стратегийн тэргүүлэх чиглэлүүдтэй уялдуулан, үндэсний хэмжээнд зөвшилцөлд хүрсэн нь тус хөтөлбөрийн хүлээгдэж буй үр дүнгийн тогтвортой байдлыг хангах суурь болж байна. Хамтын ажиллагааны хүрээ нь “Алсын хараа-2050” бодлогын баримт бичигт туссан үндэсний хөгжлийн тэргүүлэх зорилтуудтай, ялангуяа “Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөр”-тэй давхцаж буй 1 дүгээр үе шат (2021-2030)-ны зорилтуудтай нягт уялдсан болно. Монгол Улс “Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх үйлсийг манлайлж буй улс орнуудын нэг бөгөөд ТХЗ-ын зорилтууд, шалгуур үзүүлэлтүүдийг үндэсний түвшинд тодорхойлж, үндэсний болон орон нутгийн

хөгжлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх алхмуудыг хийж байна. Монгол Улсын Засгийн газар “Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах талаар хариуцлагатай хандан, тууштай санаачилгатай ажиллаж байна. НҮБ-аас Монгол Улсын Засгийн газарт КОВИД-19 цар тахлын эсрэг эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн хариу арга хэмжээ авах чиглэлд дэмжлэг үзүүлж, талуудын харилцан итгэлцлийг улам бэхжүүлж, ТХЗ-ыг амжилттай хэрэгжүүлэх институцийн механизмын тогтвортой байдлыг тодорхой хэмжээгээр шалгасан. Засгийн газар цар тахлын хямралыг даван туулахын төлөө идэвхтэй ажиллаж буй энэ үед НҮБ-аас Монгол Улсыг “илүү сайнаар сэргээн цогцлоох”-д хувь нэмэр болох хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, эрсдэл даах чадвартай, тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх болно.



Хонгорын элс. Өмнөговь аймаг. Зургийг Б. Баяр

НҮБ үндэсний болон орон нутгийн түвшний байгууллагуудын чадавхыг үргэлжлүүлэн бэхжүүлж, тогтвортой байдалд хувь нэмэр оруулна. Хүний эрх, жендэрийн эрх тэгш байдлыг хангах, байгаль орчны олон талт гэрээ хэлэлцээрийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь Монгол Улсын Засгийн газарт дэмжлэг үзүүлэх зорилгоор 2027 оноос цааших тогтвортой байдлыг хангахад чиглэсэн техникийн туслалцаа үзүүлэх, хяналт-шинжилгээ, тайлагналын чадавхыг бэхжүүлэх замаар институцийн механизм бий болгон, бэхжүүлэхэд НҮБ хувь нэмэр оруулна. Хүний эрх, жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиг үүрэг бүхий институцийн чадавхыг бэхжүүлэх хэлбэрээр эмзэг бүлгийн хүмүүсийн эрхийг зөрчихгүй байх, "хэнийг ч орхигдуулахгүй байх" зарчмыг удирдлага болгон чанд баримталж, эмзэг бүлгийн хүмүүсийн эрхийг тогтвортой сайжруулах нөхцөлийг бүрдүүлнэ.

Үндэсний санхүүжилтийн нэгдсэн тогтолцоог бий болгох нь хөтөлбөрийн үр дүн тогтвортой үргэлжлэхэд томоохон хувь нэмэр оруулах болно. НҮБ нь ТХЗ-уудтай уялдуулсан бодлого шийдвэр, төсвийн төлөвлөлт, санхүүжилт хариуцсан гол оролцогч талуудыг чадавхжуулах замаар төр,

хувийн хэвшлийн санхүүжилтийн бүхий л хүрээг хамарсан иж бүрэн зураглал гаргахад дэмжлэг үзүүлнэ. Энэ нь хэдийн боловсруулаад буй тогтвортой хөгжил, ногоон эдийн засагт чиглэсэн татвар (таксоном)-ыг дэмжих хувийн хэвшлийн санхүүжилтийн эрс шинэлэг арга хэрэгслийг ашиглах боломжийг бодлого шийдвэр гаргагчдад олгох юм.

Бодлогын уялдаа холбоог хангах, бодлого шийдвэр гаргах зэрэг нь Хамтын ажиллагааны хүрээний бүх зорилгод хамаарах бөгөөд нарийвчилсан задаргаатай тоо мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, ашиглах чадавхыг бэхжүүлэх замаар нотолгоонд суурилсан бодлого шийдвэр гаргах, улмаар тогтвортой үр дүнд хүрэхэд чухал хувь нэмэр болно.

НҮБ-ын хамтын хүчийг нэгтгэх чадвар, туршлага нь талуудад алсын хараагаа хамтдаа тодорхойлоход дэмжлэг болохын зэрэгцээ оролцогч талууд нэгдмэл нэгэн хүч болж, үйл ажиллагаагаа уялдуулан нягтруулж, давхардалгүй, өөр хоорондоо өрсөлдөөнгүй байснаар хамтын ажиллагаа үр дүнд хүрч, улс орны тогтвортой байдалд үнэтэй хувь нэмэр оруулна.

2.6 Хил дамнасан болон бүс нутгийн хамтын ажиллагаа

Монгол Улс нүүрс, эрдэс баялгийн экспортоос ихээхэн хамааралтай, цөөн хэдэн улсад бүтээгдэхүүн экспортолдог, далайд гарцгүйгээс үүдсэн дэд бүтцийн саад бэрхшээл ихтэй зэргээс шалтгаалан тус улс бүс нутгийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх зайлшгүй шаардлага урган гарч байна. Цар тахлын улмаас БНХАУ-тай хиллэдэг хилийн боомтууд удаан хугацаагаар хаагдсан нь Монгол Улсын эдийн засагт хүндээр тусч, хил дамнасан хамтын ажиллагаа нэн чухал болохыг улам бүр тодотгов. Хил дамнасан эдийн засаг, байгаль орчны асуудлууд, үр тарианы болон малын өвчний дэгдэлт, элсэн болон шороон шуурга, цөлжилт, хил дамнасан усны менежмент, бусад орчны эрүүл мэндийн асуудлууд зэрэгт бүс нутгийн түвшинд цаашид анхаарал хандуулах шаардлагатай байна.

Аюулгүй, дэг журамтай, хэвийн шилжилт хөдөлгөөнийг зохицуулах замаар шилжилт хөдөлгөөний үр нөлөөг сайжруулах, улмаар шилжих хөдөлгөөний гарах урсгалыг үүсгэж байгаа илгээгч, дамжин өнгөрөх, хүлээн авагч улс

орнууд хоорондын хамтын ажиллагааг сайжруулж зохисгүй шилжих хөдөлгөөн үүсэх нөхцөл, сөрөг нөлөөллийг бууруулах гол арга зам нь хил орчмын хамтын ажиллагааг өргөжүүлэх асуудал хэмээн тодорхойлсон Аюулгүй, дэг журамтай, хэвийн шилжилт хөдөлгөөний талаарх Даян дэлхийн гэрээг Монгол Улс хүлээн авч батлан дэмжиж байна. Монгол Улсад шинээр байгуулагдсан НҮБ-ын Шилжилт хөдөлгөөний сүлжээгээр дамжуулан энэхүү Даян дэлхийн гэрээг хэрэгжүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэх байр суурийг НҮБ-ын системийн байгууллагууд баримталж байна.

Чадавхжсан, идэвхтэй бүс нутгийн албан ёсны институцүүд тус улсад суурин ажиллахгүй байгаа нь хоёр талын харилцан ашиг сонирхолд тулгуурласан, хамтын ажиллагааг тодорхой хугацаагаар хөгжүүлэх боломжийг (гарц, суваг) тодорхойгүй болгож байгаа тул Монгол Улс тайван замаар ардчилсан шилжилт хийх, чөлөөт сонгууль явуулах, хүний эрхийг дээдлэх зэргээр олон улсын түвшинд нэр хүндээ өндөр хэвээр байлгахад улам анхаарах хэрэгтэй.



Хөвсгөл нуур нь Монголын хамгийн цэнгэг уст, гүн нуур бөгөөд дэлхийн цэнгэг усны 0.4 хувьтай тэнцэнэ. Зургийг Б. Баяр

Монгол Улс бүс нутгийн хамтын ажиллагаанаас худалдаа, тээвэр, байгаль орчин, ус, гамшгийн эрсдэлийг бууруулах, шилжилт хөдөлгөөн, эрчим хүч, зам тээвэр, эрсдэлийг даах чадварын сүлжээ, хүн амын статистик, дижитал хувьсал, аялал жуулчлал зэрэг олон салбарт үр өгөөж хүртэх боломжтой. Монгол Улс бүс нутгийн хэлэлцээрүүд, түүний дотор Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрт болон хамтын ажиллагааны бусад механизмд нэгдэх чиглэлд идэвхтэй ажиллаж, хүч чармайлт гаргаж байгаа нь бүс нутагтаа гол тоглогчийн үүрэг гүйцэтгэх, улмаар дамжин өнгөрөх улс болох боломжоо ахиулах эрмэлзэлтэй байгааг харуулж байна.

Монгол Улс дахь НҮБ-ын байгууллагууд нь холбогдох хэлэлцээрүүдийн заалтуудтай нийцүүлэн, бүс нутгийн байгууллагуудтай хамтын

ажиллагааг өргөжүүлж, хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, хууль бус санхүүгийн урсгалаас сэргийлэх, тэмцэх зэрэг чиглэлд хамтран ажиллахын зэрэгцээ Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын Венийн Үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх болно. НҮБ нь Өмнөд-Өмнөдийн болон гурван талт хамтын ажиллагаа зэрэг Монгол Улсад ашиглах боломжтой хил дамнасан асуудлаарх олон талт хамтын ажиллагааны мэдлэг туршлага, мэдээллийн солилцоог дэмжин ажиллана. Бүс нутгийн худалдаа, эдийн засгийн интеграцчилалд нэгдэх, БНХАУ-Монгол Улс-ОХУ-ын Эдийн засгийн коридор зэрэг нь "Алсын хараа - 2050" бодлогын баримт бичгийн бүс нутгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх тэргүүлэх зорилтуудад туссан болно.

2.7 НҮБ-ын Удирдлагын багийн харьцангуй давуу тал, зохицуулалт

Монгол Улс дахь НҮБ-ын Удирдлагын баг нь тус улсад суурин 9, суурин бус 14 байгууллага, сангийн төлөөллөөс бүрдэж байна. НҮБ-ын системийн эдгээр 23 байгууллага нь энэхүү Хамтын ажиллагааны хүрээ баримт бичигт гарын үсэг зурсан болно¹⁵. Монгол Улс дахь НҮБ-ын Удирдлагын баг нь хөтөлбөр, үйл ажиллагааны асуудлаар эдгээр байгууллага хоорондын зохицуулалт, шийдвэр гаргах үйл явцыг бүхэлд нь хариуцан ажиллах үндсэн механизм болно. Монгол Улс дахь НҮБ-ын Удирдлагын багийг Суурин зохицуулагч тэргүүлж, Хамтын ажиллагааны хүрээ баримт бичгийн алсын хараа, үр дүнгийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд нь тус багийг удирдан чиглүүлж, хэрэгжилтийн явц, үр дүнг Монгол Улсын Засгийн газар болон бусад оролцогч талд Хамтарсан Удирдах хороо (ХУХ)-гоор дамжуулан тайлагнаж, шаардлагатай тохиолдолд НҮБ-ын Удирдлагын баг хамтран хэлэлцэж, зохих өөрчлөлтийг хийнэ.

Түүнчлэн 1). Монгол Улс дахь НҮБ-ын систем нь Хамтын ажиллагааны хүрээ, “хэнийг ч орхигдуулахгүй байх” гэсэн хамтын амлалтыг хэрэгжүүлэхэд шаардагдах чадавх, нөөц, бизнесийн загвартай, зохих байр суурьтайг баталгаажуулах; 2). Монгол Улсын “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, үндэсний хөгжлийн дунд болон богино хугацааны хөтөлбөр, төлөвлөгөөнд туссан үндэсний хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдтэй уялдуулан, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрүүдийн зохицуулалтын ил тод байдал, өгөөж, үр нөлөөг сайжруулж, улмаар НҮБ-ын хөгжлийн системийн шинэчлэлийн тухай НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тогтоолд туссан “хэрэгцээнд-тулгуурласан, улс орны нөхцөл байдалд тохирсон байх” зарчмын дагуу НҮБ-ын Удирдлагын багийн зохицуулалтад үнэлгээ өгөх зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн болно¹⁶.


Чингэхдээ НҮБ-ын системийн байгууллагууд оролцооны аргыг ашиглан өөрсдийн мэргэшсэн салбарын бодлогын болон олон улсын хэм хэмжээ, стандартын талаарх мэдлэг туршлага, бодлого боловсруулах, хэрэгжүүлэх талаар зөвлөх

үйлчилгээ үзүүлэх, мэдлэг хуваалцах, удирдах, үндэсний болон олон улсын сүлжээ, түншлэлд нэгдэх, оролцох, харилцаа холбоо, нөлөөллийн үйл ажиллагаа явуулах, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх зэрэг чиглэлээр бие даасан чадавхын үнэлгээ хийсэн. Мөн НҮБ-ын системийн байгууллагууд өөрсдийн бизнесийн загварыг хэвээр үргэлжлүүлэхэд тодорхой өөрчлөлт гаргаж чадах эсэхэд дүгнэлт хийж, хариулт олох үүрэг авсан болно. Тодорхой асуулгаар мэдээлэл цуглуулан, НҮБ-ын Удирдлагын багийн зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж, НҮБ-ын системийн байгууллагуудын чадавх, үйл ажиллагааны хөрөнгө нөөцийн зөрүүтэй байдал, уялдаа холбоо, давхардал зэргийг тодорхойлж, хамтын ажиллагаандаа тодорхой зохицуулалт хийх шаардлагатай талаар санал нэгдсэн. Энэхүү зохицуулалтыг НҮБ-ын Удирдлагын багийг төлөөлөн НҮБ-ын Суурин зохицуулагч Монгол Улсын Засгийн газарт танилцуулж баталгаажуулсан болно.

Энэ нь Монгол Улс дахь НҮБ-ын Удирдлагын баг хамтын болон дагнасан мэргэжлийн чадвар, мэдлэг, туршлагадаа тулгуурлаж, энэхүү Хамтын ажиллагааны хүрээ баримт бичигт дэвшүүлж буй зорилго, зорилтуудыг бүрэн хэрэгжүүлэх боломжтой гэж Засгийн газар болон оролцогч бусад тал үзэн, итгэл хүлээлгэж буйн илэрхийлэл болсон. НҮБ-ын системийн байгууллагууд шаардлагатай тохиолдолд тусламж дэмжлэг авах бүс нутгийн албад болон төв байгууллагууд нь өргөн хүрээний мэргэшсэн байдал, зохих туршлага, санхүүгийн нөөцтэй болно. НҮБ Монгол Улсын Засгийн газартай олон жилийн турш нягт хамтран ажиллаж, үндэсний хөгжлийн сорилтуудыг даван туулахад нь байнга, итгэлтэй, тууштай дэмжлэг үзүүлж ирснийг онцлон тэмдэглэж байна. Олон улсын хүний эрхийн хэм хэмжээ, үнэт зүйлсийг сахин хамгаалагчийн хувьд НҮБ нь хөгжлийн үр шимээс “хэнийг ч орхигдуулахгүй байх” зарчмыг удирдлага болгон, хүний эрхэд суурилан хөгжих чиг хандлагыг сурталчлан таниулах, дэмжих байр суурь баримталж байна.

¹⁵ ХХААБ, ОУХААХС, ОУХБ, ОУШХБ, ОУХТ, ОУЦХБ, НҮБ-ын ХЭДКГ, НҮБ-ын ДОХ-ын НХ, НҮБ-ын ХХБХ, НҮБ-ын ХХ, НҮБ-ын ГЭББ, НҮБ-ын БОХ, НҮБ-ын АНДЭЗНК, НҮБ-ын БШУСБ, НҮБ-ын ХАС, НҮБ-ын Хабитат, НҮБ-ын ХС, НҮБ-ын АҮХБ, НҮБ-ын МБГХТА, НҮБ-ын ТҮА, НҮБ-ын СДХ, НҮБ-ын Эмэгтэйчүүд, ДЭМБ.

¹⁶ НҮБ-ын Ерөнхий Ассамблейн Тогтоол 72/279, зүйл 2.



НҮБ-аас хэрэгжүүлж буй хөгжилд чиглэсэн туслалцаа, хөгжлийн асуудлаарх яриа хэлэлцүүлгийг өргөн хүрээнд зохион байгуулахад үзүүлж буй дэмжлэг, Монгол Улсын Тогтвортой хөгжлийн Үндэсний зөвлөлд НҮБ-ын Суурин зохицуулагч нь НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудын төлөөлөл болон оролцож байгаа зэрэг нь “Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөр”, ТХЗ-ыг амжилттай хэрэгжүүлэхэд давуу тал болж байна. НҮБ нь бүс нутгийн болон олон улсын түвшний албадын дэмжлэгтэйгээр хил дамнасан түншлэл, хамтын ажиллагаанд тодорхой хувь нэмэр оруулах боломжтой. Үндэсний хэмжээнд нэн чухал хэрэгцээ шаардлага гарах үед буюу онцгой байдлын үед НҮБ шуурхай хариу арга хэмжээ авч ирснийг КОВИД-19 цар тахлын тархалт, зудын эсрэг авч хэрэгжүүлсэн арга хэмжээний туршлагаудаас харж болно.

Талуудын нийтлэг ашиг сонирхлын зарим салбар (тухайлбал нийгмийн чанартай үйлчилгээ, ногоон эдийн засаг, сэргээгдэх эрчим хүч, дижитал шилжилт, уур амьсгалын өөрчлөлт, залуучуудыг эрх мэдэлжүүлэх, хүний эрх, жендэр, сайн засаглал)-ыг тодорхойлсон хэдий ч Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээ баримт бичгийг хэрэгжүүлэхэд НҮБ-ын системийн байгууллагуудын зохицуулалтад нөлөөлж болохуйц аливаа давхардал байхгүй гэж НҮБ-ын Удирдлагын баг үзэж байна. Монгол Улсын Засгийн газрын саналд үндэслэн үндэсний тэргүүлэх зорилтуудын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэхдээ НҮБ-ын Удирдлагын баг, төрөлжсөн байгууллагууд нь мэдлэг, туршлагад түшиглэн худалдаа, гамшгийн эрсдэлийн удирдлагын чиглэлд хэрэгжүүлэх үйл ажиллагаагаа цаашид улам бэхжүүлнэ. Түүнчлэн, бүс нутгийн Асуудлыг шийдвэрлэх багт оролцох нь нийтлэг ашиг сонирхлын чиглэлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх өргөн боломжийг олгоно. НҮБ-ын Удирдлагын баг нь энэхүү хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх гол хөтөлбөрүүдийн

баримтлах зарчмууд, хүний эрх, жендэрийн эрх тэгш байдал гэсэн салбар дундын асуудлуудыг хангах чиглэлд ажлын уялдаа холбоог илүү хангах шаардлагатайг тэмдэглэж байна.

НҮБ-ын Удирдлагын баг нь шинээр үүсэх нөхцөл байдлын эсрэг авах хариу арга хэмжээг өргөжүүлэхийн зэрэгцээ систем дотроо болон хөгжлийн бусад түншийн хамтын ажиллагаа, ажлын уялдаа, зохицуулалтыг илүү сайжруулна. Хамтын ажиллагааны хүрээг хэрэгжүүлэхэд суурин бус НҮБ-ын системийн байгууллагуудын оролцоог бүрэн хангахад онцгой анхаарал хандуулна. НҮБ нь Үр дүнгийн бүлгүүд хоорондын ажлын уялдаа, зохицуулалтыг сайжруулах болно. НҮБ нь хамтын ажиллагааг сайжруулахын тулд бүс нутгийн түвшин дэх “Асуудлыг шийдвэрлэх эвсэл”-ийн бүлгээс системийн байгууллага тус бүрийн бүрэн эрхээс давсан сорилтод хэрхэн хариу арга хэмжээ авах талаар олон улсын сайн туршлагад тулгуурлан тодорхой удирдамж боловсруулахыг дэмжинэ. НҮБ-ын Удирдлагын баг нь уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг сааруулах, бэлэн байдлыг хангах чиглэлээр Асуудлыг шийдвэрлэх эвслийн бүлэгтэй нягт хамтран ажиллана. Бүлгүүдийн ажлын уялдаа холбоог сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Суурин зохицуулагчийн албаны чадавхыг бэхжүүлнэ. НҮБ хамтарсан хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, боломжтой бүх нөхцөлд үйл ажиллагааны хамтарсан хэлбэрийг ашиглах замаар өртөг зардал хэмнэж ажиллана. НҮБ-ын Удирдлагын багийн зохицуулалтад жил бүр үнэлгээ хийх бөгөөд НҮБ-ын системийн байгууллагуудын зүгээс Хамтын ажиллагааны хүрээний үр дүнгийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд нөлөөлж болзошгүй ямар нэгэн зохицуулалтын өөрчлөлт орох тохиолдолд НҮБ-ын Удирдлагын багт мэдэгдэж байх үүрэг хүлээнэ.

3 БҮЛЭГ

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ





НҮБ-ын Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээ баримт бичигт гарын үсэг зурав.
Зургийг НҮБ-ын Суурин зохицуулагчийн газар.

3.1 Засаглал

3.1.1 Ерөнхий зохицуулалт

Монгол Улсад хэрэгжүүлэх Хамтын ажиллагааны хүрээний ерөнхий зохицуулалтыг Монгол Улсын Гадаад харилцааны яам хариуцна. НҮБ-ын системийн байгууллагууд, сангууд, хөтөлбөрүүд (суурин болон суурин бус) нь НҮБ-ын Удирдлага, хариуцлагын тогтолцооны (MAF) хүрээнд НҮБ-ын Суурин зохицуулагчийн ерөнхий удирдлага дор Засгийн газрын холбогдох яамд, газруудтай хамтран ажиллана. Монгол Улс дахь НҮБ-ын байгууллагууд нь НҮБ-ын Дүрэмд заасан хэм хэмжээ, чиг үүргийн дагуу үйл ажиллагаагаа уялдуулж, хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмыг мөрдлөг болгон, үндэсний чадавх, хариуцлагыг бэхжүүлэх, НҮБ-ын хөтөлбөр боловсруулах удирдах зарчмуудыг хэрэгжүүлэх хөгжлийн цогц шийдэлд хүрэхийн төлөө ажиллана.

3.1.2 Хамтарсан удирдах хороо

Хамтын ажиллагааны хүрээг хэрэгжүүлэхэд Монгол Улсын Засгийн газар болон НҮБ-ын Хамтарсан удирдах хороо (ХУХ) стратегийн удирдлагаар хангах бөгөөд тус хороог Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Гадаад харилцааны сайд, Монгол Улс дахь НҮБ-ын

Удирдлагын багийг төлөөлж НҮБ-ын Суурин зохицуулагч нар хамтран даргална.

Мөн ХУХ нь Хамтын ажиллагааны хүрээ баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. Тус хороо нь хамтран даргалагчдаас гадна Засгийн газрын салбарын яамд, агентлагууд, НҮБ-ын Удирдлагын багийн гишүүдээс бүрдсэн байна. ХУХ-ны бүрэлдэхүүнд урьдчилан зөвшилцсөнөөр ОУСБ-ууд, хоёр талын хөгжлийн түншүүд, хувийн хэвшлийн төлөөлөл, иргэний нийгмийн байгууллагууд зэрэг Хамтын ажиллагааны хүрээг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын төлөөлөл болон алагчлалд өртөх эрсдэлтэй хүн амын бүлгүүдийн төлөөллийг оролцуулж болно.

ХУХ нь жилд хоёроос доошгүй удаа хуралдаж, Хамтын ажиллагааны хүрээний хэрэгжилтийн явцад хяналт тавьж, үндэсний хөгжлийн тэргүүлэх чиглэл, бүс нутаг, олон улсын хөгжлийн чиг хандлагатай уялдуулан зөвлөмж дүгнэлт гаргаж ажиллана. Чингэхдээ ХУХ нь Хамтын ажиллагааны хүрээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн, тулгарч буй сорилт, боломжуудыг тодорхойлохын зэрэгцээ эрсдэлийн үнэлгээ хийж, шаардлагатай

тохиолдолд зохих өөрчлөлтүүдийг оруулах талаар заавар зөвлөмж гаргана. ХУХ нь Хамтын ажиллагааны хүрээний санхүүжилтийн нөхцөл байдал, “Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангахад шаардагдах хөгжлийн санхүүжилтийг төвлөрүүлэх боломжийг авч үзэх болно. Хамтын ажиллагааны хүрээний хэрэгжилтийн жилийн тайланг НҮБ-ын Суурин

зохицуулагчийн удирдлага дор НҮБ-н Удирдлагын баг Засгийн газрын холбогдох талуудтай хамтран бэлтгэж, тайланг үр дүнгийн бүлгүүдийн удирдлагын тусламжтайгаар НҮБ-ын Суурин зохицуулагч ХУХ-нд танилцуулна. Хамтарсан Ажлын төлөвлөгөөнд үндэслэн жилийн тайланг боловсруулна.


3.2 Хамтын ажиллагааны хүрээний удирдлагын бүтэц

3.2.1 НҮБ-ын Удирдлагын баг

НҮБ-ын Удирдлагын баг нь Монгол Улс дахь НҮБ-ын системийн байгууллагууд хоорондын хамтын ажиллагаа, ажлын уялдаа холбоог бэхжүүлэх, хамтын шийдвэр гаргахад чиглэсэн байгууллага дундын гол механизм юм. НҮБ-ын Суурин зохицуулагчийн тэргүүлдэг энэхүү баг нь ТХХАХ баримт бичигт гарын үсэг зурсан НҮБ-ын системийн суурин болон суурин бус байгууллагуудын төлөөллөөс бүрдэнэ. Монгол Улсын Засгийн газартай харилцан тохиролцсон Хамтын ажиллагааны хүрээ баримт бичиг нь Монгол Улс Засгийн газар болон НҮБ харилцан тохиролцон хамтын ажиллагааныхаа тэргүүлэх

чиглэлүүдийг хамтран тодорхойлж төлөвлөсөн, хэрэгжилтийг хангах хамгийн чухал арга хэрэгсэл юм. НҮБ-ын Хамтын ажиллагааны хүрээнд туссан үр дүнгийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд НҮБ-н Удирдлагын баг нь бие даасан үр дүнгүүдийг харьяа дээд байгууллагуудад тайлагнахын зэрэгцээ хамтарсан үрдүнд оруулсан хувь нэмрээ НҮБ-ын Суурин зохицуулагчид мөн тайлагнана.

НҮБ-ын Удирдлагын баг сард нэгээс дээш удаа хуралдах бөгөөд суурин бус НҮБ-ын системийн байгууллагуудын оролцох боломжийг хангана.



НҮБ-ын ТХХАХ баримт бичигт гарын үсэг ёслолын ажиллагаанд оролцсон Монгол Улсын Засгийн газрын гишүүд, Монгол дахь НҮБ-ын Удирдлагын багийн төлөөлөл. 2022 он. Зургийг НҮБ-ын Суурин зохицуулагчийн газар.

3.2.2 Үр дүнгийн бүлгүүд

Хамтын ажиллагааны хүрээг хэрэгжүүлэх ажлын салшгүй хэсэг болох Стратегийн Тэргүүлэх чиглэлийн түвшинд байгуулагдсан Үр дүнгийн бүлгүүд нь Хамтын ажиллагааны хүрээг хэрэгжүүлж, үр дүнг хариуцан ажиллана. НҮБ-ын Суурин зохицуулагчийн удирдлага дор эдгээр Үр дүнгийн бүлэг нь НҮБ-ын системийн хэмжээнд харилцан уялдаатай дүн шинжилгээ хийх, төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ хийх, улмаар холбогдох стратегийн тэргүүлэх чиглэлийн үр дүнгийн зорилтыг хэрэгжүүлэхэд мэдээлэл харилцааны туслалцаа үзүүлэх зэргээр дэмжиж ажиллана. Эдгээр бүлэг нь НҮБ-ын Удирдлагын багт төлөөлөлтэй НҮБ-ын системийн суурин болон суурин бус байгууллагуудын төлөөлөл, Засгийн газрын холбогдох яамд, газрын төлөөллөөс бүрдэнэ. Шаардлагатай тохиолдолд гаднаас нэмэлт гишүүдийг татан оролцуулж болно.

Үр дүнгийн бүлэг бүрийг НҮБ-ын Удирдлагын багт багтсан системийн нэг байгууллагын тэргүүн даргална. Үр дүнгийн бүлгийг НҮБ-ын системийн байгууллагууд жил жилээр ээлжлэн даргална. Үр дүнгийн бүлгийг Засгийн газрын холбогдох яам, агентлагуудын төлөөлөл хамтран даргалж болно. Үр дүнгийн бүлгүүд жилд дөрвөөс доошгүй удаа (улирал тутамд нэг удаа) хуралдана.

Үр дүнгийн бүлгүүд нь Хамтын ажиллагааны хүрээний 4 үр дүнгийн хэрэгжилтийг хангаж ажиллана. Хамтын ажиллагааны хүрээнд стратегийн тэргүүлэх гурван чиглэлийг тодорхойлсон байх тул НҮБ-ын Удирдлагын багт Хамтын ажиллагааны хүрээний хэрэгжилтийг дэмжих Үр дүнгийн дараах бүлгийг байгуулна. Үүнд:



Эдгээр бүлэг нь байгууллага хоорондын хамтын ажиллагааг сайжруулах, үйл ажиллагааны давхардлыг арилгах, хөгжлийн үр дүнгийн зорилтыг хэрэгжүүлэх боломжуудыг тодорхойлж, хэрэгжилтийн үр дүнг НҮБ-ын Удирдлагын багт тайлагнана. Үр дүнгийн бүлгүүд нь Хамтын ажиллагааны хүрээний үр дүнгийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн Хамтарсан ажлын төлөвлөгөө, санхүүжилтийн төлөвлөгөөг боловсруулах, шинэчлэн сайжруулах ажлыг голчлон хариуцна. Үр дүнгийн бүлгүүд нь Хамтын ажиллагааны хүрээний үр дүнгийн зорилтуудыг хэрэгжүүлэх явцад НҮБ-ын хамтарсан хөтөлбөр боловсруулах, нөлөөлөл сурталчилгаа, сорилтууд, шинээр үүсэн бий болох боломжууд зэргийг судалж, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлно. Түүнчлэн Үр дүнгийн бүлгүүд гарч буй үр дүн, хувьсан өөрчлөгдөж буй улс орны нөхцөл байдал, эрсдэл зэрэгт тогтмол хяналт тавьж, үр дүнгийн зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор Хамтын ажиллагааны хүрээнд өөрчлөлт, залруулга хийх, Хамтарсан ажлын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах зэрэг саналыг НҮБ-ын Удирдлагын багт танилцуулах үүрэг хүлээнэ.

Үр дүнгийн бүлгүүд нь Хамтарсан удирдах хорооны хурал болохоос өмнө Жилийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэнэ. Улмаар Хамтарсан ажлын төлөвлөгөө (ХАТ), түүний хэрэгжилтийн явцын талаарх мэдээллээр НҮБ-ын мэдээллийн санг сар бүр баяжуулж байна. Үр дүнгийн бүлгүүд нь Хяналт-шинжилгээ, үнэлгээ, сургалтын баг (ХШҮСБ-дараагийн хэсэгт өгүүлнэ)-тай хамтран ажиллаж, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, сургалт (ХШҮС)-ын төлөвлөгөөг хэрэгжүүлж, үр дүнг НҮБ-ын Мэдээлэл харилцааны багт илгээнэ. Сэдэвчилсэн багууд (дараагийн хэсэгт өгүүлнэ) нь Үр дүнгийн бүлгүүд болон НҮБ-ын системийн байгууллагуудад “хэнийг ч орхигдуулахгүй байх” зэрэг үндсэн зарчмыг мөрдлөг болгоход дэмжлэг үзүүлж ажиллана.

НҮБ-ын Суурин зохицуулагч нь Ерөнхий сайдын тэргүүлдэг Тогтвортой хөгжлийн үндэсний хороо (ТХҮХ)-той нягт хамтран ажиллаж, Хамтын ажиллагааны хүрээний үр дүн болон бусад мэдээллийг ТХҮХ-нд илгээж байна. Үр дүнгийн бүлгүүд нь “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд байгуулагдсан ажлын хэсгүүдтэй нягт хамтран ажиллах бөгөөд холбогдох төлөвлөгөөнүүдийг судалж, өөрсдийн үйл ажиллагаатай уялдуулах болно.

Түүнчлэн, НҮБ-ын Удирдлагын баг нь Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээ (ТХХАХ)-ний хэрэгжилт, түүний чанарт хяналт тавих үүрэг бүхий Хөтөлбөрийн хяналтын баг байгуулах асуудлыг авч үзэж болно. Энэ баг нь ТХХАХ-г

хэрэгжүүлэх явцад “хэнийг ч орхигдуулахгүй байх” зарчмыг тууштай мөрдөж хэрэгжүүлэхэд хяналт тавьж ажиллана.



“Хувьсаж буй боловсрол” үндэсний хэлэлцүүлэгт оролцож буй залуучууд. 2022 он.
Зургийг НҮБ-ын Суурин зохицуулагчийн газар.

3.2.3 НҮБ-ын Сэдэвчилсэн багууд болон Хөтөлбөрийг дэмжих багууд

Дараах сэдэвчилсэн болон хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих багууд НҮБ-ын ТХХАХ-г хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Сэдэвчилсэн багууд

ЖЕНДЭРИЙН БАГ

Хамтын ажиллагааны хүрээнд жендэрийн эрх тэгш байдал, эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх асуудлыг бүх шатны үйл ажиллагаанд тусгах ажлыг үргэлжлүүлж, өргөжүүлнэ. Түүнчлэн, энэ баг нь хариуцлагын тогтолцоог бий болгож, жендэрийн эрх тэгш байдал, эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх хүрээнд НҮБ-ын системийн байгууллагууд хоорондын зохицуулалтыг сайжруулахад чиглэсэн Жендэрийн эрх тэгш байдлын үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор онооны картын үнэлгээний аргыг хэрэглэнэ. НҮБ болон бусад хэрэгжүүлэгч байгууллагын хүрээнд Жендэрийн багийн гүйцэтгэх үүрэгт Бэлгийн мөлжлөг, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх асуудал хамаарна. Жендэрийн багийг НҮБ-ын Суурин зохицуулагчийн газар, эсхүл НҮБ-ын системийн аль нэг байгууллагын тэргүүн даргалах ба гишүүд нь НҮБ-ын системийн байгууллагуудын жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд байна. НҮБ-ын Удирдлагын багийн шийдвэрээр иргэний нийгмийн байгууллагын болон Засгийн газрын байгууллагын төлөөллийг энэ багт оруулж болно. Жендэрийн баг нь жилд хоёроос доошгүй удаа хуралдана.

ЗАЛУУЧУУДЫН БАГ

Залуучуудын баг нь залуучууд болон НҮБ-ын Удирдлагын багийн стратегийн хамтын ажиллагааг дэмжиж ажиллана. Монгол Улсын хүн амын ойролцоогоор тал хувийг залуучууд эзэлж байгаа бөгөөд НҮБ-аас хэрэгжүүлж буй үйл ажиллагааг залуучуудад хандуулж, тэдэнд хүрч ажиллахыг зорьж байна. Залуучуудын багийн бүрэлдэхүүнд НҮБ-ын ТХХАХ-нд гарын үсэг зурсан байгууллага бүрийн төлөөлөл орж, НҮБ-ын 2030 он хүртэлх Залуучуудын стратегийг удирдлага болгон ажиллана. Залуучуудын баг нь залуучууд болон НҮБ-ын Удирдлагын багийн стратегийн хамтын ажиллагааг сайтар зохицуулалттайгаар удирдан чиглүүлэх хамтарсан стратеги боловсруулж, өөрсдийн боломж чадавхыг бүрэн ашиглах, улмаар өөрчлөгч хүч болон улс орныхоо хөгжилд хувь нэмэр оруулах хэмжээнд хүрч, эрх мэдэлжихэд нь залуучуудад дэмжлэг үзүүлнэ. Залуучуудын багийг НҮБ-ын системийн байгууллагууд тодорхой хугацаагаар ээлжлэн даргална. Залуучуудын баг нь жилд хоёроос доошгүй удаа хуралдана.

ХҮНИЙ ЭРХИЙН БАГ

НҮБ-ын ТХХАХ болон бусад хөтөлбөр, стратеги зэрэг НҮБ-ын үйл ажиллагаа, Монгол Улс дахь НҮБ-ын нөлөөлөл сурталчилгааны ажил, хөтөлбөрүүд, үйл ажиллагааны удирдлагыг бэхжүүлэх, хүний эрхийн олон улсын хэм хэмжээ, стандартын дагуу техникийн туслалцаа үзүүлэх зэрэгт хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлэхэд нь НҮБ-ын Удирдлагын багт дэмжлэг үзүүлнэ. Хүний эрхийн баг нь НҮБ-ын системийн байгууллагуудаас томилогдсон гишүүдээс бүрдэх ба НҮБ-ын Суурин зохицуулагчийн алба, эсхүл НҮБ-ын системийн аль нэг байгууллагын тэргүүн даргална. Хүний эрхийн баг жилд хоёроос доошгүй удаа хуралдана.

НҮБ-ын Ази, Номхон далайн бүс нутаг дахь байгууллага хоорондын Асуудлыг шийдвэрлэх ажлын хэсэг зэрэг бусад бүс нутгийн болон үндэсний сүлжээний мэдлэг, туршлагад суурилж, Шилжилт хөдөлгөөний талаарх даян дэлхийн гэрээ, ТХЗ-ыг хэрэгжүүлэх хүрээнд шилжилт хөдөлгөөний удирдлага, зохицуулалтыг сайжруулах, шилжин суурьшигчдыг хамгаалах асуудлаар үр дүнтэй, цаг үеэ олсон, зохицуулалттай дэмжлэгийг НҮБ-ын Удирдлагын багаас Монгол Улсын Засгийн газарт үзүүлнэ.

Сэдэвчилсэн бүлгүүд нь Үр дүнгийн бүлгүүдтэй нягт хамтран ажиллахын зэрэгцээ Хамтын ажиллагааны хүрээ нь “хэнийг ч орхигдуулахгүй байх” үндсэн зарчмыг чанд мөрдөхөд гол анхаарлаа чиглүүлнэ.

Түүнчлэн эдгээр ажлын хэсгүүд нь өөрсдийн хариуцсан асуудлыг (жишээ нь, жендэр, залуучууд) бодлого, үйл ажиллагаанд тусгах ажилд нөлөөлөх үүрэг хүлээнэ. Ингэхдээ сэдэвчилсэн ажлын хэсгийн гишүүд Үр дүнгийн бүлгүүдийн уулзалт хэлэлцүүлгүүдэд оролцож, хариуцсан чиглэлийнхээ асуудал, хөтөлбөрүүдийн удирдах зарчмуудыг (хэнийг ч орхигдуулахгүй байх, жендэрийн эрх тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийг чадавхжуулж эрх мэдлийг нь нэмэгдүүлэх, хүний эрхэд суурилсан хандлага,

гэх зэрэг) үйл ажиллагаанд тусгахад анхаарч ажиллана. Түүнчлэн сэдэвчилсэн ажлын хэсгүүд нь тус хамтын ажиллагааны хүрээний үр дүнгийн зорилтуудын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийхэд шаардагдах шалгуур үзүүлэлтүүдийг Үр дүнгийн матрицад оруулахад нь Үр дүнгийн бүлгүүдэд дэмжлэг үзүүлнэ. Сэдэвчилсэн ажлын хэсгүүд нь холбогдох чиглэлээр гарсан шинэлэг тоо мэдээллээр Үр дүнгийн бүлгүүд болон НҮБ-ын Удирдлагын багийг хангаж байна.

Хөтөлбөрийг дэмжих багууд

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, СУРГАЛТЫН БАГ

НҮБ-ын Суурин зохицуулагчийн газрын ахалдаг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, сургалтын баг (ХШҮСБ) нь НҮБ-ын системийн байгууллагуудын Хяналт-шинжилгээ, үнэлгээ (ХШҮ)-ний төлөвлөгөөг хооронд нь болон Хамтын ажиллагааны хүрээний ХШҮ-ний төлөвлөгөөтэй уялдуулж, нийцүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. ХШҮСБ нь Хамтын ажиллагааны хүрээний хэрэгжилтийн үр дүнг тайлагнах зорилгоор мэдээлэл цуглуулж, НҮБ-ын мэдээллийн санг тогтмол баяжуулах үүрэг хүлээнэ. ХШҮСБ нь шаардлагатай тохиолдолд Үр дүнгийн хүрээ болон ХШҮС-ын төлөвлөгөөнд холбогдох өөрчлөлт оруулах санал гаргаж болгоно. Түүнчлэн үр дүнгийн тайланг хянаж, мэдээллийн үнэн зөв эсэхийг баталгаажуулна. Энэ баг нь Хамтарсан удирдах хорооны жилийн тайлангийн уулзалтын өмнө Хамтын ажиллагааны хүрээний хэрэгжилтийн жилийн тайланг гаргаж, мэдээллийн үнэн зөвийг баталгаажуулах үүрэг хүлээнэ. ХШҮСБ нь Хамтын ажиллагааны хүрээний тэргүүлэх чиглэлийн үр дүнгийн зорилт бүрийн хэрэгжилтийн талаарх холбогдох мэдээллийг Үр дүнгийн бүлгүүдтэй зөвлөлдөж, үнэн зөв гарган, Хамтын ажиллагааны хүрээний хэрэгжилтэд эцсийн үнэлгээ хийхэд дэмжлэг үзүүлнэ. ХШҮСБ нь Хамтын ажиллагааны хүрээг хэрэгжүүлэх явцад бий болсон сайн туршлага, сургамжийг сайтар баримтжуулна. Багийн уулзалтыг улирал бүр хийнэ.

САНХҮҮЖИЛТ, ТҮНШЛЭЛИЙН БАГ

Санхүүжилт, түншлэлийн баг нь НҮБ-ын ТХХАХ-г хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө нөөцийг дайчлах, стратегийн түншлэлийг бий болгоход чармайлт гарган ажиллаж, үр дүнтэй, зохицуулалттайгаар ажиллана. Баг нь НҮБ-ын ТХХАХ-ний Түншлэлийн болон санхүүжилтийн тогтолцоог бий болгох гол хөдөлгөгч хүчний үүргийг гүйцэтгэж, шаардлагатай тохиолдолд холбогдох өөрчлөлт оруулах санал гаргаж болно. Санхүүжилт, түншлэлийн баг нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд, олон улсын санхүүгийн байгууллагууд болон хөгжлийн түншүүд, төрийн бус байгууллагууд (дотоод, гадаадын), бодлогын судалгааны төвүүд, эрдэм шинжилгээний байгууллагууд зэрэг олон талын түнштэй хамтын ажиллагааг хөгжүүлэх, зохицуулах боломжуудыг судалж, НҮБ-ын ТХХАХ-г үр дүнтэй хэрэгжүүлэхэд дэмжлэг болох нэмэлт санхүүгийн болон бусад эх үүсвэр, техникийн туслалцаа, чадавх бэхжүүлэх бүхий л боломжийг бүрдүүлэхийг хичээн ажиллана. Санхүүжилт, түншлэлийн баг нь үндсэн зорилтууд, салбар хоорондын тэргүүлэх чиглэлийн асуудлаар яриа хэлэлцүүлэг өрнүүлж, НҮБ-ын ТХХАХ-ний тэргүүлэх чиглэлийн зорилтуудыг хэрэгжүүлэх үйл явцыг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлэх боломжит түншүүдийг НҮБ-ын системийн хэмжээнд татан оролцуулна. Санхүүжилт, түншлэлийн баг нь НҮБ-ын системийн байгууллагуудаас томилогдсон гишүүдээс бүрдэх бөгөөд НҮБ-ын Суурин зохицуулагчийн газар даргална. Тус багийн уулзалтыг сар бүр хийнэ.

ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН БАГ

Захиргааны удирдлагын баг (ЗУБ) нь НҮБ-ын системийн байгууллагуудын захиргаа, үйл ажиллагаа хариуцсан ажилтнуудаас бүрдэж, байгууллагуудын бизнесийн үйл ажиллагааг уялдуулан, үр нөлөөг дээшлүүлэх талаар НҮБ-ын Удирдлагын багт дэмжлэг үзүүлж, зөвлөмж өгч ажиллана. Баг нь худалдан авалт, ажилтан сонгон шалгаруулж авах, ложистик

үйлчилгээ, мэдээлэл, харилцааны технологийн болон бусад үйлчилгээг хэмнэлттэй, үр ашигтай зохион байгуулахыг зорьж, нийтлэг үйлчилгээг нэгдмэл байдлаар хэрэгжүүлэх хүрээнд ажиллана. ЗУБ-ийн уулзалтыг сар бүр хийж, суурин байгаа НҮБ-ын системийн байгууллагууд жил бүр ээлжлэн тэргүүлнэ.


НҮБ-ЫН МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦААНЫ БАГ

Мэдээлэл харилцааны баг (МХБ) нь НҮБ-ын Удирдлагын багийн салшгүй нэг хэсэг юм. Хамтын ажиллагааны хүрээ баримт бичгийг боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт шинжилгээ хийх, тайлагнах, үнэлэх зэрэг бүх үйл явцад НҮБ-ын Мэдээлэл харилцааны баг оролцоно. Улс орнуудад хэрэгжүүлэх Хамтын ажиллагааны хүрээ баримт бичгийн дагуу өөр хоорондоо нягт уялдаа бүхий ТХЗ-уудыг хэрэгжүүлэхэд оролцогч агентлагуудыг төлөөлөх НҮБ-ын Удирдлагын баг нь олон нийттэй харилцахдаа нэгдмэл байр сууринаас хамтран ажиллах ёстой гэж НҮБ-аас баталсан Мэдээлэл харилцааны ерөнхий стратегид заасан. Иймд НҮБ-ын Мэдээлэл харилцааны баг нь үндэсний хөгжлийн тэргүүлэх чиглэлийн асуудлууд, бодлогын хэрэгжилт, "Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөр"-ийн үндэсний хэрэгжилтийг эрчимжүүлэхэд чиглэсэн мэдээлэл сурталчилгааны ажлыг дэмжих замаар НҮБ-ын системийн байгууллагуудын харилцан уялдаа бүхий мэдээлэл харилцаа, нөлөөлөл

үзүүлэх сурталчилгааны ажилд туслалцаа үзүүлнэ. НҮБ-ын Мэдээлэл харилцааны баг нь НҮБ-ын ТХХАХ-ний хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх Хамтарсан мэдээлэл харилцааны шинэ стратеги болон ажлын төлөвлөгөөг боловсруулна. НҮБ-ын Мэдээлэл харилцааны баг нь хэвлэл мэдээлэл, олон нийтэд НҮБ-ын үйл ажиллагааг илүү тод таниулж, ойлголт мэдлэгийг сайжруулах, сурталчлах зэрэгт чиглэсэн арга хэмжээг чанартай, үр дүнтэй зохион байгуулахад шаардагдах хангалттай төсвөөр хангагдсан байна. Баг нь НҮБ-ын ТХХАХ-г дэмжиж гарын үсэг зурсан НҮБ-ын системийн суурин болон суурин бус байгууллагуудын мэдээлэл харилцааны асуудал хариуцсан ажилтнуудаас бүрдэх ба мэдээлэл харилцааны ажлын батлагдсан төлөвлөгөөг тогтвортой хэрэгжүүлэхэд шаардагдах бүх дэмжлэгийг авч ажиллана. Мэдээлэл харилцааны багийг НҮБ-ын Суурин зохицуулагчийн газар даргалах бөгөөд сард нэг удаа хуралдана.

Сэдэвчилсэн багууд нь үйл ажиллагаагаа НҮБ-ын Удирдлагын багийн бусад сэдэвчилсэн баг, ажлын хэсэгтэй уялдуулан зохицуулна. Түүнчлэн сэдэвчилсэн багууд нь НҮБ-ын Удирдлагын багийн бусад багийн холбогдох хөтөлбөр, үйл ажиллагааны уялдааг хангахад анхаарч ажиллана.

ТХХАХ-г хэрэгжүүлэхэд оролцох НҮБ-ын Удирдлагын багийн бүтэц, зохион байгуулалт



3.3 Хамтын ажиллагааны хүрээний санхүүжилт

Хамтын ажиллагааны хүрээний санхүүжилт бүрдүүлэх асуудлыг ТХЗ-ын санхүүжилтийн үндсэн шийдэлтэй уялдуулж, Хамтын ажиллагааны хүрээ баримт бичгийг баталж гарын үсэг зурсны дараа бүрэн шийдвэрлэнэ. Хамтын ажиллагааны хүрээний НҮБ-ын санхүүжилт нь хэлбэрийн хувьд шинэчлэгдсэн, шинэлэг бөгөөд уламжлалт бус хөрөнгийн бусад эх үүсвэрийг дайчлах хэрэгсэл байх болно. Хөрөнгө санхүүжилтийн төлөвлөгөөний ажлын хэсгийн дэмжлэгтэйгээр НҮБ-ын Удирдлагын баг нь хамтарсан хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхдээ ТХЗ-ын Хамтарсан сан, НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах тусгай сан, Олон талт итгэлцлийн сангуудаар дамжуулан санхүүжилт татах боломжийг судална. Эдгээр эх үүсвэр нь өнөөгийн бий болоод байгаа ТХЗ-ын санхүүжилтийн томоохон эх үүсвэрүүд (дотоод, гадаадын төрийн болон хувийн санхүүжилт)-д нэмэлт дэмжлэг болно. Хөгжлийн бусад түнш, хувийн хэвшлийнхний оруулж буй хувь, боломжит санхүүгийн эх үүсвэрүүдэд үнэлгээ хийх замаар НҮБ-ын санхүүжилтийг бүрдүүлнэ. Монгол Улс дахь НҮБ нь Сангийн яам болон бусад оролцогч талтай нягт хамтран ажиллаж, “Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөр”, “Алсын хараа -2050” зэрэг бодлогын баримт бичигтэй

нийцүүлэн, ТХЗ болон үндэсний тэргүүлэх зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн хөрөнгө нөөцийн хуваарилалтыг сайжруулах зорилгоор Үндэсний санхүүжилтийн нэгдсэн тогтолцоог боловсруулж хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлнэ.

НҮБ-ын системийн байгууллагууд (НҮБ-ын ТХХАХ-нд гарын үсэг зурсан) нь Хамтын ажиллагааны хүрээг хэрэгжүүлэх дараах үйл ажиллагааг батлагдсан төлөвлөгөө, төслийн баримт бичгийн хүрээнд тохиролцсоны дагуу санхүүжүүлж, НҮБ-ын Удирдлагын багт дэмжлэг үзүүлж хамтран ажиллана. Үүнд: техникийн туслалцаа, чадавх бэхжүүлэх, тэтгэлэгт хөтөлбөрүүд, хангамж, бараа бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж, худалдан авалтын үйлчилгээ, тээвэр, нөлөөлөл үзүүлэх сурталчилгааны ажил, судалгаа шинжилгээ, зөвлөх үйлчилгээ, хөтөлбөр боловсруулалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ, сургалтын үйл ажиллагаа, ажилтнуудад дэмжлэг үзүүлэх зэрэг ажил хамаарна. НҮБ-ын системийн байгууллагуудын дэмжлэгийн зохих хэсэг нь иргэний нийгмийн болон төрийн бус байгууллагуудын чадавхыг бэхжүүлэхэд чиглэнэ.

Нэмэлт дэмжлэг авч болох бүхий л сувгуудыг, тухайлбал, НҮБ-ын системийн байгууллагуудын олон улсын мэдээллийн сангууд, бусад улс дахь НҮБ-ын системийн байгууллагуудын сүлжээ, мэдээллийн мэргэшсэн сангууд, нөөцөд бүртгэгдсэн зөвлөхүүд болон хөгжлийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд, НҮБ-ын системийн байгууллагууд, сангууд, хөтөлбөрүүдийн сүлжээ зэргээс үзүүлж буй дэмжлэгүүдийг ашиглана. НҮБ-ын системийн байгууллагууд нь хөтөлбөр боловсруулах, хөтөлбөрийг дэмжих, техникийн туслалцаа үзүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ зэрэг олон чиглэлийн асуудал хариуцсан ажилтан, зөвлөхүүдийг томилно.



3.4. Хамтарсан Ажлын төлөвлөгөө

Хамтын ажиллагааны хүрээг жил бүр НҮБ болон Монгол Улсын Засгийн газар хамтран боловсруулж, баталсан Хамтарсан Ажлын төлөвлөгөө (ХАТ)-ний дагуу хэрэгжүүлнэ. ХАТ нь Хамтын ажиллагааны хүрээний үр дүнгийн зорилт, үр дүн, үйл ажиллагаа, санхүүжилтийг жил бүрээр, ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүд, жендэрийн болон хүний эрхийн үзүүлэлтийн гүйцэтгэл зэргийг бүхэлд нь хамруулна. ХАТ-г НҮБ-ын Удирдлагын баг (суурин, суурин бус) Үр дүнгийн бүлэг бүрээр хамтран бэлтгэж, НҮБ-ын “UNInfo” мэдээллийн системд оруулна.

ХАТ нь Үр дүнгийн бүлгүүдийн бэлтгэх Ажлын жилийн гүйцэтгэл, Үр дүнгийн жилийн тайлангийн суурь үндэс болно. ХАТ нь Монгол Улсын ТХЗ-ын хөтөлбөр, үндэсний тэргүүлэх зорилтуудтай нийцсэн байх ба биелэлтийг жил бүр дүгнэн, хүрсэн түвшинг үнэлж, шаардлагатай тохиолдолд улс орны нөхцөл байдалтай уялдуулан, зохих

өөрчлөлт оруулах саналыг гаргаж болно. ХАТ-ний хүрээнд хүрэх үр дүнгүүд нь хамтарсан үр дүнг илэрхийлэх бөгөөд “байгууллага бүрийн оруулсан хувь нэмэр” нь дэд үр дүнгүүд буюу хариуцсан үйл ажиллагааны гүйцэтгэлээр илэрхийлэгдэнэ.

Хөтөлбөрүүдийн үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд НҮБ-ын системийн байгууллагууд болон түншүүд энэхүү Хамтын ажиллагааны хүрээ, хамтран баталсан эсвэл өөрийн байгууллагын ажлын тусгай төлөвлөгөө, төслийн баримт бичиг зэрэг аль болох цөөн тооны баримт бичиг ашиглахыг эрмэлзэнэ. Харин шаардлагатай тохиолдолд, Хамтын ажиллагааны хүрээний холбогдох бичвэр, хамтарсан буюу өөрийн байгууллагын ажлын тусгай төлөвлөгөө болон төслийн баримт бичгээс тодорхой хэсгийг ишлэл болгон төслийн баримт бичиг шинээр боловсруулж болно.

3.5 Бизнесийн үйл ажиллагааны стратеги

Бизнесийн үйл ажиллагааны стратеги нь Монгол Улс дахь НҮБ-ын Удирдлагын багт ТХЗ, НҮБ-ын ТХХАХ-ний үр дүнгийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааныхаа үр ашгийг нэмэгдүүлж, өртөг зардлыг бууруулах боломжийг бүрдүүлнэ. ЗУБ нь НҮБ-ын хамтын ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх, бизнесийн хамтарсан арга хэлбэрийг ашиглах замаар үйл ажиллагаагаа хамтран зохион байгуулна. НҮБ өнгөрсөн хугацаанд хүрсэн ололт амжилтад тулгуурлан, санхүүгийн болон хүний нөөцийн боломжийг илүү сайн ашиглаж, захиргааны зардлыг бууруулах чиглэлээрх ажлаа үргэлжлүүлнэ. ЗУБ нь бизнесийн үйл ажиллагааны стратегийн дагуу нийтлэг үйлчилгээний гурван чиглэлийг өргөжүүлнэ. ЗУБ нь бизнесийн нийтлэг үйл ажиллагааг илүү хөнгөвчлөхийг зорьж, санхүү, хүний нөөц,

худалдан авалт, мэдээлэл харилцаа, захиргааны чиглэлээр хамтарсан нийтлэг үйл ажиллагааг хэрэгжүүлж, хөтөлбөрүүдтэй нягт хамтран ажиллана. Энэ нь хөтөлбөрүүдийн хэрэгцээг хангаж, хамтын ажиллагааны шинэ боломжуудыг бий болгох бөгөөд ТХЗ-ын хэрэгжилтэд үр нөлөө үзүүлэхүйц, үр дүнтэй хамтран ажиллах шинэ арга замуудыг нээн илрүүлж, улмаар НҮБ-ын ТХХАХ-ийн хэрэгжилтийг хангахад чухал дэмжлэг, үнэтэй хувь нэмэр болно.



4

БҮЛЭГ

ТӨЛӨВ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭГ
БАЯЖУУЛЖ ШИНЭЧЛЭХ БА
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ



4.1 Хамтарсан ажлын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх

НҮБ-аас бэлтгэдэг Монгол Улсын төлөв байдлын шинжилгээ нь жил бүрийн шинэ мэдээлэл дээр тулгуурлан, улс орны хөгжилд гарсан бодит өөрчлөлтийг шинэчилж байдаг чухал баримт бичиг болно. Энэ ажлыг НҮБ-ын Суурин зохицуулагчийн газрын ахалсан Ажлын хэсэг хариуцна. Ажлын хэсгийг энэхүү Хамтын ажиллагааны хүрээ баримт бичгийг боловсруулахын өмнө Монгол Улсын Төлөв байдлын шинжилгээг хийх зорилгоор байгуулсан болно. Ажлын хэсэг нь НҮБ-ын Удирдлагын багийн удирдлага дор Үр дүнгийн бүлгүүд, Сэдэвчилсэн багууд, ажлын хэсгүүд,

ХШҮС-ын ажлын хэсгийн дэмжлэгтэйгээр үйл ажиллагаа явуулна.

Хамтын ажиллагааны хүрээг хэрэгжүүлэх хугацааны туршид НҮБ-ын системийн байгууллагууд дундын ХШҮС-ын баг байгуулагдан, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, сургалтын төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллана. Энэ баг нь Хамтын ажиллагааны хүрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих замаар НҮБ-ын Удирдлагын багт дэмжлэг үзүүлэх юм. ХШҮС нь дараах тусгайлсан ажил үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

1

Суурь түвшний үзүүлэлтүүд, шалгуур үзүүлэлтүүд, мэдээлэл цуглуулах хэрэгцээ, мэдээллийг баталгаажуулах арга хэрэгслийг тодорхойлох;

2

ХШҮ-ний тогтолцоог ашиглан үр дүнгийн гүйцэтгэлд тогтмол хяналт-шинжилгээ хийхэд нь Үр дүнгийн бүлгүүдэд дэмжлэг үзүүлэх;

3

Байгууллагуудын онцлог хэрэгцээг хангах тоо мэдээлэл цуглуулах ажлыг зохицуулах;

4

Дүн шинжилгээ хийх, ХШҮ хариуцсан ажилтнуудын чадавхыг хөгжүүлэх үйл ажиллагаа явуулах;

5

Хамтын ажиллагааны хүрээний хэрэгжилтэд тогтмол хяналт-шинжилгээ хийх, тайлагнахад дэмжлэг үзүүлэх;

6

Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиг үүрэг нь жендэрийн эрх тэгш байдал, хүний эрх, хэнийг ч орхигдуулахгүй байх зэрэг үндсэн зарчимтай нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах, энэ зорилгыг хангах үүднээс ХШҮСБ-т бусад сэдэвчилсэн багийн гишүүдийг оруулах боломжтой;

7

Мэдээлэл цуглуулах эрс шинэлэг арга хэрэгслийг санал болгох, шаардлагатай тохиолдолд хөдөлгөөнт технологид суурилсан буюу дижитал технологи ашиглан бодит цаг хугацааны нарийвчилсан задаргаатай тоо мэдээлэл цуглуулах;

8

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад бий болсон сайн туршлага, сургамжийг баримтжуулж, НҮБ-ын Мэдээлэл харилцааны ажлын хэсгийн тусламжтайгаар түгээн дэлгэрүүлэх зэрэг ажил болно.

Үр дүнгийн хүрээнд тодорхойлсон шалгуур үзүүлэлтүүд нь үндэсний хэмжээний ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдтэй (батлах шаардлагатай байгаа) сайтар уялдаж байгаа бөгөөд тогтмол, найдвартай, нарийвчилсан задаргаатай тоо мэдээллийг үндэсний эх сурвалжаас авч тооцох боломжтой. НҮБ-ын Удирдлагын баг Хамтын ажиллагааны хүрээг хэрэгжүүлэх хугацаанд хийх судалгаа, ярилцлага, хэлэлцүүлэг зэргээс гарах тоо мэдээллээр үндэсний мэдээллийн эх сурвалжуудыг баяжуулах боломжтой.

ХШҮСБ нь НҮБ-ын системийн байгууллагуудын ХШҮ-ний төлөвлөлтийн туршлагад түшиглэн, НҮБ-ын ТХХАХ-ний ХШҮС-ын нэгдсэн төлөвлөгөөг боловсруулна. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлийн хяналт шинжилгээний асуудлаар Жендэрийн баг дэмжлэг үзүүлнэ.

Хамтын ажиллагааны хүрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, тайлагнахад шаардагдах нарийвчилсан задаргаатай тоо мэдээллийг Үндэсний статистикийн хороо, Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа,

Үндэсний сайн дурын илтгэл, Хүний эрхийн механизмуудад илгээсэн үндэсний тайлан (гэрээний байгууллагууд, Хүний эрхийн төлөв байдлын тайлангийн хэлэлцүүлэг, Тусгай процедурын зөвлөмжийн хэрэгжилтийн тайлан, гэх мэт), НҮБ-ын Гэрээний байгууллагуудын судалгааны дүгнэлтүүд, Хүний эрхийн төлөв байдлын илтгэлийн Ажлын хэсгийн тайлангууд, НҮБ-ын системийн байгууллагуудын төслүүдийн тайлан мэдээлэл, судалгааны тайлангууд, дэлхийн тайлангууд, индексүүд зэрэг олон эх сурвалжаас ашиглана.

Хяналт-шинжилгээний ажил нь тогтмол, тасралтгүй явагдах үйл явц бөгөөд төлөвлөсөн үр дүнд хүрэхийн төлөө хийж байгаа ажлын гүйцэтгэл, тулгарч буй сорилт, сургамжуудыг судалж, хяналт тавих, шаардлагатай тохиолдолд, Засгийн газрын холбогдох талуудтай зөвшилцөх замаар Хамтарсан ажлын төлөвлөгөөнд зохих өөрчлөлт оруулах зэрэг ажил үүнд хамаарна.

Хамтын ажиллагааны хүрээний хяналт-шинжилгээ нь дараах үндсэн хэсгээс бүрдэнэ. Үүнд:



4.2 Эрсдэл болон боломжуудад хяналт-шинжилгээ хийх нь

Хяналт-шинжилгээний механизмууд нь Хамтын ажиллагааны хүрээний үр дүнгийн зорилтуудын хэрэгжилтийн явц, бий болох боломжууд, тулгарч болзошгүй эрсдэлийн талаар НҮБ-ын Удирдлагын багийг мэдээллээр хангана. Тулгарч болзошгүй дараах **эрсдэлүүд** ажиглагдаж байна. Үүнд: эдийн засаг төдийлөн төрөлжөөгүй, уул уурхайн эрдэс түүхий эдийн экспортоос хэт хамааралтай зэргээс шалтгаалан дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн савлагаанаас эдийн засаг бүхэлдээ хамааралтай, нэн эмзэг; шатахууны импорт ОХУ-аас маш өндөр (89 хувь) хамааралтай байгаа нь макро эдийн засагт дарамт учруулж, бодит үйлдвэрлэл буурч, дунд хугацаанд санхүүжилтийн өртөг өндөр байх эрсдэлийг бий болгох; гадаад өрийн дарамт нэмэгдэх, төсвийн тогтворгүй байдал; байгалийн нөөцийн зохисгүй ашиглалт; гамшгийн эрсдэл (зуд гэх мэт); бүс нутгийн эдийн засгийн хямрал, түүний хор уршиг; цар тахлын шинэ давалгаа; засаглалын ахиц удаашралтай байх; авлига амь бөхтэй орших; жендэрийн эрх тэгш бус байдал; иргэний нийгмийн байгууллагуудын утга төгөлдөр оролцоо, чадавх дутмаг байх; төрийн албан хаагчдын тогтвор суурьшилгүй байдал, залгамж чанар алдагдах; Дэлхийн банкны Хөгжлийн тусламжийн хороо (WB-DAC)-ны

ангиллаар Монгол Улсын зэрэглэл ахих тусам хандивлагчдын дэмжлэг буурч байгаа зэрэг эрсдэл тулгарч болзошгүй юм.

Эрсдэлийг бууруулах стратегид Хамтын ажиллагааны хүрээний тэргүүлэх зорилтуудыг үндэсний тэргүүлэх зорилтуудтай уялдуулах; өргөн хүрээний үр дүнтэй түншлэлийг бий болгох; Засгийн газрын хамтарсан санхүүжилтийг дэмжих; Засгийн газрын чадавхыг бэхжүүлэх; онцгой байдлын үед шуурхай хариу арга хэмжээ авах талаарх НҮБ-ын уян хатан байдал, чадавхыг сайжруулах зэрэг арга хэмжээг тусгана. НҮБ нь жендэр, хүний эрх зэрэгт холбогдох нийгмийн болон байгаль орчны стандартыг мөрдлөг болгон, санамсаргүйгээр хор хохирол учруулахгүй байх болно.


НҮБ нь дараах **боломжийг** бүрэн ашиглана. Тухайлбал, залуу хүн ам, өндөр боловсролтой эмэгтэйчүүд, байгалийн арвин баялаг нөөц, өндөр боловсрол, өрнөж буй шилжилт хөдөлгөөн, улс төрийн харьцангуй тогтвортой байдал, ардчилсан институц болон шийдвэр гаргалт, “Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөр”, ТХЗ-ыг хэрэгжүүлэх улс төрийн үүрэг амлалт, хил дамнасан болон бүс нутгийн хамтын ажиллагаа, өргөжин тэлж буй хувийн хэвшил, дижитал хувьсал зэрэг өргөн боломжийг бүрэн ашиглахад анхаарна.

4.3 Жилийн гүйцэтгэлийн үнэлгээ, үр дүнгийн тайлан

Хамтарсан Удирдах хороо нь Монгол Улсын Засгийн газартай хамтран хамтын ажиллагааны хүрээ баримт бичгийн засаглалын бүтэц (Үр дүнгийн бүлгүүд, Сэдэвчилсэн багууд, ХШҮС-ын баг)-ийн дэмжлэгтэйгээр НҮБ-ын Удирдлагын багийн бэлтгэсэн тайланд үндэслэн, Хамтын ажиллагааны хүрээний жилийн гүйцэтгэлд үнэлэлт дүгнэлт өгнө. Уг тайлан нь Монгол Улс дахь суурин болон суурин бус НҮБ-ын системийн нийт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг нэгтгэсэн мэдээлэл байна. Тайланд Хамтын ажиллагааны хүрээг хэрэгжүүлэх явцад тулгарах сургамжуудыг баримтжуулан, НҮБ-ын Удирдлагын багийн сургалтын төлөвлөгөөнд тусгах болно. Тайланг гаргахдаа үндэсний

хэмжээний нарийвчилсан мэдээллийн нэгдсэн эх сурвалжийг ашиглахын зэрэгцээ Хамтын ажиллагааны хүрээний үр дүнгийн зорилтуудыг хэрэгжүүлэх явцад гарсан үр дүнгийн баримт мэдээллийг гуравдагч эх үүсвэр болгон ашиглана.

Хамтарсан Удирдах хороо (ХУХ) нь НҮБ-аас үзүүлсэн дэмжлэгийн бодит гүйцэтгэлийг Хамтарсан Ажлын төлөвлөгөө (ХАТ)-ний дагуу төлөвлөсөн үр дүнтэй харьцуулж дүгнэнэ. ХУХ нь шаардлагатай тохиолдолд, Хамтын ажиллагааны хүрээний үр дүнгийн гүйцэтгэлийг илүү үр өгөөжтэй болгох зорилгоор стратеги, хүлээгдэж буй үр дүн, хөрөнгө нөөц, хэрэгжүүлэх зохицуулалт зэрэгт зохих өөрчлөлт оруулах саналыг дүгнэлт хийх явцад зөвлөмж болгоно.



Жилийн гүйцэтгэлийн үнэлгээний дүнг Засгийн газар, хэрэгжүүлэгч талууд, хөгжлийн түншүүд, хувийн хэвшил, иргэний нийгмийнхэн зэрэг гол оролцогч талд мэдээлнэ. Түүнчлэн үнэлгээний дүнг илүү өргөн хүрээний хэрэглэгчдэд хүргэж, олон нийтэд нээлттэй түгээнэ.

Жил бүрийн гүйцэтгэлийн тайланг Засгийн газрын холбогдох байгууллагууд, салбарууд, Тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөлд хүргүүлэх бөгөөд үндэсний сайн дурын илтгэл бэлтгэх, нөлөөлөл үзүүлэх сурталчилгааны үйл ажиллагаанд эх сурвалж болгон ашиглана.

4.4 Үнэлгээ хийх төлөвлөгөө

Хамтын ажиллагааны хүрээний хэрэгжилтийн эцсийн шатны үнэлгээг Монгол Улсын Засгийн газартай зөвшилцсөний үндсэн дээр хэрэгжилтийн сүүлийн жилийн өмнөх жилд багтаан хийнэ. Үнэлгээгээр хамтын ажиллагааны хүрээний дараагийн үе шатад анхаарах сургамжийг баримтжуулна. Энэхүү үнэлгээ нь Засгийн газар болон иргэдийн өмнө Монгол Улс дахь НҮБ-ын системийн байгууллагуудын хүлээх хариуцлагын механизм байх болно.

Энэ нь хэрэгцээнд нийцсэн байх, үр дүнтэй, үр ашигтай, тогтвортой, үр нөлөө үзүүлэхүйц байх зэрэг Хөгжлийн тусламжийн хорооны үнэлгээний шалгуурын дагуу хийсэн хөндлөнгийн үнэлгээ байна. Үнэлгээг олон талыг хамруулан, оролцооны аргад тулгуурлан хийхийн зэрэгцээ, зорилтот хүн амын бүлгүүдийг оролцуулан яриа

хэлэлцүүлэг өрнүүлж, тэдний амьдралд гарсан үр нөлөөг мөн судална. Чингэхдээ боломжит бүх тохиолдолд орчин үеийн мэдээлэл цуглуулах арга хэрэгсэл, технологийг ашиглан, НҮБ-ын Үнэлгээний бүлгийн хэм хэмжээ, стандартыг дагаж мөрдөнө.

НҮБ-ын системийн байгууллагуудын хийх үнэлгээ нь Хамтын ажиллагааны хүрээний хэрэгжилтийн эцсийн үнэлгээнд үнэтэй мэдээлэл болох бөгөөд үнэлгээний үйл явцыг хэт сунжруулахгүй байх үүднээс зөвлөлдөх уулзалтуудыг аль болох хамтатган зохион байгуулахыг зорино. Эцсийн үнэлгээний үр дүнг олон нийтэд нээлттэй мэдээлнэ. ХШҮСБ нь эцсийн үнэлгээг зохион байгуулах чиглэлээр НҮБ-ын Удирдлагын багт дэмжлэг үзүүлж ажиллана.

ХАВСРАЛТ 1:

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНИЙ ҮР ДҮНГИЙН МАТРИЦ

СТРАТЕГИЙН АЛСЫН ХАРАА 2030 он гэхэд Монгол Улсын иргэн бүр амьдралынхаа туршид хүртээмжтэй, эрсдэл даах чадвартай, тогтвортой хөгжлөөр баталгаажсан, хамтаар хөгжин цэцэглэх, эрүүл, аюулгүй орчны үр шимийг хүртэх; эрх зүйт ёс, хүний эрхэд суурилсан эв нэгдэлтэй нийгэмд хөгжин дэвжих нөхцөл бүрдсэн байна.



СТРАТЕГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 1: ХҮНИЙ ХӨГЖИЛ, САЙН САЙХАН БАЙДАЛ

Үр нөлөө:

Үндэсний хөгжлийн тэргүүлэх чиглэлүүд

Алсын хараа - 2050 ¹⁷:

2. Чанартай амьдралын баталгаа бүхий нийгмийн хамгаалалтай, аз жаргалтай амьдралын ээлтэй орчинд, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болсон чанартай боловсролыг хүн бүр эзэмших боломжийг бүрдүүлэн нийгмийн идэвхтэй, эрүүл монгол хүнийг хөгжүүлнэ.
 - 2.1. Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ.
 - 2.2. Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлнэ.
 - 2.5. Амьдралын хэрэгцээг хангасан эрүүл, ая тухтай, таатай орчныг бүрдүүлж баталгаат хүнсээр хангана.
 - 2.6. Хөдөлмөрийн эдийн засгийн тэнцвэрийг хангаж, мэдлэгийн эдийн засгийг бүрдүүлж, иргэн бүрийг ажилтай, орлоготой болгоно.
 - 2.7. Монгол хүний удмын санг хамгаалж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чадавхыг бэхжүүлж, монгол хүний хөгжлийг дэмжинэ.
3. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин өрхийн орлогыг тогтвортой нэмэгдүүлж, идэвхтэй бүтээлч гэр бүлийг төлөвшүүлэн, хэрэгцээндээ нийцсэн байр сууц бүхий, хөрөнгө оруулалтын таатай орчин, нөхцөлд өрсөлдөхүйц бичил, жижиг, дунд бизнес эрхлэн өрх, гэр бүл, өөрийгөө тэтгэн амьдрах боломжтой, сэтгэл хангалуун амьдрах нөхцөлөөр тэтгэгдсэн дундаж давхаргыг бүрдүүлнэ.
 - 3.1. Амьдралын баталгааг хангах нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлнэ.
 - 3.5. Идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүлийг дэмжиж, биеийн тамир, спортын ээлтэй орчныг бүрдүүлнэ.
5. Монгол хүний хөгжлийг хангасан ухаалаг-тогтвортой засаглал тогтож, захиргааны оновчтой бүтэц зохион байгуулалт бүхий төрийн алба төлөвшин, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжиж, төр-хувийн хэвшил-иргэний нийгмийн хамтын ажиллагаа бүх хүрээнд өргөжин, хүний эрхийг бүрэн хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшсөн, авлигагүй улс болно.
 - 5.4. Иргэндээ үйлчилдэг, мэргэшсэн, чадварлаг, ил тод, үр нөлөөтэй, ухаалаг төрийн албыг төлөвшүүлнэ.












¹⁷ Монгол Улсын Засгийн газар (2020 оны 52 дугаар тогтоол). "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого. Мэдээллийг https://cabinet.gov.mn/wp-content/uploads/2050_VISION_LONG-TERM-DEVELOPMENT-POLICY.pdf




6. Байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийг эрхэмлэн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, байгаль орчны тогтвортой байдлыг ханган үр өгөөжийг нь өнөө болон ирээдүй хойч үе хүртэх нөхцөлийг бүрдүүлж, хүний амьдралын чанарыг сайжруулна.
 - 6.3. Усны нөөцийн хомсдолоос сэргийлж, гадаргын усыг хуримтлуулан, эрэлт хэрэгцээг хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлнэ.
 - 6.4. Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон эдийн засгийг хөгжүүлж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах олон улсын хүчин чармайлтад хувь нэмэр оруулна.
7. Улсын батлан хамгаалах чадавхыг бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, нийгмийн дэг журам, иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, гамшгийн эрсдэлийг бууруулах замаар хүн, нийгмийн аюулгүй байдлыг хангана.
 - 7.3. Уламжлалт бус аюулын эрсдэлийг бууруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхыг бэхжүүлж, хүн-нийгмийн амар тайван орчныг бүрдүүлнэ.
9. Амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, хүн төвтэй ухаалаг хот болгон хөгжүүлнэ.
 - 9.1. Иргэдийнхээ хөгжих боломжийг хангасан хөдөлмөрийн үнэлэмж өндөртэй эрүүл чийрэг, бүтээгч, оюунлаг иргэдтэй хот болно.
 - 9.2. Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан, хүлэмжийн хийн ялгарал багатай ногоон технологи бүхий амьдралын таатай орчинтой хот болно.

Бүс нутгийн хамтын ажиллагаа, хөтөлбөрүүд:

Төв Азийн бүс нутгийн Эдийн засгийн хамтын ажиллагаа; БНХАУ-Монгол Улс-ОХУ-ын Эдийн засгийн коридор; Зүүн хойд Азийн Супер сүлжээ; Ази Номхон далайн Худалдааны хэлэлцээр; Нийгмийн хамгааллын талаар Ази, Номхон далайн бүс нутгийн хамтын ажиллагааг бэхжүүлэх Үйл ажиллагааны төлөвлөгөө <https://www.unescap.org/kp/2021/action-plan-strengthen-regional-cooperation-social-protection-asia-and-pacific>;

ТХЗ-ууд, Зорилтууд:

- | | | |
|---|--------|---|
|  | ТХЗ 1 | Ядуурлыг устгах (Зорилтууд 1.1 & 1.2, 1.3, 1.4, 1.a); |
|  | ТХЗ 2 | Хүнсний аюулгүй байдал, тогтвортой хөдөө аж ахуйг дэмжих (Зорилтууд 2.1.1, 2.1.2, 3.4, 3.9.2); |
|  | ТХЗ 3 | Бүх нийтээрээ насан турш эрүүл энх, сайн сайхан амьдрах нөхцөлөөр хангах (Зорилтууд 3.1, 3.2, 3.4, 3.9.2, 3.8); |
|  | ТХЗ 4 | Чанартай боловсролыг дэмжих (Зорилтууд 4.1, 4.41, 4.2, 4.4, 4.7, 4.a.1); |
|  | ТХЗ 5 | Жендэрийн тэгш эрх байдлыг хангах, нийт эмэгтэйчүүд, охидыг эрх мэдэлжүүлэх (Зорилт 5.б); |
|  | ТХЗ 6 | Нийт хүн амыг ундны усаар хангаж, ариун цэврийн байгууламжийг хүртээмжтэй болгох, тогтвортой менежментийг хэрэгжүүлэх (Зорилтууд 6.1, 6.2); |
|  | ТХЗ 7 | Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх (Зорилт 7.1.); |
|  | ТХЗ 8 | Эдийн засгийн өсөлт, зохистой ажлын байр (Зорилт 8.5); |
|  | ТХЗ 9 | Дэд бүтцийг сайжруулж, инновацийг дэмжих (Зорилтууд 9.1, 9.с); |
|  | ТХЗ 10 | Тэгш бус байдлыг бууруулах (Зорилт 10.7); |
|  | ТХЗ 11 | Хот, суурин газруудын аюулгүй, хүртээмжтэй, тогтвортой хөгжлийг дэмжих (Зорилт 11.2); |

-  ТХЗ 12 Хариуцлагатай хэрэглээ, үйлдвэрлэлийг дэмжих (Зорилт 12.8);
-  ТХЗ 13 Уур амьсгалын өөрчлөлт, түүний сөрөг нөлөөллийг сааруулах арга хэмжээг яаралтай авах (Зорилтууд 13.3, 13.6);
-  ТХЗ 16 Энх тайван, шударга ёсыг цогцлоох (Зорилт 16.2);

Гол түншүүд:

- Шадар сайдын Ажлын алба
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
- Барилга, хот байгуулалтын яам
- Эдийн засаг, хөгжлийн яам
- Боловсрол, шинжлэх ухааны яам
- Байгаль орчин, аялал жуулчлалын яам
- Сангийн яам
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
- Хууль зүй, дотоод хэргийн яам
- Эрүүл мэндийн яам
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
- Үндэсний статистикийн хороо
- Онцгой байдлын ерөнхий газар
- Хүний эрхийн Үндэсний Комисс
- Жендэрийн үндэсний хороо
- Шүүхийн ерөнхий зөвлөл
- Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
- Орон нутгийн засаг захиргаа
- Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо
- Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо
- Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим
- Иргэний нийгмийн байгууллагууд
- Хувийн хэвшил
- Эрдэм шинжилгээний байгууллагууд
- Азийн хөгжлийн банк
- Хоёр талт хамтын ажиллагааны байгууллагууд
- Европын холбоо
- Олон улсын төрийн бус байгууллагууд
- АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг
- Дэлхийн банк

Хамтран ажиллах НҮБ-ын системийн байгууллагууд:

ХХААБ, ОУХБ, ОУШХБ, ОУЦХБ, НҮБ-ын ХЭДКГ, НҮБ-ын ДОХ-ын НХ, НҮБ-ын ГЭББ, НҮБ-ын АНДЭЗНК, НҮБ-ын БШУСБ, НҮБ-ын ХАС, НҮБ-ын Хабитит, НҮБ-ын ХС, НҮБ-ын АҮХБ, НҮБ-ын МБГХТА, НҮБ-ын ТҮА, НҮБ-ын СДХ, ДЭМБ.

Стратегийн тэргүүлэх чиглэл 1: Хүний хөгжил, сайн сайхан байдал

Үр дүнгүүд	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд (нарийвчилсан задаргаатай)	Суурь түвшин (он)	Зорилт (ХАХ хэрэгжиж дуусахад)	Мэдээллийн эх сурвалж/ Баталгаажуулах арга хэрэгсэл	Тавигдах нөхцөл
Үр дүнгийн зорилт 1: 2027 он гэхэд хот, хөдөөгийн иргэн бүр, ялангуяа нэн эмзэг болон орхигдох эрсдэлтэй хүн амын бүлгүүд өөрсдийн нөөц боломжийг бүрэн дүүрэн, эрх тэгш ашиглаж, хүний эрхэд суурилсан, хүртээмжтэй, жендерийн мэдрэмжтэй, цочролд тэсвэртэй, эрүүл мэнд, хоол тэжээл, боловсрол, нийгмийн хамгаалал, ус, ариун цэврийн байгууламжийн болон бусад үйлчилгээний үр шимийг хүртэнэ.	1.1 Үндэсний ядуурлын шугамаас доогуур амьжиргаатай хүн амын эзлэх хувь, бус нутаг, аймгаар [ТХЗ 1.2.1]	27.8 (2020)	20.0%	ҮСХ, Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа	Засгийн газраас эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбарт хангалттай төсөв хуваарилах,
	1.2 Хүнсний аюулгүй байдал нь дунд болон хүнд хэлбэрийн алдагдалд орсон өрхүүдийн нийт хүн амд эзлэх хувь ¹⁸ [ТХЗ 2.1.2]	26.18% (2018-2020)	23.8%	Хүн амын хүнсний бодит хэрэглээний судалгаа, ШУТИС, ҮСХ, Өрхийн нийгэм эдийн засгийн судалгааны Өрхийн хүнсний хэрэглээний хэсэг	КОВИД-19 цар тахлын нөхцөл байдлыг орнуулж, цар тахлын давлагаа арилсан, байх,
	1.3 Эхийн эндэгдэл (100,000 амьд төрөлтөд ногдох) [ТХЗ 3.1.1]	30.2 ¹⁹ (2020)	20	Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны тайлан ХН-201, Эрүүл мэндийн хөгжлийн төв (ЭМХТ)	Ачаа тээвэр, үйлчилгээний хил дамнансан хөдөлгөөний саад бэрхшээл арилсан байх.
	1.4 Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл (1000 амьд төрөлтөд ногдох) [ТХЗ 3.2.1]	14 ²⁰ (2020)	12		Ачаа тээвэр, үйлчилгээний хил дамнансан хөдөлгөөний саад бэрхшээл арилсан байх.
	1.5 (i) Унших болон (ii) тоо бодох наад захын чадвар эзэмшсэн (a) 2/3-р ангийн сурагчид, (b) бага сургууль төгсөх ангийн сурагчид, (c) бүрэн бус дунд боловсрол эзэмших төгсөлтийн ангийн хүүхэд, залуучуудын эзлэх хувь, хүйсээр [ТХЗ 4.1.1]	2/3-р анги Унших Бүгд 44.4% (2018)	48.4%	Чанарын үнэлгээ, Боловсролын үнэлгээний төв (ЕАС)	Үйлчилгээг үр дүнтэй хүргэхийн тулд дэд бүтэц, цахим шилжилтэд хөрөнгө оруулалт хийх, Төрийн үйлчилгээг хүргэх төсвийн орон зайг хязгаарлах санхүүгийн хямрал тохиохгүй байх.
		Эр 42.8% (2018)	46.8%	Нийгмийн үзүүлэлтүүдийн түүвэр судалгаа, ҮСХ	
		Эм 46.2% (2018)	50.2%		
		Тоо бодох Бүгд 33.6% (2018)	37.6%		
		Эр 34.9% (2018)	38.9%		
		Эм 32.2% (2018)	36.2%		
		Бага сургуулийн төгсөх анги Унших Бүгд 67.0% (2018)	70%		
		Эр 68.0% (2018)	70%		
		Эм 66.2% (2018)	70%		
Тоо бодох Бүгд 61.3% (2018)		63%			
Эр 65.6% (2018)	67%				
Эм 57.6% (2018)	60%				

¹⁸ ХХААБ. Тогтвортой хөгжлийн зорилтууд. Мэдээллийг <https://www.fao.org/sustainable-development-goals/indicators/212/en/>

¹⁹ Дэлхийн эрүүл мэндийн байгууллага. Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төв (2020) Эрүүл мэндийн үзүүлэлт. http://hdc.gov.mn/media/uploads/2021-08/Eruul_mendiin_uzuulelt_2020.pdf

²⁰ ҮСХ. ТХЗ-ын мэдээллийн сан. Мэдээллийг <http://sdg.gov.mn/>

Үр дүнгүүд

Үр дүн 1.1

Жендэрийн мэдрэмжтэй, цочролд тэсвэртэй, хүртээмжтэй, хямд төсөр, чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээ (бие махбодын, сэтгэцийн, бэлгийн болон нөхөн үржихүйн), хоол тэжээлийн болон ус, ариун цэврийн байгууламжийн үйлчилгээг хүн бүрт хүргэх эрүүл мэндийн нэгдсэн тогтолцоог дэмжих чадавх бэхэжсэн байна.

[НҮБ-ын системийн байгууллагууд: ХХААБ, ОУЦХБ, НҮБ-ын ХЭДКГ, НҮБ-ын ДОХ-ын НХ, НҮБ-ын ГЭББ, НҮБ-ын АНДЭЗНК, НҮБ-ын ХАС, НҮБ-ын ХС, НҮБ-ын МБГХТА, НҮБ-ын ТҮА, НҮБ-ын СДХ, ДЭМБ]

Үр дүн 1.2

Боловсролын тогтолцоо, боловсролын байгууллагууд нь бага насны хүүхдийн боловсрол, тогтвортой хөгжлийн боловсрол, амьдрах ухаан, бэлгийн цогц боловсрол зэрэг боловсролын бүхий л үйлчилгээнд ялангуяа онцгой байдлын үед эмзэг бүлгийн хүүхдүүдийг оролцуулан нийт хүүхэд, залуучуудыг хүртээмжтэй, тэгш хамруулан сургах, сургуулиас хөдөлмөрийн зах зээлд шилжих боломжийг бүрдүүлэх түвшинд хүрч чадавхжсан байна.

[НҮБ-ын системийн байгууллагууд: ОУЦХБ, НҮБ-ын ХЭДКГ, НҮБ-ын БШУСБ, НҮБ-ын ХАС, НҮБ-ын ХС, НҮБ-ын СДХ]

Үр дүн 1.3

Нийгмийн болон хүүхэд хамгааллын бодлого, тогтолцоо (нийгмийн даатгал, нийгмийн халамж, хөдөлмөрийн зах зээлийн хөтөлбөрүүд) нь хүн бүрийг нийгмийн хамгааллын үйлчилгээнд эрх тэгш хамруулж, цочролд тэсвэртэй, тогтвортой хөгжиж, хүн амын эмзэг хэсгийг найдвартай хамгаалах чадавхтай болно.

[НҮБ-ын системийн байгууллагууд: ХХААБ, ОУХБ, ОУШХБ, НҮБ-ын ХЭДКГ, НҮБ-ын БШУСБ, НҮБ-ын Хабитит, НҮБ-ын ХС, НҮБ-ын СДХ]

Үр дүн 1.4

Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, жендэрийн мэдрэмжтэй, хүн бүрт хүртээмжтэй, боломжит өртөг бүхий, чанартай ундны ус, ариун цэврийн байгууламж, эрүүл ахуйн үйлчилгээг хүн бүрт хүргэх хүчин чадалтай болно.

[НҮБ-ын системийн байгууллагууд: НҮБ-ын ХЭДКГ, НҮБ-ын ГЭББ, НҮБ-ын БШУСБ, НҮБ-ын ХАС, НҮБ-ын Хабитит, НҮБ-ын ХС, НҮБ-ын ТҮА, НҮБ-ын СДХ, ДЭМБ]

Үр дүн 1.5

Хүн амын эмзэг хэсэгт онцгой анхаарал хандуулахын зэрэгцээ шим тэжээлтэй, эрүүл хоол хүнсийг хүн бүр зохистой түвшинд хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх, хамгаалах, дэмжих чадавх бэхэжсэн байна.

[НҮБ-ын системийн байгууллагууд: ХХААБ, НҮБ-ын ХС, НҮБ-ын АҮХБ, НҮБ-ын СДХ, ДЭМБ]

Үр дүн 1.6

Жендэрийн тэгш байдал, хүний эрх, ялангуяа шилжин суурьшигчдын эрхийг хүндэтгэдэг, хэрэгжүүлдэг нийгэмд, хүртээмжтэй, тэгш хамруулсан, олон салбарыг хамарсан болон жендэрт суурилсан хүчирхийллийн эсрэг хариу арга хэмжээ авах механизмыг бий болгох институцууд болон чадавх бэхэжсэн байна.

[НҮБ-ын системийн байгууллагууд: ОУШХБ, НҮБ-ын ХЭДКГ, НҮБ-ын БШУСБ, НҮБ-ын ХАС, НҮБ-ын Хабитат, НҮБ-ын ХС, НҮБ-ын МБГХТА, НҮБ-ын СДХ, ДЭМБ]



Үр нөлөө:

Үндэсний хөгжлийн тэргүүлэх чиглэлүүд

Алсын хараа - 2050:

- 2.5 Амьдралын хэрэгцээг хангасан эрүүл, ая тухтай, таатай орчныг бүрдүүлж баталгаат хүнсээр хангана.
- 2.6 Хөдөлмөрийн эдийн засгийн тэнцвэрийг хангаж, мэдлэгийн эдийн засгийг бүрдүүлж, иргэн бүрийг ажилтай, орлоготой болгоно.
- 3.3 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, бизнес эрхлэх арга, ур чадварыг хөгжүүлж, жижиг, дунд бизнес эрхлэлтийн өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.
- 3.6 Ухаалаг, иргэн төвтэй газрын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх замаар тэгш байдал, шударга ёс, үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг хангана.
- 4.1 Макро эдийн засгийн тогтвортой орчныг бүрдүүлж, дундаж давхаргыг нийгмийн зонхилох бүлэг болгоно.
- 4.2 Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно.
- 4.4 Бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцад нэгдэж, худалдааг хөнгөвчилнэ.
- 4.5 Олон улсад өрсөлдөх чадвартай бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг хөгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.
- 4.6 Эдийн засгийн төрөлжилт, инновац, шинэ технологи, хүний хөгжил, ногоон хөгжлийн зорилтуудыг дэмжих чадавхтай олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн баялгийн санг бий болгоно.
- 6.1 Байгалийн үнэ цэн, өгөөжийг үнэлэн хамгаалж, анхдагч экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална.
- 6.2 Байгалийн нөөц баялгийг нөхөн сэргээж хомсдолыг бууруулан, ашиглалтын нөөц бий болгож, байгалийн үр өгөөжийг ирээдүй хойч үедээ өвлүүлнэ.
- 6.3 Усны нөөцийн хомсдолоос сэргийлж, гадаргын усыг хуримтлуулан, эрэлт хэрэгцээг хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 6.4 Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон эдийн засгийг хөгжүүлж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах олон улсын хүчин чармайлтад хувь нэмэр оруулна.
- 8.1 Бүс нутгийн эдийн засгийн интеграцад дэд бүтцийн нэгдсэн сүлжээгээр бүрэн холбогдож, эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангах суурь нөхцөлийг бүрдүүлнэ.
- 8.2 Эдийн засгийн тэргүүлэх салбарууд болон байршлын давуу талд тулгуурлан бүс, орон нутагт аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- 8.3 Хөдөө аж ахуйг байгальд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадвартай, нийгмийн хөгжлийн чиг хандлага, хэрэгцээ, шаардлагад нийцсэн, хариуцлагатай, бүтээмж өндөр, тогтвортой үйлдвэрлэлтэй эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ.
- 9.2 Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан, хүлэмжийн хийн ялгарал багатай ногоон технологи бүхий амьдралын таатай орчинтой хот болно.
- 9.5 Үндэсний онцлог бүхий аялал жуулчлал, соёлын үйлчилгээ, үйлдвэрлэлийг бий болгосон, Зүүн хойд Азийн тээвэр, логистикийн болон олон улсын харилцааны зангилаа төв болсон дагуул хотуудыг хөгжүүлнэ.

Бүс нутгийн хамтын ажиллагаа:

Төв Азийн бүс нутгийн Эдийн засгийн хамтын ажиллагаа; БНХАУ-Монгол Улс-ОХУ-ын Эдийн засгийн коридор; Зүүн хойд Азийн Супер сүлжээ; Ази Номхон далайн Худалдааны хэлэлцээр; Ази, Номхон далайн бүс нутгийн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх тухай хэлэлцээр (<https://www.unescap.org/kp/cpta>),

Азийн хурдны замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр <https://www.unescap.org/our-work/transport/asian-highway-network>













Транс Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр <https://www.unescap.org/our-work/transport/trans-asian-railway-network>,

Хуурай боомтын тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр <https://www.unescap.org/our-work/transport/dry-ports-and-intermodal-transport>,

Азийн хурдны сүлжээгээр дамжих олон улсын авто тээврийн тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр, Байгаль орчны хамтын ажиллагааны Зүүн хойд Азийн дэд бүсийн хөтөлбөр (www.neaspec.org)

Ази Номхон Далайн Эрсдэл, Эрсдэл даах сүлжээ, Портал (<https://rrp.unescap.org/>)

ТХЗ-ууд:

-  ТХЗ 1 Ядуурлыг устгах (Зорилтууд 1.1, 1.2, 1.4);
-  ТХЗ 2 Хүнсний аюулгүй байдлыг хангаж, хоол тэжээлийн чанарыг сайжруулж, хөдөө аж ахуйн тогтвортой өсөлтийг хөхиүлэн дэмжих (Зорилтууд 2.3, 2.4, 2.5, 2a, 2b, 2c);
-  ТХЗ 4 Хүн бүрт чанартай боловсролыг тэгш, хүртээмжтэй эзэмших, насан турш сурч боловсрох нөхцөлийг бүрдүүлэх (Зорилтууд 4.1, 4.2, 4.3, 4.7);
-  ТХЗ 5 Жендэрийн эрх тэгш байдлыг хангаж, нийт эмэгтэйчүүд, охидыг эрх мэдэлжүүлэх (Зорилтууд 5a, 5b);
-  ТХЗ 6 Нийт хүн амыг ундны усаар хангаж, ариун цэврийн байгууламжийг хүртээмжтэй болгох, тогтвортой менежментийг хэрэгжүүлэх (Зорилтууд 6.1 ба 6.2);
-  ТХЗ 7 Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх (Зорилтууд 7.1, 7.2, 7.3, 7.a, 7.b);
-  ТХЗ 8 Эдийн засгийн өсөлт, зохистой хөдөлмөрийг дэмжих (Зорилтууд 8.1, 8.2, 8.3, 8.4, 8.5, 8.6, 8.7, 8.8, 8.9, 8.10, 8.a, 8.b);
-  ТХЗ 9 Эрсдэл даах чадвартай дэд бүтцийг бий болгож, хүртээмжтэй, тогтвортой үйлдвэржилтийг дэмжиж, эрс шинэлэг дэд бүтцийг хөгжүүлж, дэмжих (Зорилтууд 9.1, 9.2, 9.3, 9.4, 9.5, 9.a, 9.b);
-  ТХЗ 10 Тэгш бус байдлыг бууруулах (Зорилтууд 10.1, 10.2, 10.3, 10.4, 10.6, 10.7, 10.a, 10.b);
-  ТХЗ 11 Ээлтэй, хүртээмжтэй хот, хүн амын суурьшлыг хөгжүүлэх (Зорилтууд 11.5, 11.a, 11.b);
-  ТХЗ 12 Хариуцлагатай хэрэглээг дэмжих (Зорилтууд 12.1, 12.2, 12.3, 12.5, 12.6, 12.7, 12.8, 12.a, 12.b, 12.c);
-  ТХЗ 13 Уур амьсгалын өөрчлөлт, түүний үр дагавартай тэмцэх шуурхай арга хэмжээ авах (Зорилтууд 13.1, 13.2, 13.b)



ТХЗ 15 Газрын экосистемийг хамгаалах, нөхөн сэргээх, тогтвортой ашиглах, ойг тогтвортой удирдах, цөлжилттэй тэмцэх, газрын доройтлыг зогсоох, нөхөн сэргээх, биологийн олон янз байдлыг хамгаалах (Зорилтууд 15.1, 15.2, 15.3, 15.4, 15.6, 15a)



ТХЗ 17 Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх (Зорилтууд 17.1, 17.2, 17.3, 17.4, 17.5, 17.6, 17.7, 17.8, 17.9, 17.10, 17.11, 17.12, 17.15, 17.16)

Гол түншүүд:

- Барилга, хот байгуулалтын яам
- Соёлын яам
- Эдийн засаг, хөгжлийн яам
- Боловсрол, шинжлэх ухааны яам
- Байгаль орчин, аялал жуулчлалын яам
- Гадаад харилцааны яам
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
- Эрүүл мэндийн яам
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
- Үндэсний статистикийн хороо
- Монгол банк
- Жендэрийн үндэсний хороо
- Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо
- Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо
- Иргэний нийгмийн байгууллагууд
- Хувийн хэвшил
- Азийн хөгжлийн банк
- Европын холбоо
- Европын сэргээн босголт, хөгжлийн банк
- Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг
- Олон улсын валютын сан
- Японы Олон улсын хамтын ажиллагааны агентлаг
- БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны агентлаг
- Дэлхийн банк

Хамтран ажиллах НҮБ-ын системийн байгууллагууд:

ХХААБ, ХААХОУС, ОУХБ, ОУШХБ, ОУХТ, ОУЦХН, НҮБ-ын ХЭДКГ, НҮБ-ын ХХБХ, НҮБ-ын ХХ, НҮБ-ын ГЭББ, НҮБ-ын БОХ, НҮБ-ын АНДЭЗНК, НҮБ-ын БСШУБ, НҮБ-ын ХАС, НҮБ-ын Хабитит, НҮБ-ын ХС, НҮБ-ын АҮХБ, НҮБ-ын МБГХТА, НҮБ-ын ТҮА, НҮБ-ын СДХ, ДЭМБ.

Үр дүнгүүд	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд (нарийвчилсан задаргаатай)	Суурь түвшин (он)	Зорилт (ХАХ хэрэгжиж дуусахад)	Мэдээллийн эх сурвалж/ Баталгаажуулах арга хэрэгсэл	Тавигдах нөхцөл
Үр дүнгийн зорилт 2: 2027 он гэхэд Монгол Улсын эдийн засаг илүү төрөлжсөн, шинэлэг, бүтээмжтэй, хүртээмжтэй, “ногоон” болж, бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг ханган, ялангуяа эмэгтэйчүүд, залуучуудын зохистой амьжиргааг тэтгэх, XXI зууны эрэлт хэрэгцээтэй ур чадварыг хөгжүүлэх, нүүрсхүчлийн хий бага ялгаруулах хөгжлийг дэмжинэ.	2.1 Нийт эрчим хүчний эцсийн хэрэглээнд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь [ТХЗ 7.2.1]	3.4% (2018) (Дэлхийн банк)	12%	БОАЖЯ/ ТХЗ-ын мэдээллийн сан	Засгийн газар нүүрсхүчлийн хий бага ялгаруулах хөгжлийн замналыг сонгох улс төрийн хүсэл зоригоо илэрхийлж, үүрэг амлалт авсан байх
	2.2 Зэрэгцүүлэх үнээр тооцсон нэг ажилтанд ногдох ДНБ-ий жилийн өсөлт [ТХЗ 8.2.1]	6.3% (2020)	4.2%	ҮСХ/ ТХЗ-ын мэдээллийн сан	Нүүрсхүчлийн хий бага ялгаруулах хөгжлийн зорилтын эсрэг ашиг сонирхлын зөрчил гаргахгүй байх
	2.3 Ажилгүйдлийн түвшин (хувиар), байршил, хүйс, нас, хөгжлийн бэрхшээлийн байдлаар [ТХЗ 8.5.2]	7% (2020) Хүйсээр: Эм -6.7% Эр – 7.3% Байршлаар: Хот – 8% Хөдөө – 4.6% Насны бүлгээр: 15-24 -17.9% 25-64 – 5.9% Хөдөлмөрийн бэрхшээлийн статусаар: Хөгжлийн бэрхшээлтэй -7% Хөгжлийн бэрхшээлгүй -7.2%	Суурь түвшнээс бага* (*энэ үзүүлэлтээр үндэсний хэмжээнд зорилт дэвшүүлээгүй)	ҮСХ/ ТХЗ-ын мэдээллийн сан	КОВИД-19 цар тахлын нөхцөл байдлыг хяналтдаа оруулж, цар тахлын давлагаа арилсан, байх Бүс нутгийн эдийн засгийн хямралын хор уршиг нөлөөлөхгүй байх Дэд бүтэц, өртгийн шинэ сүлжээг бий болгох, эрс шинэчлэл, цахим шилжилтэд хангалттай хөрөнгө оруулалт хийх
	2.4 ДНБ-д боловсруулах үйлдвэрлэлийн нэмүү өртгийн эзлэх хувь, [ТХЗ 9.2.1]	ДНБ-д эзлэх хувь – 10.8% (2019) [Эх сурвалж: НҮБАҮХБ] Нэг хүнд ногдох: 900,000 төг (2020)	19%	ҮСХ/ ТХЗ-ын мэдээллийн сан	Засгийн газар хүний хөгжил, газарзүйн тэнцвэртэй хөгжлийг хангахад чиглэсэн хөрөнгө оруулалтыг дэмжих
	2.5 ДНБ-д судалгаа, хөгжүүлэлтийн салбарын зардлын эзлэх хувь [ТХЗ 9.5.1]	0.55% (2020)	2.5%	ҮСХ/ ТХЗ-ын мэдээллийн сан	Макро эдийн засгийн байдал тогтвортой, төрийн үйлчилгээг хүргэх төсвийн орон зайг хязгаарлах санхүүгийн хямрал нүүрлэхгүй байх
	2.6 Цахим засаглал хөгжлийн индекс (EGDI)	Эрэмбэ: 92 Оноо: 0.6497 (2020)	Суурь түвшингээс өндөр* (*энэ үзүүлэлтээр үндэсний хэмжээнд зорилт дэвшүүлээгүй)	НҮБ-ын Цахим засаглал судалгаа	

Үр дүнгүүд

Үр дүн 2.1 ▶ Эмэгтэйчүүд, залуучуудын ур чадвар эзэмших, дахин мэргэших, сайн дурынхны оролцоог хангах боломжийг өргөжүүлж бизнес эрхлэх сургалтыг зохион байгуулан тэдний зохистой хөдөлмөр эрхлэх, ажилд ороход шаардагдах бүтээлч чадварыг дээшлүүлэх, түүнчлэн дотоод, гадаадын шилжих хөдөлгөөнийг илүү үр дүнтэй удирдах зэргээр эмэгтэйчүүд, залуучууд, орхигдох эрсдэлтэй хүн амын бүлгүүдийн ажиллах хүчний оролцоог нэмэгдүүлэх институцийн чадавхыг бэхжүүлнэ.

[НҮБ-ын системийн байгууллагууд: ХХААБ, ХААХОУС, ОУХБ, ОУШХБ, ОУЦХН, НҮБ-ын ХЭДКГ, НҮБ-ын ХХ, НҮБ-ын БСШУБ, НҮБ-ын ХАС, НҮБ-ын ХС, НҮБ-ын АҮХБ, НҮБ-ын СДХ]

Үр дүн 2.2 ▶ Эдийн засгийг төрөлжүүлж, нөөцийг үр ашигтай зарцуулах арга хандлагад шилжих, нүүрсхүчлийн хий бага ялгаруулах хөгжил, цахим шилжилтийг дэмжих, улмаар өрсөлдөх чадвартай, технологийн хувьд эрс шинэлэг, бүтээлч, бүтээмжтэй эдийн засгийг хөгжүүлэх, жижиг аж ахуйн нэгжүүд ногоон үйл ажиллагаа эрхлэх, олон улсын нэмүү өртгийн сүлжээнд холбогдох, албан ёсны эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэх боломжийг нэмэгдүүлэх, алагчлал, ялгаварлалд өртөмтгий нутгийн иргэдэд учирч болзошгүй гэнэтийн эрсдэлийг бууруулах нөөцийг үр ашигтай, тогтвортой ашиглах зэрэг нөхцөлийг хангасан бодлого, стратеги, институцууд бий болсон байна.

[НҮБ-ын системийн байгууллагууд: ХХААБ, ОУХБ, ОУХТ, ОУЦХН, НҮБ-ын ХХБХ, НҮБ-ын ХХ, НҮБ-ын БОХ, НҮБ-ын АНДЭЗНК, НҮБ-ын БСШУБ, НҮБ-ын ХС, НҮБ-ын АҮХБ]

Үр дүн 2.3 ▶ Ил тод, урьдчилан тооцоолох боломжтой хөрөнгө оруулалтын орчныг бүрдүүлэх, үр ашигтай, нүүрсхүчлийн хий бага ялгаруулах хөгжилд чиглэсэн хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих эрс шинэлэг санхүүжилтийн тогтолцоог бий болгох Засгийн газрын чадавх бэхжиж, бизнесийн хариуцлагатай хэрэглээ, үйлдвэрлэлийг дэмжих, ялангуяа уул уурхайн салбарт татварын тэгш, шударга бодлогыг хэрэгжүүлж татварын удирдлагыг сайжруулах замаар илүү их орлого төвлөрүүлэх, хүний эрхийг дээдлэх, нийгэм, байгаль орчин, өмч хөрөнгөд ээлтэй бодлогууд хэрэгжинэ.

[НҮБ-ын системийн байгууллагууд: ХХААБ, НҮБ-ын ХХ, НҮБ-ын БОХ, НҮБ-ын Хабитит, НҮБ-ын ХС, НҮБ-ын АҮХБ, НҮБ-ын ТҮА]

Үр дүнгүүд	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд (нарийвчилсан задаргаатай)	Суурь түвшин (он)	Зорилт (ХАХ хэрэгжиж дуусахад)	Мэдээллийн эх сурвалж/ Баталгаажуулах арга хэрэгсэл	Тавигдах нөхцөл
Үр дүнгийн зорилт 3: Нотолгоонд суурилсан, жендэрийн мэдрэмжтэй, байгалийн нөөц, байгаль орчны тогтвортой менежмент, гамшгийн эрсдэлийг бууруулах чадавх сайжирснаар 2027 он гэхэд Монгол Улсын хүн ам, экосистем уур амьсгалын өөрчлөлтөд илүү тэсвэртэй болсон байна.	3.1 Орон нутгийн хүн амын бүлгүүдийн эрсдэл даах чадавхын индекс [ТХЗ 13.2.1]	40.7	58.7		Засгийн газар уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, мэдрэмжтэй үндэсний болон орон нутгийн түвшний стратеги, бодлого, хууль тогтоомж, төлөвлөлт, хөгжлийн институт, эрх зүйн зохицуулалтын тогтолцоог бэхжүүлэхийн төлөө тууштай ажиллах,
	3.2 Нийт газар нутагт ойгоор бүрхэгдсэн газар нутгийн эзлэх хувь [ТХЗ 15.1.1]	7.9% (2019)	8.7%	БОАЖЯ	КОВИД-19 цар тахлын нөхцөл байдлыг хяналтдаа оруулж, цар тахлын давалгаа арилсан, байх, Уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны тогтвортой байдал зэрэг суурь асуудалд богино хугацааны эдийн засгийн ашиг сонирхол нөлөөлөхгүй байх,
	3.3 Тусгай хамгаалалттай газар нутаг дахь эх болон, хуурай газар нутаг, цэнгэг усны биологийн олон янз байдлын томоохон газруудын эзлэх хувь, экосистемийн төрлөөр [ТХЗ 15.1.2]	Тусгай хамгаалалттай газар нутаг (17.4), Усны сав газар (44.75) Ойн сан бүхий газар (36.8) % (2015)	Тусгай хамгаалалттай газар нутаг (27), Усны сав газар (55) Ойн сан бүхий газар (48.7)%	БОАЖЯ	Байгаль орчны тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд олон нийтийн сонирхол, мэдлэг, оролцоо хангалттай байх
	3.4 Нийт газар нутагт доройтолд орсон газар нутгийн эзлэх хувь [ТХЗ 15.3.1]	Нийт 13.7% (2015)	13.7%	http://irimhe.namem.gov.mn/?cat=5&type=news&action=more&id=246	Гамшгийн эрсдэл, түүний эсрэг хариу арга хэмжээ авахад хөрөнгө оруулалт хийхээс илүүтэйгээр урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах хэрэгцээ, ач холбогдлын талаарх улс төрийн ойлголт, хүсэл зориг өндөр байх. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн

Үр дүнгүүд

Үр дүн 3.1 ▶ Дасан зохицох чадавхыг сайжруулж, нийгэм, эдийн засгийн эмзэг байдлыг бууруулах, гамшгийн улмаас нүүлгэн шилжүүлэх эрсдэлийг сааруулахын тулд уур амьсгалын өөрчлөлтөд мэдрэмжтэй хариу арга хэмжээ авах төлөвлөлт, хөгжлийн эрх зүйн зохицуулалтын тогтолцоо бэхэжсэн байна.

[НҮБ-ын системийн байгууллагууд: ХХААБ, ХААХОУС, ОУШХБ, ОУЦХН, НҮБ-ын ХЭДКГ, НҮБ-ын ХХ, НҮБ-ын ГЭББ, НҮБ-ын БОХ, НҮБ-ын АНДЭЗНК, НҮБ-ын Хабитит, НҮБ-ын ХС, НҮБ-ын ТҮА, ДЭМБ]

Үр дүн 3.2 ▶ Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг тооцсон, газар, ой, биологийн олон янз байдал, ус зэрэг байгалийн нөөцийн тогтвортой менежмент, мал аж ахуйн бүтээгдэхүүний өртгийн сүлжээг сайжруулах, онцгой байдлын үед авах арга хэмжээг үр дүнтэй төлөвлөх, зохицуулах зэргээр байгалийн нөөцөөс ихээхэн хамааралтай малчдын нөхөрлөлүүдийн эрсдэл даах чадварыг бэхжүүлнэ.

[НҮБ-ын системийн байгууллагууд: ХХААБ, ХААХОУС, ОУХБ, ОУЦХН, НҮБ-ын ХЭДКГ, НҮБ-ын ХХ, НҮБ-ын БОХ, НҮБ-ын БСШУБ, НҮБ-ын АҮХБ, НҮБ-ын ТҮА]

Үр дүн 3.3 ▶ Байгалийн нөөцийн тогтвортой менежмент, биологийн олон янз байдлын алдагдлыг бууруулж экосистемийн үйлчилгээг сайжруулах талаар мэргэжлийн мэдлэг чадвартай институцууд, аж ахуйн нэгжүүд, хүн амын бүлгүүд төлөвшсөн, генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглан гарах ашиг, үр шимийг тэгш, шударгаар хуваалцах, ялангуяа малчдад хүртээмжтэй байх нөхцөл бүрдсэн, чадавх бэхэжсэн байна.

[НҮБ-ын системийн байгууллагууд: ХХААБ, ХААХОУС, НҮБ-ын ХЭДКГ, НҮБ-ын ХХ, НҮБ-ын БОХ, НҮБ-ын АНДЭЗНК, НҮБ-ын БСШУБ, НҮБ-ын Хабитит, НҮБ-ын МБГХТА, НҮБ-ын ТҮА, НҮБ-ын СДХ]



Үр нөлөө:

Үндэсний хөгжлийн тэргүүлэх чиглэлүүд











Алсын хараа 2050-ын Зорилтууд:

- 3.6 Ухаалаг, иргэн төвтэй газрын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх замаар тэгш байдал, шударга ёс, үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг хангана.
- 5.1 Эрх мэдлийн хуваарилалт, хяналт, тэнцлийг оновчтой болгож, засаглалын тогтвортой байдлыг хангана.
- 5.2 Төрийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тодорхойлох замаар чиг үүрэг, эрх мэдлийн хуваарилалтыг нарийвчилна.
- 5.3 Хүний хөгжлийг дэмжсэн, үр дүн, үр нөлөөтэй цахим засаглалыг төлөвшүүлнэ.
- 5.4 Иргэндээ үйлчилдэг, мэргэшсэн, чадварлаг, ил тод, үр нөлөөтэй, ухаалаг төрийн албыг төлөвшүүлнэ.
- 5.5 Иргэний нийгэм-хувийн хэвшил-төрийн түншлэлийг бэхжүүлэх замаар үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилтэд хамаарал бүхий талуудын оролцоог хангасан зохистой тогтолцоог бүрдүүлнэ.
- 5.6 Үндэсний шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх замаар авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулна.
- 7.3 Уламжлалт бус аюулын эрсдэлийг бууруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхыг бэхжүүлж, хүн-нийгмийн амар тайван орчныг бүрдүүлнэ
- 7.4 Хууль сахиулах салбарын хууль, эрх зүйн орчныг сайжруулан, бүтээн байгуулалтыг дэмжиж, ажиллах нөхцөлийг дээшлүүлж, мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бэлтгэн өрсөлдөх чадварыг хөгжүүлнэ.
- 7.5 Төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулж, өрсөлдөх чадварыг бий болгоно.
- 9.3 Орон зайн оновчтой төлөвлөлт бүхий суурьшлын зөв тогтолцоотой, эрчимтэй хөгжиж байгаа дагуул хотуудтай олон улсад өрсөлдөгч метрополитан болж хөгжинэ.
- 9.4 Хууль, эрх зүйн тогтвортой орчинтой, хотын дүрэм, стандартыг хангуулсан сайн засаглалтай хот болно.

Бүс нутгийн хамтын ажиллагааны механизмууд:

Варшавын тунхаглал, Ази-Европын уулзалт, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага, Ази, Номхон далайн бүс нутгийн Хүний эрхийн үндэсний байгууллагуудын Чуулган, Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудын Иргэний бүртгэл, хүн амын статистикийн Үйл ажиллагааны хүрээ https://www.unescap.org/sites/default/d8files/event-documents/ESCAP_MCCRVS_2021_8_Add.1_ministerial_declaration_English.pdf; Ази, Номхон далайн бүс нутгийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн “Эрхийг нь бодитой болгох” Инчоны стратеги.

ТХЗ-ууд, Зорилтууд:

-  ТХЗ 1 Ядуурлыг устгах (Зорилтууд 1.а; 1.б)
-  ТХЗ 5 Жендэрийн эрх тэгш байдлыг хангаж, бүх эмэгтэйчүүд, охидыг эрх мэдэлжүүлэх (Зорилтууд 5.1; 5.с)
-  ТХЗ 8 Эдийн засгийн өсөлт, зохистой хөдөлмөр (Зорилтууд 8.5, 8.7, 8.8)
-  ТХЗ 9 Дэд бүтцийг сайжруулж, эрс шинэчлэлийг дэмжих (Зорилт 9.с)
-  ТХЗ 10 Тэгш бус байдлыг бууруулах (Зорилтууд 10.2; 10.3; 10.5; 10.6)
-  ТХЗ 11 Ээлтэй, хүртээмжтэй хот, хүн амын суурьшлыг дэмжих (Зорилтууд 11.3; 11.а)
-  ТХЗ 12 Хариуцлагатай хэрэглээг дэмжих (Зорилтууд 12.7; 12.8)
-  ТХЗ 13 Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг багасгах (Зорилт 13.2)
-  ТХЗ 16 Энх тайван, шударга ёсыг цогцлоох (Зорилтууд 16.1; 16.2; 16.3; 16.5; 16.6; 16.7; 16.9; 16.б)
-  ТХЗ 17 Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх (Зорилтууд 17.2; 17.3; 17.5; 17.6; 17.8; 17.9; 17.12; 17.13; 17.16; 17.17; 17.18)

Гол түншүүд:

- Монгол Улсын Их Хурал
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
- Цахим хөгжил, харилцаа холбооны яам
- Эдийн засаг, хөгжлийн яам
- Гадаад харилцааны яам
- Хууль зүй, дотоод хэргийн яам
- Үндэсний статистикийн хороо
- Хүний эрхийн Үндэсний Комисс
- Жендэрийн үндэсний хороо
- Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо
- Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо
- Иргэний нийгмийн байгууллагууд
- Азийн хөгжлийн банк
- Европын холбоо
- Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг
- Олон улсын төрийн бус байгууллагууд
- Японы Олон улсын хамтын ажиллагааны агентлаг
- БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны агентлаг
- БНТУ-ын Олон улсын хамтын ажиллагааны агентлаг
- АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг
- Дэлхийн банк

Хамтран ажиллах НҮБ-ын системийн байгууллагууд:

ХХААБ, ОУХБ, ОУШХБ, ОУЦХН, НҮБ-ын ХЭДКГ, НҮБ-ын ДОХ-ын НХ, НҮБ-ын ХХ, НҮБ-ын АНДЭЗНК, НҮБ-ын БШУСБ, НҮБ-ын ХАС, НҮБ-ын Хабитит, НҮБ-ын ХС, НҮБ-ын МБГХТА НҮБ-ын ТҮА, НҮБ-ын СДХ, НҮБ-ын Эмэгтэйчүүд, ДЭМБ.

Үр дүнгүүд	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд (нарийвчилсан задаргаатай)	Суурь түвшин (он)	Зорилт (ХАХ хэрэгжиж дуусахад)	Мэдээллийн эх сурвалж/ Баталгаажуулах арга хэрэгсэл	Тавигдах нөхцөл	
Үр дүнгийн зорилт 4: 2027 он гэхэд Монгол Улсын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл явц нь жендэрийн мэдрэмжтэй, оролцоог хангасан, харилцан уялдаатай, нотолгоонд суурилсан, ТХЗ-той уялдсан, бүх шатны засаглалын байгууллагууд ил тод, хариуцлагатай ажиллаж, хүний эрхийг бүрэн хангаж хамгаалсан, тэгш шударга, эрх зүйт ёсыг хүн бүр, ялангуяа орхигдох эрсдэлтэй хүн амын бүлгүүд ялгаваргүй эдлэх боломж нөхцөл бүрдсэн байна	4.1 Шийдвэр гаргах үйл явц хүртээмжтэй, хариуцлагатай гэдэгт итгэдэг хүн амын эзлэх хувь [ТХЗ 16.7.2]	57.1 (2019)	65.8	ҮСХ	Засгийн газар олон улсын хүний эрхийн гэрээгээр хүлээсэн үүрэг, хөдөлмөрийн хууль тогтоомжийг дагаж мөрддөг байх,	
	4.2 Олон улсын хүний эрхийн хуулиар хориглосон ялгаварлан гадуурхах явдлын аль нэг тохиолдлоор сүүлийн 12 сард гадуурхагдсан, доромжлуулснаа мэдэрсэн хүн амын эзлэх хувь, эрхийн төрлөөр (ТХЗ 16.b.1 a)	17.7 (2019)	Суурь түвшнээс доогуур*	(*энэ үзүүлэлтээр үндэсний хэмжээнд зорилт дэвшүүлээгүй		ҮСХ
	16.b.14.2 (a) Олон улсын хүний эрхийн хуулиар хориглосон ялгаварлан гадуурхах явдлын аль нэг тохиолдлоор сүүлийн 12 сард гадуурхагдсан, доромжлуулснаа мэдүүлсэн хүн амын эзлэх хувь	4.5 (2019)	Суурь түвшнээс өндөр*	(*энэ үзүүлэлтээр үндэсний хэмжээнд зорилт дэвшүүлээгүй	ҮСХ	КОВИД-19 цар тахлын нөхцөл байдлыг хяналтдаа оруулж, цар тахлын давалгаа арилсан, байх,
	4.3 Эрх зүйт ёсны индекс	45.67 (эрэмбэ) (2020) -0.26 (утга) (2020)	Суурь түвшнээс өндөр* (*энэ үзүүлэлтээр үндэсний хэмжээнд зорилт дэвшүүлээгүй	Дэлхийн банк, Дэлхийн засаглалын үзүүлэлтүүд	Тоо мэдээллийг нарийвчилсан задаргаатайгаар цуглуулах, бодлого шийдвэрлэх гаргахдаа ашиглах тогтолцоог бий болгох сонирхолтой байх,	
	4.4. (a) УИХ болон (б) орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын нийт суудалд эмэгтэйчүүдийн эзлэх хувь	(a) 17% (2020) (b) 27% (2020)	(a) 24.6% (2024) (b) 37.4% (2024)	ҮСХ, ҮХГ	Төрийн захиргааны удирдлагыг шинэчлэх улс төрийн хүсэл зоригтой байх,	
	4.5 Авлигын төсөөллийн индекс	35 (утга) (2020) 111(эрэмбэ) (2020)	38 94 ²¹	Транспэрэнси Интернэшнл https://www.transparency.org/en/cpi/2020/index/mng	Төрийн үйлчилгээг үр дүнтэй хүргэхийн тулд цахим шилжилтэд хөрөнгө оруулалт хийх,	
	4.6 Залуучуудын хөгжлийн индекс (ерөнхий оноо)	0.758 (2020)	Суурь оны үзүүлэлтээс өндөр* (*энэ үзүүлэлтээр үндэсний хэмжээнд зорилт дэвшүүлээгүй	Залуучуудын хөгжлийн олон улсын индекс, тайлан https://youth-development-index.thecommonwealth.org/	Төрийн үйлчилгээг хүргэх төсөвт хязгаарлалт хийхгүй байх.	

²¹ Хамгийн сүүлийн мэдээллээр (2020) Монгол Улс авбал зохих нийт 100 онооноос 35 оноо авч, 111 дүгээр байрт эрэмбэлэгдсэн байна. Монгол Улсын Засгийн газар 2023 он гэхэд Монгол Улсын Авлигын төсөөллийн индекс (АТИ)-ийг 100-аас доош болгон бууруулах зорилт тавин ажиллаж байна. Иймд Монгол Улс 2023 он гэхэд 100 дугаар байрт эрэмбэлэгдэнэ хэмээн тооцож, цаашид жил тутамд 2 байраар бууруулж чадвал 2027 онд Монгол Улсын АТИ 94 дүгээрт эрэмбэлэгдэнэ гэж тооцоолов. АТИ 2020-ийн тооцооллоос харахад одоогоор 94-р байрт жагсаж буй улс орнууд 38/100 онооны шалгуур хангажээ. Холбогдох мэдээллийг доорх холбоосуудаас үзнэ үү <https://legalinfo.mn/mn/detail?awld=16231084041711>; <https://montsame.mn/mn/read/269824>; <https://www.transparency.org/en/cpi/2020/index/mng>

Үр дүнгүүд

Үр дүн 4.1 ▶ Жендэрийн эрх тэгш байдал, хөдөлмөрлөх эрх зэрэг асуудлаар хүн амын эмзэг хэсгийн эрхийг хамгаалах, дэмжих, хяналт тавих эрх үүрэг бүхий шүүх засаглалын байгууллагууд, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, иргэний нийгмийн байгууллагуудын чадавх сайжирна.

[НҮБ-ын системийн байгууллагууд: ОУХБ, НҮБ-ын ХЭДКГ, НҮБ-ын ДОХ-ын НХ, НҮБ-ын ХХ, НҮБ-ын ХАС, НҮБ-ын Эмэгтэйчүүд, ДЭМБ]

Үр дүн 4.2 ▶ Бодлогын үнэлгээг тогтмол хийх, нөлөөлөл, сурталчилгаа, сургалт мэдээллийн үйл ажиллагааг өргөжүүлэх зэргээр эмэгтэйчүүд, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эсрэг хүчирхийлэл, дарамт, хүн худалдаалах гэмт хэрэг зэргээс үр дүнтэй урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, жендэрийн эрх тэгш байдлыг хангах механизм, үйл явцыг сайжруулна.

[НҮБ-ын системийн байгууллагууд: ХХААБ, ОУХБ, ОУШХБ, НҮБ-ын ХЭДКГ, НҮБ-ын ХХ, НҮБ-ын ХАС, НҮБ-ын МБГХТА]

Үр дүн 4.3 ▶ Төв, орон нутгийн оролцогч талуудын үйлчилгээг ил тод, хүн төвтэй, үр нөлөө гарахуйцаар үр дүнтэй хүргэх чадавх цахим шилжилт хийснээр сайжирч, нотолгоонд суурилж бодлого боловсруулах, хяналт шинжилгээ хийх, тайлагнах үйл явцыг харилцан уялдуулж, бодлого шийдвэр гаргахад иргэд оролцох боломжийг бүрдүүлснээр эрх баригчдаас үр дүнгийн хариуцлага нэхэх чадвар эзэмшсэн байна.

[НҮБ-ын системийн байгууллагууд: ХХААБ, ОУЦХН, НҮБ-ын ХЭДКГ, НҮБ-ын ХХ, НҮБ-ын АНДЭЗНК, НҮБ-ын БШУСБ, НҮБ-ын ХАС, НҮБ-ын Хабитит, НҮБ-ын ХС, НҮБ-ын МБГХТА, НҮБ-ын ТҮА, НҮБ-ын СДХ]

Үр дүн 4.4 ▶ Иргэний нийгэм, залуучуудын зөвлөл, эмэгтэйчүүд, залуучуудын сүлжээгээр дамжуулан үндэсний болон орон нутгийн сонгуулиуд, шийдвэр гаргах байгууллагууд дахь эмэгтэйчүүд, залуучуудын төлөөлөл, оролцоог нэмэгдүүлнэ.

[НҮБ-ын системийн байгууллагууд: НҮБ-ын ХЭДКГ, НҮБ-ын ХХ, НҮБ-ын ХАС]

ХАВСРАЛТ 2:

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Энэхүү эрх зүйн зохицуулалт нь НҮБ-ын Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээ (2023-2027 он)-г хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж буй НҮБ-ын байгууллага тус бүрийн болон Монгол Улсын Засгийн газар хоорондын харилцааны эрх зүйн үндсийг тодорхойлсон хамтын ажиллагааны буюу туслалцааны хэлэлцээр, бусад гэрээ, хэлэлцээрийг агуулсан болно.

Монгол Улсын Засгийн газар (цаашид “Засгийн газар” гэх) нь НҮБ-ын системийн байгууллагуудтай дараах эрх зүйн харилцаа тогтоосон байна. Үүнд:

- a) **НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр** (НҮБ-ын ХХ)-ийн хувьд, тухайн улсад үзүүлэх НҮБ-ын ХХ-ийн туслалцааг зохицуулах суурь гэрээ буюу Туслалцааны талаарх үндсэн жишиг хэлэлцээр (ТТҮЖХ)-ийг Монгол Улсын Засгийн газар болон НҮБ-ын ХХ-ын хооронд 1976 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр байгуулсан. НҮБ-ын Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээ (НҮБ-ын ТХХАХ) баримт бичигт НҮБ-ын ХХ-ийн хөтөлбөрийн үйл ажиллагааг тусгайлан заасан хамтарсан үр дүнгийн төлөвлөгөөний хамт (НҮБ-ын ТХХАХ-ний нэг хэсэг бөгөөд хавсралтаар оруулах) ТТҮЖХ-т заасан “төслийн баримт бичиг”-ийн хамт иж бүрдэл болно. Хэрэгжүүлэгч тал болон НҮБ-ын ХХ нь холбогдох төслийн баримт бичгийн дагуу төсөл тус бүрийн тусгайлсан зохицуулалтыг агуулсан Төсөл хэрэгжүүлэх гэрээнд гарын үсэг зурна.
- b) **НҮБ-ын Хүүхдийн сан** (НҮБ-ын ХС)-гийн хувьд, Монгол Улсын Засгийн газар болон НҮБ-ын ХС-гийн хооронд Хамтын ажиллагааны үндсэн хэлэлцээр (ХАҮХ)-ийг 1994 оны 2 дугаар сарын 8-ны өдөр байгуулсан.
- c) **НҮБ-ын Хүн амын сан** (НҮБ-ын ХАС)-гийн хувьд, Монгол Улсын Засгийн газар болон НҮБ-ын ХХ-ийн хооронд 1976 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр байгуулсан Туслалцааны талаарх үндсэн жишиг хэлэлцээр (ТТҮЖХ), мөн Монгол Улсын Засгийн газар болон НҮБ-ын ХАС хооронд байгуулж, (харилцан албан захидал солилцон) 1999 оны 8 дугаар сарын 27-ны өдөр хүчин төгөлдөр болсон хэлэлцээр нь НҮБ-ын Хүн амын сангийн үйл ажиллагаа, боловсон хүчний асуудалд нэгэн адил хамаарна.
- d) **НҮБ-ын Аж үйлдвэр хөгжлийн байгууллага** (НҮБ-ын АҮХБ)-ын хувьд, Монгол Улсын Засгийн газар болон НҮБ-ын ХХ-ийн хооронд 1976 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр байгуулсан Туслалцааны талаарх үндсэн жишиг хэлэлцээр (ТТҮЖХ) үйлчлэх бөгөөд уг хэлэлцээрийг Монгол Улс дахь НҮБ-ын АҮХБ-ын төслүүд дагаж мөрдөнө.
- e) **НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага** (ХХААБ)-ын хувьд, ХХААБ 2008 оны 8 дугаар сарын 11-нд, Монгол Улсын Засгийн газар мөн оны 8 дугаар сарын 26-ны өдөр харилцан захидал солилцоноор Монгол Улсын Засгийн газар болон ХХААБ-ын хооронд хэлэлцээр байгуулсан.
- f) **Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага** (ОУШХБ)-ын хувьд, Монгол Улсын Засгийн газар болон ОУШХБ хооронд Хамтын ажиллагааны үндсэн хэлэлцээр (ХАҮХ)-ийг 2010 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр байгуулсан.
- g) **НҮБ-ын Хүн амын суурьшлын хөтөлбөр** (НҮБ-ын Хабитат)-ийн хувьд, Монгол Улсын Засгийн газар болон НҮБ-ын ХХ-ийн хооронд байгуулсан Туслалцааны талаарх үндсэн жишиг хэлэлцээр (ТТҮЖХ) мөн адил үйлчилнэ.
- h) **Олон улсын хөдөлмөрийн байгууллага** (ОУХБ)-ын хувьд, 1947 оны Мэргэжлийн байгууллагуудын давуу эрх, халдашгүй байдлын тухай конвенц, түүний I хавсралтад 1970 оны 3 дугаар сарын 3-ны өдөр Монгол Улс нэгдэн орсон, мөн Монгол Улсын Засгийн газар болон ОУХБ, бусад мэргэжлийн байгууллагуудын хооронд Техникийн туслалцааны хэлэлцээр (ТТХ)-ийг 1963 оны 5 дугаар сарын 24-ний өдөр байгуулсан.

- i) [Дэлхийн эрүүл мэндийн байгууллага](#) (ДЭМБ)-ын хувьд Монгол Улсын Засгийн газар болон ДЭМБ хооронд Хамтын ажиллагааны үндсэн хэлэлцээр (ХАҮХ)-ийг 1968 оны 6 дугаар сарын 15-ны өдөр байгуулсан.
- j) [НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага](#) (НҮБ-ын БШУСБ)-ын хувьд, Монгол Улсын Засгийн газар болон НҮБ-ын БШУСБ хооронд Хамтран ажиллах санамж бичигт 2017 оны 2 дугаар сарын 20-ны өдөр гарын үсэг зурсан.
- к) [Хүний эрхийн Дээд Комиссарын Газар](#) (ХЭДКГ)-ын Хамтын ажиллагааны хүрээнд оролцох оролцоо нь НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1993 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 48/141 тоот тогтоолд баталгаажуулсан тус байгууллагын эрх хэмжээний дагуу хэрэгжинэ.
- l) Мэргэжлийн байгууллагуудын эрх ямба, халдашгүй байдлын тухай конвенц, түүний I хавсралтыг 1947 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр соёрхон баталсан.

[НҮБ-ын системийн нийт байгууллагууд](#)²²: Монгол Улсын Засгийн газарт үзүүлэх туслалцааг НҮБ-ын системийн тухайн байгууллагын удирдлагын бүтцийн холбогдох болон зохих тогтоол, шийдвэрт үндэслэн үзүүлэх, хүлээн авах боломжтой.


Энэхүү [ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ](#) -г НҮБ-ын системийн байгууллага тус бүртэй гарын үсэг зурж байгаатай холбогдуулан НҮБ-ын системийн байгууллага, Хүлээн авагч улсын Засгийн газрын хооронд байгуулсан үндсэн хэлэлцээрт нийцүүлэн, түүний дагуу тайлбарлаж, хэрэгжүүлнэ.

Харилцааны үндэслэл хэсэгт заасан хамтын ажиллагаа, туслалцааны тухай хэлэлцээрийн заалтын дагуу Засгийн газар хүлээсэн үүргээ биелүүлнэ.

Засгийн газар эдгээр хэлэлцээрийн заалтыг дагаж мөрдөхийн зэрэгцээ Нэгдсэн Үндэстний Байгууллагын давуу эрх, халдашгүй байдлын тухай конвенц ("Ерөнхий конвенц") буюу Мэргэжлийн байгууллагуудын давуу эрх, халдашгүй байдлын тухай конвенц ("Мэргэжлийн байгууллагуудын тухай конвенц")-ийн холбогдох заалтууд нь байгууллагуудын өмч, санхүүжилт, хөрөнгө болон тэдгээрийн албан тушаалтан, томилолтоор ажиллаж буй мэргэжилтнүүдэд нэгэн адил үйлчилнэ. Засгийн газар нь байгууллагууд болон тэдгээрийн албан тушаалтан, тухайн байгууллагуудын нэрийн өмнөөс үйлчилгээ үзүүлж буй бусад хүмүүс, байгууллагуудад, Засгийн газар хоорондын хамтын ажиллагаа, тусламжийн хэлэлцээрт заасан эрх ямба, халдашгүй байдал, хөнгөлөлт эдлүүлнэ. Нэгдсэн Үндэстний Байгууллагын нийт сайн дурын ажилтнуудыг Ерөнхий конвенц буюу Мэргэжлийн байгууллагуудын тухай конвенцид заасан давуу эрх, халдашгүй байдлыг эдлэх эрх бүхий байгууллагуудын албан тушаалтнуудтай адилтган авч үзнэ. Аль нэг байгууллага, тэдгээрийн албан тушаалтан, томилолтоор ажиллаж байгаа мэргэжилтнүүд болон тэдний нэрийн өмнөөс үйлчилгээ үзүүлж буй бусад хүмүүсийн эсрэг гуравдагч этгээдээс гаргасан нэхэмжлэлийг Засгийн газар хариуцахын зэрэгцээ хамтын ажиллагаа, тусламжийн хэлэлцээрийн дагуу явуулж буй үйл ажиллагааны эсрэг аливаа нэхэмжлэл, хариуцлагаас хамгаална.

Хамтын ажиллагаа, тусламжийн хэлэлцээрийн дагуу хэрэгжүүлж буй үйл ажиллагаанаас бусад тохиолдолд үүссэн аливаа нэхэмжлэл, үүрэг хариуцлага, мөн Засгийн газар болон байгууллага хооронд харилцан тохиролцоноос гадуур тухайн байгууллага, түүний албан тушаалтан, зөвлөх, тэдний нэрийн өмнөөс үйлчилгээ үзүүлж буй хүмүүсийн хайхрамжгүй байдал, буруутай үйл ажиллагаанаас үүссэн аливаа нэхэмжлэл, үүрэг хариуцлага үүнд хамаарахгүй.

²² ОУХТ, ОУЦХБ, НҮБ-ын ДОХ-ын НХ, НҮБ-ын ХХБХ, НҮБ-ын ГЭББ, НҮБ-ын БОХ, АНДЭЗНК, НҮБ-ын МБГХТА, НҮБ-ын ТҮА, НҮБ-ын СДХ, НҮБ-ын Эмэгтэйчүүд.



Засгийн газар нь дээр дурдсан нийтлэг заалтыг дагаж мөрдөхийн зэрэгцээ байгууллагуудаас хангаж, Засгийн газрын хяналт, ашиглалтад байгаа тээврийн хэрэгсэлд тухайн улсын хууль тогтоомжийн дагуу хариуцлагын даатгал хийлгэх буюу нөхөн төлбөр төлөх үүрэг хүлээнэ.

- (a) “Энэхүү Гэрээнд заасан аль ч зүйл нь НҮБ болон түүний системийн аливаа агентлаг, байгууллага эдэлж буй давуу эрх, халдашгүй байдлаасаа татгалзах, эсхүл энэхүү Гэрээнээс үүссэн маргааныг шийдвэрлэх аливаа улсын шүүхийн харьяаллыг хүлээн зөвшөөрөх үндэслэл болохгүй”.
- (b) Нэгдсэн Үндэстний Байгууллагын 1946 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн Давуу эрх, халдашгүй байдлын тухай конвенц, НҮБ-ын 1947 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн Мэргэжлийн байгууллагуудын давуу эрх, халдашгүй байдлын тухай конвенц зэрэгт тусгасан эсэхээс үл хамааран энэхүү баримт бичигт хамаарах болон холбогдох зүйл нь НҮБ болон түүний системийн байгууллагууд, түүний дотор Дэлхийн хүнсний хөтөлбөр зэргийг эрх ямба, халдашгүй байдлын эрхээс шууд буюу далд хэлбэрээр татгалзсан гэж үзэхгүй бөгөөд энэхүү баримт бичиг, аливаа байгууллагын гэрээ, үүрэг хариуцлагын ямар ч заалтыг тэдгээрийн давуу эрх, халдашгүй байдалтай үл нийцэх байдлаар тайлбарлах болон хэрэглэхийг хориглоно.

ХАВСРАЛТ 3:

ХӨТӨЛБӨР, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Хөтөлбөрийн хэрэгжилт

Энэхүү хөтөлбөр нь Монгол Улсын Гадаад харилцааны яамны ерөнхий удирдлага, зохицуулалт дор үндэсний хэмжээнд хэрэгжинэ. Хөтөлбөрийн үйл ажиллагааг төрийн яамд, байгууллагууд, төрийн бус байгууллагууд, олон улсын төрийн бус байгууллагууд, НҮБ-ын системийн байгууллагууд хамтран хэрэгжүүлнэ. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ²³ нь Хамтарсан ажлын төлөвлөгөө(нүүд)²⁴ - ний дагуу хэрэгжих буюу шаардлагатай гэж үзвэл тодорхой үр дүн гаргахаар зорьж байгаа байгууллагын ажлын төлөвлөгөө, төслийн баримт бичгүүдийн дагуу хэрэгжих бөгөөд НҮБ-ын системийн байгууллагууд болон хэрэгжүүлэгч байгууллага бүр харилцан гэрээ хийж, хөрөнгийн ашиглалтыг баталгаажуулсан байна. НҮБ-ын системийн байгууллагууд болон оролцогч талууд нь гарын үсэг зурж баталгаажуулсан ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ, гарын үсэг зурж баталгаажуулсан хамтарсан буюу байгууллагын ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх төслийн баримт бичгүүд зэргээс өөрөөр нэмэлт олон баримт бичиг ашиглахаас аль болох татгалзана. Харин шаардлагатай, ач холбогдолтой гэж үзвэл ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ, хамтарсан буюу байгууллагын ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх төслийн баримт бичгүүдээс ишлэл авч төслийн баримт бичиг шинээр боловсруулж болно²⁵.

Томилолтын зардал

Томилолт, тэтгэлэг, урамшуулал болон бусад зардалд зориулах төсвийн тооцоог хийхдээ тухайн улсад хэрэглэгдэж буй үнийн саналыг жишиг болгоно. Гэхдээ НҮБ-ын системд мөрдөгдөж буй зардлын ангилалд тогтоосон хэмжээнээс хэтрэхгүй байхаар тогтооно (ICSC ангиллыг баримтална).

Бэлэн мөнгө шилжүүлэхэд мөрдөх журам

НҮБ болон Монгол Улсын Засгийн газар нь шаардлагатай тохиолдолд бэлэн мөнгөний шилжүүлэг хийхэд мөрдөх журам (НАСТ)-ыг хэрэгжүүлэх үйл явцыг хэдийнээ эхлүүлсэн болно. Дараах заалтууд нь төсөл хөтөлбөрийн хэрэгжүүлэгч талуудад шууд бэлэн мөнгөний шилжүүлэг хийдэг НҮБ-ын Хүүхдийн сан, НҮБ-ын Хүн амын сан, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр зэрэг НҮБ-ын системийн байгууллагуудад хамаатай.

Хэрэгжүүлэгч талуудад шилжүүлэх бэлэн мөнгөний бүх гүйлгээг хийхдээ Хэрэгжүүлэгч тал болон НҮБ-ын системийн байгууллагуудын харилцан баталсан Ажлын төлөвлөгөөнд²⁶ үндэслэнэ.

НҮБ-ын системийн байгууллагууд нь Ажлын төлөвлөгөөнд тусгасан үйл ажиллагаанд зарцуулах бэлэн мөнгөний шилжүүлгийг хийхдээ дараах журмыг мөрдлөг болгоно. Үүнд:

1. Хэрэгжүүлэгч байгууллага руу шууд бэлэн мөнгө шилжүүлэх:
 - a. Үйл ажиллагаа эхлэхийн өмнө (шууд бэлэн мөнгө шилжүүлэх), буюу
 - b. Үйл ажиллагаа дууссаны дараа (нөхөн төлбөр) олгох.

²³ НҮБ-ын Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээ (2023-2027 он)

²⁴ Улс орнуудад зориулсан "Нэгдэн ажиллах" арга хандлагыг мөрдөх талаарх НҮБ-ын ТХЗ-ын хөтөлбөрийн стандарт үйл ажиллагааны журам (SOPs)-ын дагуу

²⁵ НҮБ-ын ХХ-ийн хувьд Засгийн газрын зохицуулагч байгууллагаас НҮБХХ-ийн санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэх төсөл бүрийг шууд хариуцан хэрэгжүүлэх засгийн газрын байгууллагыг томилно. "Хэрэгжүүлэгч байгууллага (ууд)" гэдэг нь ТТҮЖХ/SBAA-д заасан "Гүйцэтгэгч байгууллага (ууд)" юм. Ажлын төлөвлөгөөнд олон тооны хэрэгжүүлэгч тал орсон тохиолдолд, тэдгээр хэрэгжүүлэгч талуудыг удирдан зохицуулах, хөтөлбөрийн үйл ажиллагаа болон санхүүжилтэд ерөнхийд нь хяналт тавих үүрэг хүлээх Үндсэн хэрэгжүүлэгч байгууллагыг тодорхойлж хөтөлбөрийн төлөвлөгөөт үйл ажиллагаа бүрийг уялдаа холбоотойгоор үр дүнтэй хэрэгжүүлнэ.

²⁶ Үр дүнгийн бүлгүүдийн болон системийн байгууллагуудын жил, хоёр жил, олон жилийн ажлын төлөвлөгөө

2. Хэрэгжүүлэгч байгууллагын томилогдсон албан тушаалтны гарын үсэг зурж баталгаажуулсан хүсэлтийг үндэслэн, хэрэгжүүлэгч байгууллагын хүлээсэн үүргийг гүйцэтгэсэн ханган нийлүүлэгчид буюу гуравдагч этгээдэд шууд төлбөр хийх;
3. Хэрэгжүүлэгч байгууллагатай тохиролцсон үйл ажиллагааг дэмжих зорилгоор НҮБ-ын системийн байгууллагуудын хүлээсэн үүргийг гүйцэтгэсэн ханган нийлүүлэгч буюу гуравдагч этгээдэд шууд төлбөр хийх.

Бэлэн мөнгөний шууд төлбөр тооцоо нь хөтөлбөрийн гурван сараас илүүгүй хугацаанд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хамаарна. Өмнө нь зөвшөөрөгдсөн зардлын нөхөн төлбөрийг улирал тутамд буюу тухайн үйл ажиллагаа дууссаны дараа нэхэмжилж, холбогдох төлбөрийг хийнэ.

Зөвшөөрөгдсөн хэмжээнээс илүү гаргасан хэрэгжүүлэгч байгууллагын зардлыг НҮБ-ын системийн байгууллагууд нөхөн төлөх үүрэг хүлээхгүй. Аливаа үйл ажиллагаа дууссаны дараа үлдэгдэл хөрөнгийг буцаан шилжүүлэх буюу хөтөлбөрийн үйл ажиллагаанд дахин хуваарилах эсэхийг хэрэгжүүлэгч байгууллага болон НҮБ-ын системийн байгууллагууд харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэнэ.

Бэлэн мөнгө шилжүүлэх журам, зарцуулалтын хэмжээ, баталгаажуулах үйл ажиллагааны цар хүрээ, давтамж нь Засгийн газрын хэрэгжүүлэгч байгууллагын төрийн санхүүгийн удирдлагын чадавхад хийсэн үнэлгээний үр дүн, НҮБ-ын бус²⁷ Хэрэгжүүлэгч байгууллагын санхүүгийн удирдлагын чадавхын үнэлгээ зэргээс хамаарч болно. Ийм үнэлгээг НҮБ-ын системийн байгууллагуудын сонгосон нягтлан бодох бүртгэлийн төрийн компани зэрэг мэргэшсэн зөвлөхүүд хийж болох бөгөөд үүнд хэрэгжүүлэгч байгууллага мөн оролцоно. Зөвлөхийг сонгон шалгаруулахад Хэрэгжүүлэгч байгууллага оролцож болно.

Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, зарцуулалтын хяналт шалгалт, тайлагнал, аудитын дүгнэлтэд үндэслэн хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад бэлэн мөнгө шилжүүлэх журам, зарцуулалтын хэмжээ, баталгаажуулах үйл ажиллагааны цар хүрээ, давтамжийг шинэчлэн тогтоож болно.

Бэлэн мөнгө шууд шилжүүлэх буюу нөхөн төлбөр хийх тохиолдолд НҮБ-ын системийн байгууллагууд нь санхүүжилтийн батлагдсан дүнг хэрэгжүүлэгч байгууллагад мэдэгдэх бөгөөд төлбөрийг 30 хоногийн дотор хэрэгжүүлэгч байгууллагад шилжүүлнэ.

Хэрэгжүүлэгч байгууллагын томилогдсон албан тушаалтны гарын үсэг зурж баталгаажуулсан хүсэлтийг үндэслэн, хэрэгжүүлэгч байгууллагын хүлээсэн үүргээ гүйцэтгэсний төлбөрийг ханган нийлүүлэгч буюу гуравдагч этгээдэд шууд шилжүүлэх тохиолдолд; мөн НҮБ-ын системийн байгууллагуудын хэрэгжүүлэгч байгууллагуудтай тохиролцсон үйл ажиллагааг дэмжихэд хүлээсэн үүргээ гүйцэтгэсний төлбөрийг ханган нийлүүлэгч буюу гуравдагч этгээдэд шилжүүлэх тохиолдолд төлбөрийг 30 хоногийн дотор тус тус шилжүүлнэ.

Хэрэгжүүлэгч байгууллагууд болон гуравдагч ханган нийлүүлэгчдийн хооронд байгуулсан гэрээний дагуу НҮБ-ын системийн байгууллагууд ямар нэгэн шууд хариуцлага хүлээхгүй.

НҮБ-ын системийн болон бусад байгууллага нь нэг хэрэгжүүлэгч байгууллага руу бэлэн мөнгө шилжүүлж буй тохиолдолд тэдгээр НҮБ-ын системийн байгууллагатай холбогдож, хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, санхүүгийн хяналт шалгалт, аудитыг хамтран зохион байгуулна.

Батлагдсан ажлын төлөвлөгөөний дагуу Хэрэгжүүлэгч байгууллага нь бэлэн мөнгөний урьдчилгаа авах, шууд болон нөхөн төлбөр хийлгэх хүсэлтийг батлагдсан төсөв, санхүүжилтийн стандарт FACE маягтаар гаргаж санхүүжүүлэгч байгууллага руу илгээх бөгөөд [НҮБ-ын байгууллага] нь төлөвлөгөөт үйл ажиллагаанд зориулсан нөхөн болон шууд төлбөрийг батлагдсан төсөв, төлөвлөгөөг үндэслэн гүйцэтгэнэ.

²⁷ Энэ заалтын "НҮБ"-ын гэдэгт ОУСБ-ууд хамаарна

Хэрэгжүүлэгч байгууллага нь хөрөнгийн зарцуулалтын тайланг Батлагдсан төсөв, санхүүжилтийн стандарт FACE маягтаар гаргаж тайлагнана. Хэрэгжүүлэгч байгууллага нь төсөв санхүү, банкны харилцах данс, санхүүжилтийн хүсэлт гаргах, баталгаажуулах эрх бүхий албан тушаалтныг томилно. Батлагдсан төсөв, санхүүжилтийн стандарт FACE маягтаар гаргасан хүсэлтийг хэрэгжүүлэгч байгууллагын томилсон эрх бүхий албан тушаалтан (ууд) баталгаажуулсан байна.

Хэрэгжүүлэгч байгууллагад шилжүүлсэн бэлэн мөнгөний санхүүжилтийг зөвхөн батлагдсан ажлын төлөвлөгөөнд орсон үйл ажиллагаанд тогтоосон цаг хугацаанд нь зарцуулна.

Хэрэгжүүлэгч байгууллага нь Засгийн газар, үндэсний төрийн бус байгууллага бол хүлээн авсан бэлэн мөнгөний санхүүжилтийг олон улсын стандартад нийцсэн үндэсний бодлого, хууль тогтоомжийн дагуу зөвхөн батлагдсан ажлын төлөвлөгөөнд орсон үйл ажиллагаанд товлосон хугацаанд нь бүрэн зарцуулах бөгөөд зарцуулалтын тайлангаа санхүүжилт хүлээн авснаас хойш зургаан сарын дотор [НҮБ-ын байгууллага]-д хүргүүлсэн байна. Үндэсний хууль тогтоомж нь олон улсын стандартад нийцээгүй бол НҮБ-ын системийн байгууллагын санхүүгийн болон холбогдох бодлого, дүрэм журмыг мөрдөнө.

Хэрэгжүүлэгч байгууллага нь олон улсын төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллага, олон улсын төрийн байгууллага бол бэлэн мөнгөний санхүүжилтийг олон улсын стандартад нийцүүлэн, зөвхөн батлагдсан ажлын төлөвлөгөөнд орсон үйл ажиллагаанд бүрэн зарцуулах бөгөөд санхүүжилтийн гүйцэтгэлийн тайланг санхүүжилтийг хүлээн авснаас хойш зургаан сарын дотор [НҮБ-ын байгууллага]-д хүргүүлсэн байна.

Төлөвлөгөөт болон тусгайлсан аудит оруулах ажлыг хөнгөвчлөхийн тулд [НҮБ-ын байгууллага]-аас бэлэн мөнгөний санхүүжилт авч буй хэрэгжүүлэгч байгууллагуудад дараах асуудлаар НҮБ-ын системийн байгууллагууд болон тэдгээрийн төлөөлөл саадгүй нэвтэрч, хяналт тавих боломжийг олгосон байна. Үүнд:

- [НҮБ-ын системийн байгууллага]-аас олгосон бэлэн мөнгөний санхүүжилттэй холбоотой санхүүгийн бүх бүртгэл, тооцоо, гүйлгээний мэдээлэл, холбогдох баримт бичгүүд;
- Бэлэн мөнгөний санхүүжилт хүлээн авсан хэрэгжүүлэгч байгууллагын дотоод хяналтын бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой бүх холбогдох бичиг баримт, ажилтнуудтай танилцах, хяналт тавих;

Аудитын үнэлгээ бүрийн үр дүн, тайлантай хэрэгжүүлэгч байгууллага болон [НҮБ-ын байгууллага] сайтар танилцсан байна. Хэрэгжүүлэгч байгууллага бүр дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

- Аудиторуудын бэлтгэсэн аудитын тайлантай танилцах, хянаж үзэх.
- Аудитын үнэлгээнээс гарсан дүгнэлт, зөвлөмжийг хүлээн зөвшөөрөх, аль эсвэл татгалзах тухай мэдэгдлээ бэлэн мөнгөний (Аудитын дээд байгууллагаас аудит хийхээр шийдвэрлэсэн, аль эсвэл Аудитын дээд байгууллагад аудит хийлгэхээр хандсан) санхүүжилт хийсэн [НҮБ-ын байгууллага]-д цаг алдалгүй хүргүүлнэ. Ингэснээр аудиторууд дээрх мэдэгдлийг аудитын эцсийн тайланд хавсарган [НҮБ-ын байгууллага]-д хүргүүлэх боломж бүрдэнэ.
- Хүлээн зөвшөөрч байгаа аудитын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг цаг тухайд нь авах.

Аудитын хүлээн зөвшөөрсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх чиглэлээр авсан арга хэмжээний талаар улирал тутам (тохиролцсон цаг хугацаанд) НҮБ-ын системийн байгууллагуудад (Аудитын дээд байгууллагаас аудит хийхээр шийдвэрлэсэн, эсхүл тухайн байгууллагад аудит хийлгэхээр хандсан) (эсхүл тухайн түвшинд тохиролцсоны дагуу) тайлагнана.

Санхүүгийн баталгаажуулалт болон аудит

Аудитын дээд байгууллага нь Засгийн газрын хэрэгжүүлэгч байгууллагуудад аудитын шалгалт оруулж болно. Хэрэв Аудитын дээд байгууллага нь НҮБ-ын системийн байгууллагуудын санал болгосон давтамж, хамрах хүрээний дагуу тодорхой хэрэгжүүлэгч байгууллагуудад аудитын шалгалт оруулах төлөвлөгөөгүй тохиолдолд НҮБ-ын системийн байгууллагууд хувийн хэвшлийн аудитын үйлчилгээг авах боломжтой байна²⁸.

Хөрөнгө, нөөц дайчлах стратеги

НҮБ-ын системийн байгууллагууд нь техникийн туслалцаа, мөнгөн тусламж, ханган нийлүүлэлт, бараа бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж, худалдан авалтын үйлчилгээ, тээвэр, нөлөөлөл сурталчилгааны ажлын санхүүжилт, судалгаа шинжилгээ, зөвлөх үйлчилгээ, хөтөлбөр боловсруулалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ, сургалтын үйл ажиллагаа, хүний нөөц зэрэг олон хэлбэрээр тус хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлон хэрэгжүүлэхэд чиглэсэн дэмжлэгийг үзүүлнэ. Тус хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх тусгайлсан ажлын төлөвлөгөө, төслийн баримт бичгийг талуудтай тохиролцон батлах замаар НҮБ-ын системийн байгууллагуудын дэмжлэгийн зарим хэсгийг төрийн бус [болон иргэний нийгмийн] байгууллагуудад чиглүүлнэ.


Нэмэлт дэмжлэгийг НҮБ-ын системийн байгууллагын удирдлага бүхий олон улсын мэдээллийн системүүд, улс орнууд дахь НҮБ-ын системийн байгууллагуудын сүлжээд, мэргэшсэн мэдээллийн системүүд, түүний дотор зөвлөхүүдийн болоод хөгжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн нөөцийн бүртгэл, НҮБ-ын системийн мэргэжлийн байгууллагуудын сүлжээд, сан, хөтөлбөрүүд зэргээс авах боломжтой. НҮБ-ын системийн байгууллагууд нь хөтөлбөр боловсруулалт, хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих үйлчилгээ, техникийн туслалцаа, хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаа зэрэг асуудал хариуцсан ажилтан, зөвлөхүүдийг томилно.

Хамтын ажиллагааны хүрээг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу НҮБ-ын системийн байгууллагуудын санхүүгийн эх үүсвэрүүдээс төвлөрүүлэх төсвийн хуваарилалтыг хуанлийн жилээр хийх бөгөөд хөтөлбөрийн хэрэгжилтийг жил тутамд дүгнэнэ. Эдгээр төсвийн хуваарилалтыг ажлын төлөвлөгөө, төслийн баримт бичигт дэлгэрэнгүй тусгасан байна. Монгол Улсын Засгийн газар болон НҮБ-ын хөгжлийн системийн байгууллагуудын харилцан тохиролцсоны үндсэн дээр НҮБ-ын хөгжлийн системийн байгууллагуудаас хэрэгжүүлж байгаа тодорхой үйл ажиллагаанд зориулагдаагүй хандивлагчдын хөрөнгийг хөтөлбөрийн хувьд ач холбогдол бүхий бусад арга хэмжээнд дахин хуваарилж болно.

Хяналт шинжилгээ, үнэлгээ

НҮБ-ын системийн байгууллагуудын бэлэн мөнгөний шилжүүлгээр дэмжигдсэн бүх үйл ажиллагаанд НҮБ-аас хяналт шалгалт хийхэд нь Хэрэгжүүлэгч байгууллагуудын зүгээс хамтран ажиллаж НҮБ-ын системийн байгууллагуудаас олгосон бэлэн мөнгөний гүйлгээтэй холбоотой санхүүгийн бүртгэлийг шалгах, хариуцсан ажилтнуудтай хамтран ажиллах боломжийг бүрэн олгоно.

²⁸ Өмнөд-Өмнөдийн хамтын ажиллагааны үүднээс авч үзэхэд, Чадавхын үнэлгээ хийх явцад тухайн улс орноос бусад хөгжиж буй орнуудад шилжүүлэн ашиглах чадавх, нөөц байгаа эсэх, түүнчлэн бусад хөгжиж буй орнуудаас авч хэрэгжүүлэх боломжтой чадавх нөөцийг тодорхойлох боломжтой. НҮБ-ын ХХ-ийн хувьд төрийн бус байгууллага болон үндэсний байгууллага хэрэгжүүлж байгаа төслүүдийн үйл ажиллагаанд оруулах аудитын шалгалтыг зөвхөн хараат бусаар ажиллах чадвартай гэдгээ баталсан нөхцөлд Аудитын дээд байгууллагад даатгах боломжтой. Үүний тулд Аудит, хяналт шалгалтын алба (ОА) дотоод цахим хуудастаа аудитын дээд байгууллагуудад үнэлгээ хийх зааварчилгааг зохих асуумжийн хамт нийтэлсэн байдаг. Асуумжийг бөглөж, гарын үсэг зурж баталгаажуулан Аудитын дээд байгууллагад мэдээлсэн байх шаардлагатай. Мөн Аудитын дээд байгууллагаар аудит хийлгэхээс өмнө магадлан шинжилгээг заавал хийсэн байвал зохино. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг Аудит, хяналт шалгалтыг албаны интернет хуудсаас авна уу.



Ингэхдээ хэрэгжүүлэгч байгууллагууд дараах үйл ажиллагааг зөвшөөрч, хамтран ажиллана. Үүнд:

1. НҮБ-ын системийн байгууллагуудтай байгуулсан хамтын ажиллагааны баримт бичиг/гэрээний холбогдох заалтын дагуу НҮБ-ын системийн байгууллагууд, тэдгээрийн төлөөллүүд санхүүгийн бүртгэл тайлантай газар дээр нь танилцах төлөвлөгөөт болон гэнэтийн шалгалт хийх
2. Хөтөлбөрийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцах, хяналт-шинжилгээ хийхэд баримтлах НҮБ-ын системийн байгууллагуудын стандарт, удирдамжийн дагуу хөтөлбөрийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх

Тусгайлсан буюу төлөвлөгөөт аудитын шалгалт. НҮБ-ын системийн байгууллага бүр НҮБ-ын системийн бусад байгууллагатай хамтран (холбогдох зохицуулагч яамтай зөвшилцсөний үндсэн дээр) аудитын шалгалтын жилийн төлөвлөгөө батлах замаар НҮБ-ын системийн байгууллагуудаас их хэмжээний мөнгөн тусламж авч буй болон санхүүгийн удирдлагын чадавхыг нь бэхжүүлэх шаардлагатай хэрэгжүүлэгч байгууллагуудад эн тэргүүнд аудитын шалгалт хийнэ.

